



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-58
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	59-110
<hr/>	
1. Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/	62
2. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/	62-82
3. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	82-86
4. Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/	86-92
5. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/	92-97
6. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	97-98
7. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа нарын 4 гишүүн 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	98-99
8. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нарын 6 гишүүн 2024.05.17-ны өдөр мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг /	99-100
9. “Монгол Улсын Ерөнхий аудитор томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	101-104
10. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	104-106
11. “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	106-108
12. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 4 гишүүн 2024.05.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	108-110
13. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	110

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 34 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Б.Бейсен, Б.Саранчимэг;

Чөлөөтэй: П.Анужин, Ё.Баатарбилэг, Д.Батлут, Ж.Батсуурь, Ж.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Н.Ганибал, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан, Г.Мөнхцэцэг, Л.Оюун-Эрдэнэ, Д.Өнөрболор, Ц.Туваан, Б.Чойжилсүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Г.Амартүвшин, С.Батболд, Ш.Раднаасэд;

Хоцорсон: С.Амарсайхан -1 цаг 15 минут, Э.Батиугар -3 цаг 15 минут, Б.Бат-Эрдэнэ -06 минут, М.Оюунчимэг -24 минут, Д.Цогтбаатар -05 минут, Ц.Цэрэнпунцаг -50 минут, Б.Энхбаяр -34 минут, Т.Энхтүвшин -22 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Ганбат нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Ганбат нар үг хэлэв.

Нэг.Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Баярбат оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат байлцав.

Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Баярмаа, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, мөн яамны Хөгжлийн бодлого төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч Д.Бэлэгсайхан, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Б.Төрбат, Сэлэнгэ аймгийн Бугант тосгоны захирагч Д.Эрдэнэбулган, мөн аймгийн Дулаанхаан тосгоны захирагч Ж.Ганболд, Булган аймгийн Хялганат тосгоны захирагч А.Сод-Эрдэнэ, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын ахлах мэргэжилтэн Д.Баялагцэнгэл, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын мэргэжилтэн С.Энхжаргал, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах хорооны Ажлын албаны дарга ахлах шинжээч Ц.Батгэрэл, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр, мөн захиргааны Ерөнхий менежер Б.Гүнболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Л.Батмөнх, Б.Баярмаа, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолоор санал хураалт явуулав.

Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Э.Бат-Амгалан, Ж.Батжаргал, Б.Баттөмөр, Г.Дамдинням, Т.Доржханд, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Г.Тэмүүлэн /цаашид

“Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Нийслэл Улаанбаатар хот, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны тухайлан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “оршин суугчтай,” гэсний дараа “эсхүл байнгын оршин суугчтай байхаар төлөвлөсөн,” гэж нэмж, 4.3 дахь хэсгийн “эдийн засаг, нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, хэрэгжүүлэх” гэснийг “болон бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, газар зүйн байршил,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дангаараа” гэснийг “нэг” гэж, 5.5 дахь хэсгийн “энэ хуулийн 5.2-т заасныг” гэснийг “тосгоны оноосон нэр, эдэлбэр газрын хэмжээ, байршил, заагийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.1.9, 6.1.10, 6.1.11 дэх заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“6.1.9.төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих;

6.1.10.алслагдсан хот, тосгонд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх;

6.1.11.хот, тосгоны зохион байгуулалт, тэдгээрийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, хотын зэрэглэл тогтоохтой холбоотой шийдвэр гаргахад их өгөгдлийн тооцоололд суурилах, дэвшилтэт технологийг ашиглах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41

63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн, 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсгийн “Хотын” гэснийг “Хот, тосгоны” гэж, 3 дугаар бүлгийн болон 14 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 14.1 дэх хэсгийн, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн, мөн зүйлийн 17.7 дахь хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж өөрчилж, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг бүхэлд нь, 18 дугаар зүйлийн гарчгийн “Улсын зэрэглэлтэй хотын” гэснийг, 18.2 дахь хэсгийн “хотын” гэснийг тус тус хасаж, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, дугаарлалтыг өөрчлөх:

“10.2.Тосгоны удирдлага дараах тогтолцоотой байна:

10.2.1.тосгоны Зөвлөл;

10.2.2.тосгоны Захирагч.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 14

Бүгд: 41

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн “хотын хороо” гэснийг “хотын хороолол” гэж өөрчилж, төслийн бусад зүйл, хэсэг, заалтын “хотын хороо” гэснийг “хотын хороолол” гэж тохиолдол бүрд агуулгад нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 16

Бүгд: 41

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 14 дүгээр зүйл нэмэх:

“14 дүгээр зүйл.Хот, тосгоны хөгжлийг дэмжихэд харилцаа холбоо, мэдээллийн технологи ашиглах

14.1.Хот, тосгоны удирдлага нь хот, тосгоны чиг үүргийг хэрэгжүүлэхэд харилцаа холбоо, мэдээллийн технологийг дараах хэлбэрээр ашиглана:

14.1.1.инновац, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, юмсын интернэт зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;

14.1.1.2.шийдвэр гаргахаас өмнө тухайн шийдвэрийг цахим орчинд урьдчилан загварчилж, үр дүнг тооцоолох;

14.1.3.дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд зохицуулалтын сэндрокс орчинд туршиж, оршин суугчийн саналыг авах;

14.1.4. харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд бүтэц, мэдээллийн системийг бий болгох, түүний тасралтгүй, найдвартай байдал болон кибер аюулгүй байдлыг хангах, саадгүй мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх;

14.1.5. хотод цугларсан мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл болгон, олон нийтэд ил тод байршуулах.

14.2. Энэ хуулийн 14.1.3-т заасан зохицуулалтын сэндрокс орчныг бий болгох, үйл ажиллагаа явуулах журмыг Засгийн газар батална.

14.3. Хот, тосгон нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасан шаардлагыг хангасан мэдээллийн систем, түүний дэд бүтцийг ашиглана.

Тайлбар: - Энэ зүйлд заасан “юмсын интернэт” гэж эд зүйлсийг цахим орчинд хянах, удирдах зорилгоор өгөгдлийг цуглуулж, дамжуулах зориулалт бүхий мэдрэгч болон бусад төхөөрөмж, программ хангамж, тэдгээрийг хооронд нь холбосон сүлжээг ойлгоно.

-Энэ зүйлд заасан “зохицуулалтын сэндрокс орчин” гэж шинээр нэвтэрч байгаа технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчин, тодорхой цаг хугацаанд туршихыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 14

Бүгд: 43

67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

8. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.6 дахь хэсэг нэмэх:

“14.6. Тосгоны Зөвлөлийн гишүүнийг оршин суугчдаас сонгох ба Зөвлөлийн гишүүний тоо 9 байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 13

Бүгд: 43

69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Зөвлөл” гэсний өмнө “Хотын” гэж нэмж, 15.3, 15.4 дэх хэсгийн “Зөвлөлийн” гэсний өмнөх “Хотын” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 15.3 дахь хэсэг нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“15.3. Тосгоны Зөвлөл энэ хуулийн 15.1.4-т заасан албан татварын хувь хэмжээг тогтоохоос болон 15.1.8-д зааснаас бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 14

Бүгд: 43

67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.3.2 дахь заалтын “улсын зэрэглэлтэй хотын Захирагч” гэсний дараа “, тосгоны Зөвлөлийг харьяалах сум, дүүргийн Засаг дарга, эсхүл орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагч” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 17

Бүгд: 43

60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “буюу” гэснийг “, эсхүл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 21

Бүгд: 43

51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “24.1.4,” гэснийг, “хотын” гэснийг тус тус хасаж, мөн хэсгийн “шийдвэрлэнэ” гэснийг “шийдвэрлэх ба 24.1.4-т заасан тохиолдолд огцорсонд тооцно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 14

Бүгд: 43

67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийн “томилно” гэснийг “томилж, чөлөөлнө” гэж, мөн зүйлийн 28.9 дэх хэсгийн “Хотын” гэснийг “Хот, тосгоны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 16

Бүгд: 43

62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1.51 дэх заалтыг бүхэлд нь, 29.1.3 дахь заалтын “энэ хуулийн 29.1.2-т заасан асуудлаар” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 15

Бүгд: 43

65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1.45 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 14
Бүгд: 43
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “, 30.1.4-д заасан тохиолдолд огцруулах” гэснийг, 30.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 10.2-т зааснаас бусад” гэснийг хасаж, 30.3 дахь хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгон, хотын хорооны” гэж өөрчилж, 30.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 30.7 дахь хэсэг болгох:

“30.7.Гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон тохиолдолд хот, тосгон, хотын хорооны захирагчийг огцорсонд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 16
Бүгд: 43
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “хотын Захирагчийг дээд шатны Захирагч, Засаг дарга, эсхүл Ерөнхий сайд” гэснийг “улсын зэрэглэлтэй хотын Захирагчийг Ерөнхий сайд, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагчийг харьяалах дээд шатны Захирагч, эсхүл Засаг дарга” гэж, 31.1.4 дэх заалтын “зохих ёсоор” гэснийг “удаа дараа” гэж өөрчилж, 31.1 дэх хэсгийг 30.4 дэх хэсэг болгон шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 16
Бүгд: 43
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1.4, 31.1.5, 31.1.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг болгох:

“30.5.Хотын хорооны захирагчийг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө хотын захирагч энэ хуулийн 30.1.2, 30.1.3, 30.1.5-д заасан үндэслэлээр чөлөөлж, 31.1.1, 31.1.4, 31.1.5, 31.1.6-д заасан үндэслэлээр огцруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 15
Бүгд: 43
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 33.2, 33.3 дахь хэсэг нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“33.2.Хотын хорооны Захирагчийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

33.3.Хотын хорооны Захирагчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон бол шинээр сонгогдох Захирагчийн бүрэн эрхийн хугацаа нь өмнөх Захирагчийн бүрэн эрхийн үлдсэн хугацаатай тэнцүү байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 17
Бүгд: 44
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийн “Тосгоны Захирагчаар дараах шаардлагыг хангасан иргэнийг” гэснийг “Тосгоны Захирагчаар дараах шаардлагыг хангасан иргэнийг тухайн тосгоны оршин суугчдаас сонгож,” гэж, “томилно” гэснийг “батламжилна” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 15
Бүгд: 44
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 34.5 дахь хэсэг нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“34.5.Тосгоны Захирагчийн үйл ажиллагааны зардлыг тухайн тосгонд хуваарилсан төсвөөс санхүүжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 18
Бүгд: 44
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 30 дугаар зүйлийн 30.6 дахь хэсэг болгох:

“30.6.Тосгоны захирагчийг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө тухайн тосгоны Зөвлөл энэ хуулийн 30.1.2, 30.1.3, 30.1.5-д заасан үндэслэлээр чөлөөлж, 31.1.1, 31.1.2, 31.1.4, 31.1.5, 31.1.6-д заасан үндэслэлээр огцруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 17
Бүгд: 44
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.7 дахь заалтыг хасаж, 35.1.8 дахь заалтын “санал гаргах,” гэсний дараа “төлөвлөгөөг батлуулах” гэж нэмж, 35.1.2 дахь заалтын “шууд” гэснийг “ерөнхийлөн” гэж, 35.1.20 дахь заалтын “харьяалах сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хотын” гэснийг “тосгоны” гэж, 35.1.28 дахь заалтын “хотын” гэснийг “тосгоны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 18
Бүгд: 44
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 36.3 дахь хэсэг нэмэх:

“36.3.Хот, тосгоныг хөгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа эрхлэхэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх асуудлыг тухайн төрлийн татварын хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 16
Бүгд: 44
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “хот нь аймаг, нийслэлийн, тосгон нь аймгийн” гэснийг “хот болон тосгон нь аймаг, нийслэлийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 14
Бүгд: 44
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийн гарчгийн “Чөлөөт бүс” гэсний дараа “, эдийн засгийн тусгай бүс” гэж нэмж, 40.1 дэх хэсгийн “чөлөөт бүстэй” гэснийг “чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүстэй” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 40.3 дахь хэсэг нэмэх:

“40.3.Хотын эдийн засгийн тусгай бүстэй холбогдох харилцааг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 38-45 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 17
Бүгд: 44
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1.2 дахь заалтын “бохир ус,” гэсний дараа “цэвэрлэх байгууламж,” гэж нэмж, 41.3 дахь хэсгийн “сан байгуулах, түүнийг” гэснийг “сангийн хөрөнгийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 15
Бүгд: 44
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тохиолдол бүрд өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 17
Бүгд: 44
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.3.3 дахь заалтын “засаг захиргааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт, удирдлагын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 15
Бүгд: 44
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсгийн, 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийн “хотын Зөвлөл, тосгоны Захирагч” гэснийг “хот, тосгоны Зөвлөл” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 15
Бүгд: 44
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 17
Бүгд: 44
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр. Найруулгын шинжтэй саналын томьёолол:

Г.Занданшатар: 1. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “тэдгээрийн” гэснийг “хотын” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтын “барилга,” гэснийг “барилгын болон бусад” гэж, 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийн, 23 дугаар зүйлийн 23.1.3 дахь заалтын “хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар” гэснийг “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр” гэж тус тус, 29 дүгээр зүйлийн 29.1.32 дахь заалтын, 35 дугаар зүйлийн 35.1.16 дахь заалтын “нийгэм хамгаалал, халамж, гэснийг “нийгмийн хамгаалал” гэж тус тус, 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсгийн, 19 дүгээр зүйлийн 19.1.8 дахь заалтын, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн, 22 дугаар зүйлийн 22.1.7 дахь заалтын, 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтын, 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тус тус, 17 дугаар зүйлийн 17.8 дахь хэсгийн “хэлэлцүүлэхээр” гэснийг “хэлэлцүүлэх санал” гэж, 17.9 дэх хэсгийн “хоногийн” гэснийг “өдрийн” гэж, 17.10 дахь хэсгийн “хуралдах тохиолдолд” гэснийг “хуралдахад” гэж, 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийн “хэсгийн заалт” гэснийг “зүйл, хэсэг, заалт” гэж, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “заасны дагуу нэр дэвшигчдийн” гэснийг “заасан нууц санал хураалтаар нэр дэвшигчийн” гэж, 20.5 дахь хэсгийн “хүний” гэснийг “нэр дэвшигчийн” гэж, 20.6 дахь хэсгийн “хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн” гэснийг “хангалтгүй биелүүлсэн гэж үзсэн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.5.1 дэх хэсгийн “хотод” гэснийг “хот, тосгонд” гэж, 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтын “хуралд” гэснийг “хуралдаанд” гэж, 22.2.1 дэх заалтын “гомдлыг” гэснийг “гомдолд” гэж, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “Хотыг өдөр тутамд удирдах” гэснийг “Хотын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.48 дахь заалтын, 35 дугаар зүйлийн 35.1.25 дахь заалтын “үйлчилгээг зохион байгуулж байгаад” гэснийг “үйлчилгээний зохион байгуулалтад” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.50 дахь заалтын “хот” гэснийг “хотын” гэж, 29.1.53 дахь заалтын “байгууллага” гэснийг “байгууллагын” гэж, “үүргээ хэрхэн биелүүлж байгаад” гэснийг “үүргийн биелэлтэд” гэж, 29.1.54 дэх заалтын “газарт” гэснийг “газрын хэмжээнд” гэж, 30 дугаар зүйлийн гарчгийн “Хотын” гэснийг “Хот, тосгон, хотын хорооны” гэж, 30.1 дэх хэсгийн “Захирагчийн бүрэн эрх” гэснийг “захирагчийг” гэж, “дуусгавар болно” гэснийг “чөлөөлнө” гэж, 31 дүгээр зүйлийн 31.1.1, 31.1.2 дахь заалтын “хот байгуулалтын” гэснийг “хотын” гэж тус тус, 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтын “хэрэгцээний” гэснийг “хэрэглээний” гэж, 35.1.17 дахь заалтын, 35.1.28 дахь заалтын “хотын” гэснийг “тосгоны” гэж, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “хот” гэснийг “хотын” гэж, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийн “хүмүүст” гэснийг “хүнд” гэж, “хүмүүсийг” гэснийг “хүнийг” гэж өөрчилж, төслийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийг 19 дүгээр зүйлийн 19.1.10 дахь заалт болгон, 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийг 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэг болгон, 30 дугаар зүйлийг 35 дугаар зүйл болгон тус тус шилжүүлэх.

2. Төслийн 15 дугаар зүйлийн 15.3.2 дахь заалтын “хотод” гэснийг, 25 дугаар зүйлийн гарчгийн, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “Хотын” гэснийг тус тус, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалтын “явуулж буй” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.8 дахь хэсгийн “асуудал санаачлан” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийн “хэсгийн” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.5.1 дэх заалтын “оршин суугч” гэснийг, 33 дугаар зүйлийн гарчгийн “, бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох” гэснийг, 33.1.3 дахь заалтын “асуудлаар” гэснийг дараах “захиран зарцуулах” гэснийг, 41 дүгээр зүйлийн 41.1.1 дэх заалтын “болон” гэснийг, 51 дүгээр зүйлийн 51.2.2 дахь заалтын “хот, тосгоны” гэснийг хасах.

3. Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Зөвлөл” гэсний өмнө “хотын” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “гэрээний” гэсний өмнө “нийтийн эрх зүйн” гэж, 28 дугаар зүйлийн 28.6, 28.7 дахь хэсгийн “Захирагчийн” гэсний өмнө, 28.8 дахь хэсгийн “Захирагч” гэсний өмнө “Хотын” гэж тус тус, 43 дугаар зүйлийн гарчгийн “Зөвлөл” гэсний өмнө “Хотын”

гэж, 51 дүгээр зүйлийн 51.2.2 дахь заалтын “Захирагчийн” гэсний өмнө “хот, тосгоны” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 15
Бүгд: 44
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн хүснэгтийн 3 дахь заалтын “Төв аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал” гэснийг “Төв аймгийн Зуунмод сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал” гэж, мөн заалтын “Төв аймгийн засаг дарга” гэснийг “Төв аймгийн Зуунмод сумын засаг дарга” гэж, мөн хүснэгтийн 10 дахь заалтын “Чингэлтэй хот, Сэлбэ хотын Зөвлөл” гэснийг “Чингэлтэй хотын Зөвлөл” гэж, мөн хүснэгтийн 14 дэх заалтын “Баян-Өлгийн аймгийн Засаг дарга” гэснийг “Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Засаг дарга” гэж, мөн хүснэгтийн 15 дахь заалтын “Баянхонгор аймгийн Засаг дарга” гэснийг “Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Засаг дарга” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 14
Бүгд: 43
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Д.Тогтохсүрэн, С.Чинзориг нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн хүснэгтийн хотын нэр баганад “Хархорин хот” гэж, “Хотын Зөвлөл, Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага баганад “Өвөрхангай аймгийн Хархорин сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал”, “Өвөрхангай аймгийн Хархорин сумын Засаг дарга”, гэж, Хотын удирдлага баганад “Хархорин хотын Зөвлөл”, “Хархорин хотын Захирагч” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 15
Бүгд: 44
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/16 дугаар зүйлийн 16.2.11 дэх заалт:

“11. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ байгаль орчин болон байгалийн нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлөхөд шаардагдах хөрөнгийг тухайн төсөл, арга хэмжээний төсөвт тусгуулах.”

2/49 дүгээр зүйлийн 49.9 дэх хэсэг:

“9. Аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлээс хэрэгжүүлж байгаа Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.7, 4.1.8-д заасан үйл ажиллагааг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхөн төлбөрөөс чөлөөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 14
Бүгд: 45
68.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: 1. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 68 дугаар зүйлийн 68.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“68.5. Энэ хуулийн 68.1-д заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын чиг үүргийг шилжүүлсэнтэй холбогдуулан тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төрийн болон орон нутгийн өмчийг хуульд заасны дагуу хот, тосгонд шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 14
Бүгд: 44
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 68 дугаар зүйлийн 68.6 дахь хэсгийн “Хотын зөвлөл” гэснийг “Хот, тосгоны зөвлөл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 16
Бүгд: 44
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.2, 24.3.3 дахь заалтын” гэснийг “24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.2, 24.3.3, 24.3.4 дэх заалт, 24.5 дахь хэсгийн, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 25.4.3 дахь заалтын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 15
Бүгд: 44
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 буюу 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хот, тосгоны эрх зүйн байдлын дагуу байгуулагдсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 13
Бүгд: 44
70.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 буюу 77 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 68.4-т заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрийн удирдлагын чиг үүргийг шилжүүлсэн бол энэ хуульд заасан иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхийг тухайн хот, тосгоны зөвлөл хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 13
Бүгд: 44
70.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3/78 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 68.4-т заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төрийн удирдлагын чиг үүргийг шилжүүлсэн бол энэ хуульд заасан засаг даргын бүрэн эрхийг тухайн хот, тосгоны захирагч хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 14
Бүгд: 44
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “тухайн хотод” гэснийг “тухайн шүүхэд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 14
Бүгд: 44
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Долоо.Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 14
Бүгд: 44
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Найм.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Н.Учрал нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 33
Бүгд: 44
25.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 22
Бүгд: 43
48.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх саналын томъёоллыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, дахин санал хураалт явуулаагүй болно.

Ес.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Арав.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 7.3.10 дахь заалтын “50-иас доошгүй” гэснийг тохиолдол бүрд “50” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 21
Бүгд: 40
47.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Н.Учрал нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 7.3.10 дахь заалтын “50-иас доошгүй” гэснийг тохиолдол бүрд “50” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван нэг.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “хот, тосгоны Зөвлөл” гэснийг “хотын Зөвлөл” гэж,” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “хот, тосгоны Зөвлөл” гэснийг “хотын Зөвлөл” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван хоёр.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмэх:

2/7 дугаар зүйлийн 7.4-7.6 дахь хэсэг:

“7.4.Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын алслагдсан байршилд тухайн хотын газрын зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссаны дагуу баригдсан олон улсын стандартад нийцсэн боловсрол, соёл, нийтийн номын сан, нийгмийн халамжийн үйлчилгээ, ахмадын төв, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, спортын барилга, байгууламжийн үл хөдлөх эд хөрөнгөд ногдуулах албан татварыг 5 жилийн хугацаанд чөлөөлж болно.”

7.5.Энэ хуулийн 7.4-д заасны дагуу албан татвараас чөлөөлөх үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалтыг тухайн хотын Захирагч, салбарын асуудал эрхэлсэн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд тавигдах шаардлага, стандартыг Засгийн газар батална.

7.6.Энэ хуулийн 6.4 дэх хэсэгт хамрагдсан үл хөдлөх эд хөрөнгөд энэ хуулийн 7.4 дэх заалт хамаарахгүй.” гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар өгч, санал хураалт явуулаагүй болно.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал үг хэлэв.

Арван гурав.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн ““Байгалийн” гэсний өмнө” гэснийг ““дараа сарын” гэсний өмнө” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван дөрөв.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “23.10 дахь хэсгийн “аймаг” гэсний дараа “, хот” гэж” гэснийг “23.10 дахь хэсгийн “Аймаг,” гэсний дараа, “суманд оршин суудаг”, “сумын төв нь”, “суманд 50 хувиар”, “суманд 90 хувиар” гэсний өмнө “хот,” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван тав.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14 дүгээр зүйлийн 14.1.22 дахь заалтын “хотын Зөвлөлийн дарга тухайн шатны Зөвлөлийн төсвийн” гэснийг “хот, тосгоны Захирагч тухайн шатны төсвийн” гэж, 4 дэх заалт буюу 23.14 дэх хэсгийн “хотод” гэснийг “хот, тосгонд” гэж, “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 1 дэх заалт буюу 14.1.23, 14.1.24 дэх заалтыг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“4/23 дугаар зүйлийн 23.8.18 дахь заалт:

“23.8.18.хотын албан татвар.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 14
Бүгд: 42
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 8.5.3 дахь заалт, 61.1, 63.4, 64.1 дэх хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж, 8.5.4 дэх заалтын “улсын зэрэглэлтэй хотын” гэснийг “тосгоны” гэж, 29.3 дахь хэсгийн “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын” гэснийг “хот, тосгоны” гэж, 57.4 дэх хэсгийн “орон нутгийн зэрэглэлтэй хот” гэснийг “болон орон нутгийн зэрэглэлтэй хотын” гэж тус тус өөрчилж, “16 дугаар зүйлийн” гэсний дараа “16.3 дахь хэсгийн” гэж нэмж, 42.3.3 дахь заалт, 66.1 дэх хэсгийн “улсын зэрэглэлтэй хотын хороо,” гэснийг, 56.3.2 дахь заалтын “хотын” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 15

Бүгд: 41

63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 19.5 дахь хэсэг, 4 дэх заалт буюу 36.1, 36.2, 36.6 дахь хэсэг, 9 дэх заалт буюу 61.4 дэх хэсэг, 10 дахь заалт буюу 63.3 дахь хэсгийн “хотын” гэснийг, 3 дахь заалт буюу 34.2 дахь хэсгийн “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын” гэснийг “хот, тосгоны” гэж, 14 дэх заалт буюу 19.6.3 дахь заалтын “улсын зэрэглэлтэй хотын” гэснийг “тосгоны” гэж, 8 дахь заалт буюу 60.6 дахь хэсгийн “хот, улсын зэрэглэлтэй хотын хорооны” гэснийг “хотын” гэж, 9 дэх заалт буюу 61.3 дахь хэсгийн “Засаг дарга болон хот, тосгон, улсын зэрэглэлтэй хотын хорооны Захирагч” гэснийг “Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч” гэж, 12 дахь заалт буюу 67.1 дэх хэсгийн “улсын зэрэглэлтэй хот, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагч нь” гэснийг “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч” гэж тус тус өөрчилж, 2 дахь заалт буюу 21.2, 21.3 дахь хэсэг, 15 дахь заалт буюу 67.2.3 дахь заалтын “улсын зэрэглэлтэй хотын хороо,” гэснийг, 3 дахь заалт буюу 34.2 дахь хэсгийн “хотын” гэснийг, 5 дахь заалт буюу 56.3 дахь хэсгийг, 7 дахь заалт буюу 59.2 дахь хэсгийг, 10 дахь заалт буюу 63.3 дахь хэсгийн “улсын зэрэглэлтэй хотын хороо,” гэснийг болон 13 дахь заалт буюу 8.5.1, 8.5.3 дахь заалтыг хасаж тус тус хасаж, 6 дахь заалт буюу 58.1.1 дэх заалтын “хот,” гэсний дараа “тосгон” гэж, 12 дахь заалт буюу 67.3 дахь хэсгийн “Захирагч” гэсний өмнө “хот, тосгоны” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 13

Бүгд: 41

68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын “Засаг дарга болон Захирагчаас” гэснийг “Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчаас” гэж, 4.1.27, 8.9.3, 59.2.4 дэх заалт, 23.8, 23.9, 25.8, 39.1 дэх хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн “8.8 дахь хэсгийн” гэсний өмнө “8.5.1, 8.5.3 дахь заалтын “Хуралд” гэснийг “Хурал болон Зөвлөлд” гэж,” гэж, “23.8, 23.9 дэх хэсгийн” гэсний өмнө “, 23.7.3 дахь заалт, 23.13 дахь хэсгийн “аймаг, нийслэлийн” гэснийг “аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын” гэж,” гэж, “25 дугаар зүйлийн” гэсний өмнө “23.9.3 дахь заалтын “сум, дүүргийн” гэснийг “сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны” гэж, 24¹ дүгээр зүйлийн 24¹.1.1 дэх заалтын “нийслэлийн” гэснийг “нийслэл, улсын зэрэглэлтэй хотын” гэж,” гэж, 59.8 дахь хэсгийн “тосгоны” гэсний өмнө “орон нутгийн зэрэглэлтэй хот,” гэж, “66 дугаар зүйлийн” гэсний өмнө “64 дүгээр зүйлийн гарчгийн

“Хурлын” гэснийг “Хурал, Зөвлөлийн” гэж, 65 дугаар зүйлийн гарчгийн “даргын” гэснийг “дарга, улсын зэрэглэлтэй хотын Захирагчийн” гэж,” гэж, “66.1.3 дахь заалтын” гэсний өмнө “гарчгийн “даргын” гэснийг “дарга, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн” гэж,” гэж тус тус нэмж, 36.3 дахь хэсгийн “улсын зэрэглэлтэй хотын хороо,” гэснийг, 66.1.6 дахь заалтын “хотын хороо,” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд “56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсгийн “нийслэлийн төсөвт, аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум дүүргийн төсөвт” гэснийг “нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төсөвт, аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсөвт, улсын зэрэглэлтэй хотын Захирагч нь орон нутгийн зэрэглэлтэй хотын төсөвт” гэж,” гэж, мөн зүйлд “59.2 дахь хэсгийн “нийслэл” гэснийг “нийслэл, улсын зэрэглэлтэй хот” гэж, “дүүргийн” гэснийг “дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны” гэж,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван зургаа.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “22.5.1 дэх заалтын “аймаг” гэсний дараа “, хот”” гэснийг “22.5.1 дэх заалтын “сумын төв нь”, “суманд байнгын”, “сумын нутаг дэвсгэр”, “суманд 50 хувиар”, “суманд 90 хувиар” гэсний өмнө болон “албан татварыг аймаг,” гэсний дараа “хот,” гэж өөрчилж, мөн зүйлийн “28.6 дахь хэсгийн” гэсний дараа ““татвар нь”, “жилд” гэсний дараах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван долоо.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 14
Бүгд: 41
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван найм.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван ес.Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “Засаг даргын” гэсний өмнө ““хооронд”, “дээд шатны” гэсний өмнөх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорь.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтын “Хурал” гэсний дараа “, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл” гэж,” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.3.Энэ хуулийн 29.1.12, 29.1.14, 35.1.4, 35.1.5, 35.1.6, 35.1.7, 35.1.8, 35.1.9, 35.1.10, 35.1.11, 35.1.12, 35.1.13, 35.1.15, 35.1.16, 35.1.17, 35.1.18, 35.1.21, 35.1.22 дахь заалт, 35.4, 35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тогтооно.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 14
Бүгд: 41
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн гарчиг болон 35.1 дэх хэсгийн “Засаг даргаас” гэснийг “Засаг дарга, хотын Захирагчаас” гэж, 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2 дахь заалтын “олгоход”, “сунгахад” гэсний дараах “нийслэлд” гэснийг “нийслэл, нийслэлийн харьяа улсын зэрэглэлтэй хотод” гэж, 35.2.1 дэх заалтын “1 000 000 төгрөг”, “300 000 төгрөг” гэсний өмнөх, 35.2.2 дахь заалтын “500 000 төгрөг”, “300 000 төгрөг” гэсний өмнөх “аймгийн төвийн суманд” гэснийг “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотод” гэж, 35.2.1 дэх заалтын “500 000 төгрөг”, “200 000 төгрөг” гэсний өмнөх, 35.2.2 дахь

заалтын “300 000 төгрөг”, “100 000 төгрөг” гэсний өмнөх “бусад суманд” гэснийг “суманд” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин нэг.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсгийн дугаарыг “40.8” гэж өөрчилж, 2, 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин хоёр.Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “50-иас доошгүй хувийг” гэсний дараа “хотын дэд бүтцийн санд төвлөрүүлж,” гэж” гэснийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлд “7.3 дахь хэсгийн “50-иас доошгүй хувийг” гэснийг “50 хувийг хотын дэд бүтцийн санд төвлөрүүлж,” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин гурав.Хотын албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “төсөвт төвлөрүүлэх” гэсний өмнө “уг татварыг” гэж нэмэн, “харилцааг зохицуулна” гэснийг “харилцаанд үйлчилнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын “тав тухтай амрах, зугаалах нөхцөлийг” гэснийг “байнгын болон улирлын үйл ажиллагаатай,

үйлчлүүлэгчийн тав тухтай амрах нөхцөлийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн “түүний дагалдах хэрэгсэл” гэснийг “тэдгээрийн дагалдах хэрэгсэл” гэж, 7.2.5 дахь заалтын “угаалгын үйлчилгээ” гэснийг “угаалгын газрын үйлчилгээ” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “ногдох албан татварыг” гэснийг “ногдуулсан албан татварыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин дөрөв. “Хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын хүснэгтийн 11, 13 дахь дэд заалтын “Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр” гэснийг “Нийслэлийн Сонгинохайрхан, Баянгол дүүргийн нутаг дэвсгэр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын хүснэгтийн 33 дахь дэд заалтын “Өвөрхангай аймгийн Арвайхээр сум” гэснийг “Өвөрхангай аймаг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын хүснэгтийн 52 дахь дэд заалтын “Дархан хот” гэснийг “Дархан-Уул аймаг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 18

Бүгд: 42

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 5 дахь заалтын “чиг үүргийг” гэсний өмнө “зарим” гэж тохиолдол бүр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 17

Бүгд: 42

59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 6, 7 дахь заалт нэмэх:

“6/Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн зарим чиг үүргийг Шаргаморьт дагуул хотод, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зарим чиг үүргийг тус хотын Зөвлөлд, дүүргийн Засаг даргын зарим чиг үүргийг тус хотын Захирагчид хотын эдэлбэр газрын хэмжээнд хэрэгжүүлэхээр тус тус шилжүүлсүгэй.

7/Нийслэлийн Багахангай дүүргийн чиг үүргийг Багахангай дагуул хотод, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чиг үүргийг тус хотын Зөвлөлд, дүүргийн Засаг даргын чиг үүргийг тус хотын Захирагчид хотын эдэлбэр газрын хэмжээнд хэрэгжүүлэхээр тус тус шилжүүлсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 17

Бүгд: 42

59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 9 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 19

Бүгд: 42

54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 10 дахь заалтын 1 дэх дэд заалтын “Нийслэл Улаанбаатар хотоос бусад” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 16

Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Д.Тогтохсүрэн, С.Чинзориг нарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын хүснэгтийн Хотын нэр баганад “Хархорин хот” гэж, “Харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, Хот баганад “Өвөрхангай аймгийн Хархорин сум”, гэж, Газар зүйн байршил баганад “Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дэвсгэр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хорин тав. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/хууль тогтоомжийг нийцүүлэх чиглэлээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2024 оны дөрөвдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/хот, тосгоны зөвлөл, захирагчийн сонгуулийг цахимаар явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судалж, танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:

Нэг.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд “23.6.13.нэмэгдсэн өртгийн албан татварын 10 хувь”, төслийн 3 дугаар зүйлд “23.4.2.нэмэгдсэн өртгийн албан татварын 90 хувь” гэсэн агуулгатай заалт тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Баярмаа, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, мөн яамны Хөгжлийн бодлого төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч Д.Бэлэгсайхан, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Б.Төрбат, Сэлэнгэ аймгийн Бугант тосгоны захирагч Д.Эрдэнэбулган, мөн аймгийн Дулаанхаан тосгоны захирагч Ж.Ганболд, Булган аймгийн Хялганат тосгоны захирагч А.Сод-Эрдэнэ, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын ахлах мэргэжилтэн Д.Баялагцэнгэл, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын мэргэжилтэн С.Энхжаргал, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах хорооны Ажлын албаны дарга ахлах шинжээч Ц.Батгэрэл, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр, мөн захиргааны Ерөнхий менежер Б.Гүнболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Л.Батмөнх, Б.Баярмаа, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Э.Бат-Амгалан, Ж.Батжаргал, Б.Баттөмөр, Г.Дамдинням, Т.Доржханд, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, С.Одонтуяа, Г.Тэмүүлэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “нутаг дэвсгэр нь” гэснийг “эдэлбэр газар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 20
Бүгд: 39
48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Э.Бат-Амгалан, Ж.Батжаргал, Б.Баттөмөр, Г.Дамдинням, Т.Доржханд, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, С.Одонтуяа, Г.Тэмүүлэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “нутаг дэвсгэр нь” гэснийг “эдэлбэр газар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “сонгон шалгаруулж, 4 жилийн хугацаагаар хотын Захирагч томилно” гэснийг “сонгоно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18

Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн “Цаашид “Захирагчийн ажлын алба” гэх./-” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,” гэсний дараа “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.3.3 дахь заалтын “академи” гэснийг “үндэсний хүрээлэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 20
Бүгд: 39
48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт доор дурдсан 17.3.6 дахь заалт нэмэх:

“17.3.6.олон улсын банк, санхүүгийн үйл ажиллагаа.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 18 дугаар зүйл нэмэх:

“18 дугаар зүйл.Олон улсын санхүүгийн төв

18.1.Энэ хуулийн 8.1.1-д заасан эдийн засгийн чөлөөт бүсэд тусгай дэглэм бүхий газар нутгийн хил зааг дотор олон улсын банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн оролцогч байгууллагуудаас бүрдсэн олон улсын санхүүгийн төв байгуулна.

18.2.Олон улсын санхүүгийн төвийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны хүрээ, хязгаар, эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “16.1.1-д зааснаас бусад” гэснийг “16.1.2, 16.1.3, 16.1.4-т заасан” гэж өөрчилж, “доор дурдсан салбарт” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, агуулга, зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын шинжтэй саналын томьёолол:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4.4 дэх заалтын “бэлгэдэл тэмдэг” гэснийг “бэлгэ тэмдэг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийн “9.5-д” гэснийг “9.6-д” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “хороонд” гэснийг “хороололд”, “хороо” гэснийг “хороолол” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “13.4.4” гэснийг “13.4.5” гэж, “13.4.5” гэснийг “13.4.6” гэж, “13.4.6” гэснийг “13.4.7” гэж, “13.4.7” гэснийг “13.4.8” гэж, “13.4.8” гэснийг “13.4.9”, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “Шинэ Зуунмод хот /цаашид “хот” гэх/”, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорац /цаашид “корпорац” гэх/” гэсэнтэй нийцүүлж тохиолдол бүрт, 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсгийн “зүйлийн” гэснийг “хуулийн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “Нийслэл” гэсний дараа “хот” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 20
Бүгд: 41
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотын хотын хөгжлийн корпорац нь Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 18.1-д заасан олон улсын санхүүгийн төвийг байгуулах бэлтгэл ажлыг хангана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг 4 дүгээр зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд хотын Захирагчийн чиг үүргийг хотын бүтээн байгуулалт, хөгжлийн асуудал хариуцсан бүрэн эрхт төлөөлөгч хэрэгжүүлэх бөгөөд түүнийг нийслэлийн Засаг даргын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 20
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “38.1.22” гэснийг “38.1.23” гэж, “40.8” гэснийг “40.9” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль баталсантай холбогдуулан бусад хууль тогтоомжийг нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2024 оны дөрөвдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв. “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Г.Занданшатар: 1. Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн үндэслэх хэсгийн “тус тус” гэсний өмнө “, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын “Шинэ Зуунмод хотын эдэлбэр газрын хилийн заагийн эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээ, байршил” хүснэгтийн Төв аймгийн Сэргэлэн сумын “Шинэ Зуунмод /Төрийн захиргааны нэгдсэн цогцолбор/”-ын 1000 га газрын солбицлыг тэгш өнцөгтийн солбицлоор хийсэн байгааг газар зүйн солбицол болгон нийцүүлж доор дурдсанаар өөрчлөх:

Төв аймаг, Сэргэлэн сум	379646.9	Шинэ Зуунмод хот /Төр, захиргааны нэгдсэн цогцолбор/	1000.0	1	106° 54'	47° 44' 55.904"
					21.302" E	N
				2	106° 56'	47° 45' 38.816"
	48.435" E	N				
	3	106° 57'	47° 44' 37.151"			
	48.615" E	N				

				4	106° 58' 16.594" E	47° 44' 33.854" N
				5	106° 58' 21.284" E	47° 44' 20.591" N
				6	106° 57' 28.373" E	47° 43' 27.071" N
				7	106° 56' 55.500" E	47° 43' 39.500" N
				8	106° 56' 2.300" E	47° 43' 42.100" N
				9	106° 55' 58.497" E	47° 44' 11.712" N

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх саналын томъёоллыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, дахин санал хураалт явуулаагүй болно.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн газрын мэргэжилтэн Ц.Мөнхнасан, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Малчны тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Ганибал, Б.Саранчимэг, Ц.Идэрбат, Т.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 4.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4.1.7, 4.1.8 дахь заалт нэмэх:

“4.1.4.“хот айл” гэж хоёр ба түүнээс дээш малчин өрх хамтран хөдөлмөрөө хоршин мал аж ахуй эрхлэх зохион байгуулалтын хэлбэрийг;

4.1.5.“мал аж ахуйн зохистой дадал” гэж бэлчээрийг хамгаалах, мал маллагаа, малын эрүүл мэнд, үүлдэр угсаа, ашиг шим, түүхий эдийн чанар, аюулгүй байдлыг хангах арга барил, үйл ажиллагааг;

4.1.7.“мал” гэж Малын генетик нөөцийн тухай хуулийн 4.1.1-д заасныг;

4.1.8.“малчин өрх” гэж Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.2-т заасныг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.6 дахь заалтын “урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд” гэсний дараа “хамрагдах хүсэлт гаргасан малчныг жил бүр” гэж нэмж, 5.1.6 дахь заалтыг 5.1.6, 5.1.7 дахь заалт болгож, 5.2, 5.3 дахь хэсэг, 5.2.1, 5.2.3, 5.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.6.мал аж ахуйн салбарын уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан эрсдэл даах чадавхыг бүрдүүлэх;

5.1.7.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, боловсруулалтын түвшинг ахиулах цогц бодлогыг хэрэгжүүлэх;

5.2.Засгийн газраас энэ хуулийн 5.1-д заасан бодлогыг хэрэгжүүлэхээс гадна дараах арга хэмжээг авна:

5.2.1.мал аж ахуйн тогтвортой хөгжлийн бодлогыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт, шаардагдах санхүүжилтийг улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;

5.2.3.мал үржүүлэг, технологийн болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг хөнгөлөлттэй зээл болон бусад хэлбэрээр дэмжих;

5.2.7.гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас малчин нь ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 48 сараар тооцож, түүнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь Засгийн газрын нөөц сангаас олгох;

5.3.Энэ хуулийн 5.2.4, 5.2.5, 5.2.6, 5.2.7, 5.2.8, 5.2.9-д заасан арга хэмжээтэй холбогдох харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 19

Бүгд: 40

52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 12 цаг 50 минутаас хуралдааныг даргалав.

Л.Мөнхбаатар: 4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, ГУРАВДУГААР БҮЛЭГТ шилжүүлэх:

МАЛЧНЫ ХӨГЖИЛ, ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

“6 дугаар зүйл.Малчны эрх, үүрэг

6.1.Малчин дараах эрх эдэлнэ:

6.1.1.уур амьсгалын өөрчлөлт, зах зээлийн нөхцөлд мал маллах арга ухааныг эзэмшиж, мэдлэг, туршлага, ур чадвар, арга барилаа ахиулж, малчинд зориулсан сургалт мэдээлэл, зөвлөгөө авах;

6.1.2.байгалийн нөөц, бэлчээрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гэрээгээр ашиглах эрхээ баталгаажуулах;

6.1.3.төрөөс болон олон улсын байгууллагын санхүүжилтээр олгосон хөрөнгө оруулалт, хөгжлийн зээл, дэмжлэг, санхүүгийн үйлчилгээ авах;

6.1.4.малын эрүүл мэндийг хамгаалах болон үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг эрх бүхий нэгжээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, зөвлөгөө авах;

6.1.5.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлт, нэр төрөл, чанараас хамаарсан урамшууллыг хууль тогтоомжийн дагуу авах;

6.1.6.хуульд заасан бусад эрх.

6.2.Малчин дараах үүрэг хүлээнэ:

6.2.1.байгалийн нөөц, бэлчээр, усан хангамжийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;

6.2.2.мал маллагааны уламжлалт болон шинжлэх ухаанч арга барилыг эзэмших;

6.2.3. малын эрүүл мэндийг хамгаалах, малын генетик нөөцийг зохистой ашиглах;

6.2.4. мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангах;

6.2.6. хуульд заасан бусад.

6.3. Энэ хуулийн 6.2.1-д заасан үүргийн хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:

6.3.1. малчин өрх, хот айл бэлчээрээ дундаа хамтран ашиглаж ирсэн уламжлалд тулгуурлан харилцан зөвшилцөж, зохион байгуулалтад орсон байх;

6.3.2. бэлчээрийг даацад нь нийцүүлэн улирлын хуваарьтай ашиглаж, сэлгэх, өнжөөх, сайжруулах, нөхөн сэргээх зэргээр бэлчээрийн төлөв байдал, голлох зүйл ургамлын эзлэх хувийг гэрээ байгуулах үеийн тогтоосон суурь түвшнээс бууруулахгүй байх;

6.3.3. Газрын тухай хуулийн 52.7-д заасан газарт тэжээлийн ургамал тариалах, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан хадлан, гар тэжээл бэлтгэх.

6.4. Энэ хуулийн 6.2.2-г заасан үүргийн хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:

6.4.1. мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг өөрийн малын тоо толгойд нийцүүлэн бүрэн хангаж, 90-ээс доошгүй хоногт хүрэлцэхүйц өвс, тэжээл бэлтгэж нөөцлөх;

6.4.2. малын хэвтэр бууц, хашаа, хороог байнга цэвэрлэж, өвөлжөөний хөрзөнг жил бүр авдаг, өтөг хөрзөнг овоолж хэвтрийн нөөц бүрдүүлдэг байх;

6.4.3. өвөлжөө, хаваржааны дулаан хашаа, хороо, байр барьж ашиглах;

6.4.4. дөрвөн улиралд нүүдэллэн бэлчээр ашиглахдаа байгаль орчныг бохирдуулахгүй, хог хаягдлыг ил задгай үлдээхгүй байх;

6.4.5. худаг, хөв цөөрөм бий болгох, сэргээн засварлах;

6.4.6. мал маллах, хариулах, тууварлах, тээвэрлэхдээ уламжлалт арга барилыг түлхүү ашиглах.

6.5. Энэ хуулийн 6.2.3-г заасан үүргийн хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:

6.5.1. тухайн бүс нутагт үржүүлэхийг зөвшөөрсөн, баталгаажсан үүлдэр, омгийн хээлтүүлэгч ашиглах, малыг ялган тэмдэглэх, бүртгэлд хамруулах;

6.5.2. малын төрлийн харьцаа, сүргийн зохистой бүтцийг хангаж, эдийн засгийн эргэлтэд оруулах;

6.5.3. тухайн үүлдэр, омгийн нэгж малаас авч болох ашиг шимийн дундаж гарцаас багагүй хэмжээний ашиг шим авах;

6.5.4.мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд 3 жил тутамд чанарын үнэлгээ хийлгэх;

6.5.5.мал эмнэлгийн болон үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг мэргэжлийн нэгжээр гэрээний үндсэн дээр технологит хугацаанд гүйцэтгүүлэх;

6.5.6.мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдал, гарал үүслийг тогтоох нөхцөлийг бүрдүүлж, малын шилжилт хөдөлгөөний талаар эрх бүхий байгууллагад мэдээлдэг байх;

6.5.7.эмийн үлдэц агуулаагүй, баталгаатай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх.

6.6.Энэ хуулийн 6.2.4-т заасан үүргийн хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:

6.6.1.малын ноос, ноолуур, хөөврийг технологийн хугацаанд холбогдох стандарт, шаардлагын дагуу чанарын ялгаатай байдлаар ангилан тордож, бэлтгэн нийлүүлэх;

6.6.2.малын мах бэлтгэлийг хийхдээ малын арьс ширийг механик гэмтэлгүйгээр хоёр цагийн дотор цэвэрлэгээ, анхан шатны тордолтыг хийж, холбогдох стандарт, шаардлагын дагуу бэлтгэх;

6.6.3.сүү, сүүн бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэхдээ эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангасан байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 18

Бүгд: 39

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.6 дахь хэсэг, 7.5.3, 7.5.4, 7.5.7 дахь заалтыг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулж, 7.2 дахь хэсгийг хасах:

“7.3.Энэ хуулийн 7.1-д заасан сургалтын хөтөлбөрийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, сургалтыг их сургууль, коллеж, мэргэжил, сургалт үйлдвэрийн төв, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор үндэсний хэмжээнд зохион байгуулна.

7.4.Энэ хуулийн 7.3-т заасан хөтөлбөр нь сургалтын нэгдсэн стандарт, бүс нутгийн онцлогт нийцсэн байна.

7.5.3.малын чанарыг сайжруулах, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал маллах, арчлах болон сувилгааны арга аргачлалын талаарх мэдлэг мэдээлэл, цуврал хичээл;

7.5.4.бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх мэдлэг олгох мэдээлэл, цуврал хичээл;

7.5.7.малын өтөг бууц, аргал, хөрзөнг цэвэрлэх, боловсруулах, техник, технологийн мэдлэг;

7.6.Сургалт зохион байгуулсан байгууллага сургалтын хөтөлбөрөөр бүрэн суралцсан, үнэлгээний шаардлага хангасан төгсөгчид үнэмлэх, тэмдэг олгож, энэ талаарх мэдээллийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 8.3 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллага нь” гэснийг “Засаг дарга” гэж өөрчилж, 8.3.4 дэх заалт, 8.4 дэх хэсэг, 8.5 дахь хэсгийн “, 8.3.4” гэснийг, тус тус хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 8.3, 8.4 дэх хэсэг нэмэх:

“8.2.Аймаг, сумын Засаг дарга орон нутгийн онцлогт нийцүүлж, малчны хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

8.3.Газрын тухай хуулийн 52.7-д заасан газрыг өөр чиглэлээр давхцуулан газар ашиглах, эзэмшүүлэх, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохгүй.

8.4.Залуу малчин гэр бүлд болон хот, сууринаас шилжин очиж, 2-оос доошгүй жил тасралтгүй мал маллаж байгаа малчин өрхөд өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх, бэлчээр ашиглуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрт үндэслэн сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 20
Бүгд: 39
48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 8.3 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллага нь” гэснийг “Засаг дарга” гэж өөрчилж, 8.3.4 дэх заалт, 8.4 дэх хэсэг, 8.5 дахь хэсгийн “, 8.3.4” гэснийг, тус тус хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 8.3, 8.4 дэх хэсэг нэмэх:

“8.2.Аймаг, сумын Засаг дарга орон нутгийн онцлогт нийцүүлж, малчны хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

8.3.Газрын тухай хуулийн 52.7-д заасан газрыг өөр чиглэлээр давхцуулан газар ашиглах, эзэмшүүлэх, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохгүй.

8.4.Залуу малчин гэр бүлд болон хот, сууринаас шилжин очиж, 2-оос доошгүй жил тасралтгүй мал маллаж байгаа малчин өрхөд өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх, бэлчээр ашиглуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрт үндэслэн сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10.9 дэх хэсгийн “хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага тус тус” гэснийг “Засаг дарга” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 10.10 дахь хэсэг нэмэх:

“10.3.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашиг, нөөц ашиглалтын түвшний өсөлт болон малчны хүлээх үүрэг, зохистой дадлын хэрэгжилтийг харгалзан улс, аймаг, сумын аварга малчин, тэргүүний малчны хоршоо, аймаг, сум шалгаруулах болзолд тусгаж, бүтээмжийг үнэлнэ.

10.6.Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу халдварт өвчингүй, эрүүл мал сүрэгтэй малчин өрхийг баталгаажуулна.

10.10.Улсын аварга, хошой аварга малчин, саальчин, фермер шалгаруулах журам болон энэ хуулийн 10.4-т заасан малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд урамшуулал олгох журмыг Засгийн газар тус тус батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4.6 дахь заалтын “малчны бүлгийн” гэснийг “хот айл, малчдын холбооны” гэж өөрчилж, 11.4.7 дахь заалтын “санаачлах аливаа малчны” гэснийг, 11.5 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12, 13, 14 дүгээр зүйлийн хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “Малчин нь” гэснийг “Малчид хамтын санаачилга, хоршилд үндэслэн” гэж өөрчилж, 15.2 дахь хэсгийг хасаж, 15.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.6.Бэлчээрийг хаших, хөрсийг эвдэх, мэргэжлийн байгууллагаас доройтсон болохыг тогтоосон бэлчээрээс ургамал түүх, хадахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “16.2-т заасан зээлийг” гэсний дараа “арилжааны банкны шаардлага болон” гэж нэмж, 16.5.10, 16.6.5, 16.6.6 дахь заалтыг тус тус хасаж, 16.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.7.Энэ хуулийн 16.2-т заасан зээлийн хүүгийн хөнгөлөлтөд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалтын “урамшууллын нэг удаагийн орлогын хуваарилалт” гэснийг “урамшууллаас малчны зөвшөөрлийг үндэслэн хуваарилсан хөрөнгө” гэж өөрчилж, 17.2.5 дахь заалтыг хасаж, 17.7 дахь хэсгийн “хоршоо,” гэсний дараа “нөхөрлөл, компани,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 22
Бүгд: 39
43.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

21 дүгээр зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

“21.1.Энэ хуулийн 5.2.9 дэх заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.

21.2.Энэ хуулийн 16 дугаар зүйлийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын шинжтэй саналын томъёолол:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “мал аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх” гэснийг мөн хэсгийн “бүтээмж бүхий” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “, чадваржуулах, оролцоо идэвхийг нэмэгдүүлэх, тогтвортой, чанартай амьдрах хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэснийг, 5.1.7 дахь заалтын “мал аж ахуй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд” гэснийг, 5.2.2 дахь заалтын “малчин өрхийн амьдралын чанарыг дээшлүүлэх үүднээс” гэснийг, 5.2.6 дахь заалтын “малчид жил тутам” гэснийг, 5.2.9

дэх заалтын “Тайлбар: Энэ заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн “батлан” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “, цахим малчныг хөгжүүлнэ” гэснийг, 16.5.1 дэх заалтын “байгаль цаг уурын нөхцөлийг хангахуйц” гэснийг, 16.5.9 дэх заалтын “, түүхий эд, бүтээгдэхүүний чанарын үнэлгээ хийлгэх” гэснийг тус тус хасах.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “малчны үйл ажиллагаатай холбогдсон бусад” гэснийг “эдгээр хуультай нийцүүлэн гаргасан” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “байгаль цаг уурт” гэснийг “уур амьсгалын нөхцөлд” гэж, 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын “сайжруулах” гэснийг “хамруулж, дэмжлэг” гэж, 5.2.4 дэх заалтын “үүднээс” гэснийг “зорилгоор орон сууцны” гэж, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “, үнийн үнэлгээг тогтоож,” гэснийг “олгох замаар” гэж, 10.5 дахь хэсгийн “үржлийн ажлыг” гэснийг “үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтын “ашгийн төлөө байгууллага” гэснийг “нөхөрлөл, хоршоо, компани.” гэж, 11.3 дахь хэсгийн “Компанийн тухай болон Хоршооны тухай хуулиар зохицуулагдана.” гэснийг “холбогдох хуулиар зохицуулна.” гэж, 11.4.7 дахь заалтын “байгаль орчны” гэснийг “уур амьсгалын өөрчлөлтийн” гэж, 17 дугаар зүйлийн 17.2.4 дэх заалтын “малчны, малчны бүлгийн” гэснийг “энэ хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.3-т заасан этгээдийн” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “малын тоо толгойн албан татварын орлогыг төвлөрүүлэх сан” гэснийг “малчны хөгжлийн сан” гэж, 18.1.3 дахь заалтын “орон нутгийг хөгжүүлэх” гэснийг “орон нутгийн хөгжлийн сан” гэж, 18.1.4 дэх заалтын “сумын хоршооны” гэснийг “хоршоо хөгжүүлэх сан” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	20
Татгалзсан:	19
Бүгд:	39

51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Малчны тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.43, 6.64 дэх заалтын “15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт” гэснийг “15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 13.11 дүгээр зүйлд” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	17
Бүгд:	39

56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Статистик, дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн С.Батхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “мал амьтны эм” гэсний дараа “/цаашид “эм” гэх/” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	19
Татгалзсан:	20
Бүгд:	39

48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	19
-------------	----

Татгалзсан: 20
Бүгд: 39
48.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “мал амьтны эм” гэсний дараа “/цаашид “эм” гэх/” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 20
Бүгд: 39
48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “мал амьтны эм” гэсний дараа “/цаашид “эм” гэх/” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.5, 4.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.1.“эм” гэж мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчин эмгэгийг оношлох, эмчлэх зориулалттай, эм судлал, эмнэлзүйн болон бусад сорилт туршилтаар үйлдэл нь нотлогдсон нийлэг болон амьтан, ургамал, эрдсийн гаралтай тодорхой хэлбэр, тун, хэмжээтэй бүтээгдэхүүнийг;”

“4.1.5.“оношлуур” гэж мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болон орчны сорьцын шинжилгээнд хэрэглэдэг тодорхой тун, хэмжээ, найрлага, өвөрмөц чанар, идэвх бүхий бүтээгдэхүүнийг;”

“4.1.8,“эмийн туслах бодис” гэж эмийн гол үйлдлийг дэмжих, сөрөг нөлөөг бууруулах, амт, үнэрийг дарах ба нэмэгдүүлэх, эмийг хэлбэржүүлэх, найрлагыг тогтворжуулах, үйлдлийн ба хадгалах хугацааг уртасгах зэрэгт шаардлагатай бодисыг; гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “мал, амьтны эмийн зөвлөл” гэсний дараа “/цаашид “Зөвлөл” гэх/” гэж, 5.3.1 дэх заалтын “мал, амьтны эм,” гэсний дараа “биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл,” гэж тус тус нэмж, 5.4 дэх хэсгийн “мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “улсын бүртгэлд” гэснийг “Мал, амьтны эмийн бүртгэлд /цаашид “бүртгэл” гэх/ гэж, 6.18 дахь хэсгийн “мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.3.8, 6.3.9 дэх заалт нэмэх:

“6.3.8.оношлуур;

6.3.9.тэжээллэг чанартай тэжээлийн нэмэлт.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.8.10 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.4.13 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төслийн Гуравдугаар бүлэг болон 10 дугаар зүйлийн гарчгийн “тэжээлийн нэмэлтийн” гэснийг “тэжээлийн нэмэлт, оношлуурын” гэж өөрчилж, 10.2.3 дахь заалтын “мал, амьтны эмийн сан” гэсний дараа “/цаашид “эмийн сан” гэх/” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 15.12.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас импортлох, экспортлох энгийн зөвшөөрлийг авна.”

“15.12.6.хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл, горим зөрчсөн нь тогтоогдсон;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “8.1 дүгээр зүйлийн 12.12,” гэснийг “8.1 дүгээр зүйлийн 12.12-г заасан тусгай зөвшөөрлийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,” гэж өөрчилж, 17.2, 17.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.2.Үйлдвэрлэх зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг зөвшөөрөл хүссэн өргөдлийн хамт мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ;”

“17.3.Импортлох зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг зөвшөөрөл хүссэн өргөдлийн хамт мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ;” гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар өгч, санал хураалт явуулаагүй болно.

11.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.3.3, 17.3.4, 17.4.4, 17.8.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	18
Бүгд:	39

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсгийн “Мал эмнэлгийн эмийг” гэснийг “Эм, тэжээлийн нэмэлтийг” гэж өөрчилж, доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“20.11.Мал, амьтны эрдэс бодисын дутлыг тодорхойлох тандан судалгааг энэ хуулийн 20.12-т заасан байгууллагын захиалгаар сургалт, эрдэм шинжилгээний байгууллага таван жил тутамд бүсчлэн хийнэ.

20.12.Энэ хуулийн 20.11-д заасан тандан судалгааг үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрдэс бодисын дутлыг нөхөх, хэрэглэх талаар зөвлөмж гаргана.

20.13.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь энэ хуулийн 20.12-т заасан зөвлөмжийн дагуу шаардлагатай эрдэс бодисыг агуулсан эм, тэжээлийн нэмэлтийг хэрэглэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	16
Татгалзсан:	24
Бүгд:	40

40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	16
Татгалзсан:	24

Бүгд: 40
40.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 12.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсгийн “Мал эмнэлгийн эмийг” гэснийг “Эм, тэжээлийн нэмэлтийг” гэж өөрчилж, доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“20.11.Мал, амьтны эрдэс бодисын дутлыг тодорхойлох тандан судалгааг энэ хуулийн 20.12-т заасан байгууллагын захиалгаар сургалт, эрдэм шинжилгээний байгууллага таван жил тутамд бүсчлэн хийнэ.

20.12.Энэ хуулийн 20.11-д заасан тандан судалгааг үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрдэс бодисын дутлыг нөхөх, хэрэглэх талаар зөвлөмж гаргана.

20.13.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь энэ хуулийн 20.12-т заасан зөвлөмжийн дагуу шаардлагатай эрдэс бодисыг агуулсан эм, тэжээлийн нэмэлтийг хэрэглэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.4.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.1.Энэ хуулийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр. Найруулгын шинжтэй саналын томьёолол:

Л.Мөнхбаатар: 1. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, 1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “хэлбэр,” гэсний өмнө “гол үйлчлэгч бодис,” гэж, 6.7.5, 6.8.5 дахь заалтын “хорон” гэсний дараа “, эсхүл хоруу” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “үр дүнгийн” гэсний дараа “харьцуулсан” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “хүртээмжтэй” гэсний дараа “тогтвортой” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “бөөнөөр ханган нийлүүлэх” гэсний өмнө “эмийн санд” гэж, 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтын “түдгэлзүүлэх,” гэсний дараа “цуцлах” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.3.8 дахь заалтын “тайланг хэлэлцэж, зөвлөмж өгөх” гэснийг “тайлантай танилцах” гэж, 5.6 дахь хэсгийн “төсөвт тусган санхүүжүүлнэ” гэснийг “төсвийн төсөлд тусгана” гэж, 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтын “тусламжаар импортлох” гэснийг “тусламж, хандивын” гэж, 6.3.2 дахь заалтын “эм” гэснийг “бүтээгдэхүүн” гэж, 6.4 дэх хэсгийн “зориулалтыг зааж” гэснийг “зориулалт, жороор олгох эсэхийг зааж” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2.7 дахь заалтын “үйлдвэрлэсэн эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн” гэснийг “бүтээгдэхүүний” гэж, 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “хүн эмнэлгийн зориулалт бүхий” гэснийг “хүний” гэж, 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсгийн “лиценз” гэснийг “энгийн зөвшөөрөл” гэж, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт импортлох, экспортлох энгийн зөвшөөрөл олгохдоо” гэснийг “Энгийн зөвшөөрөл хүсэгч нь” гэж, 17 дугаар зүйлийн 17.8.1 дэх заалтын “бүрдүүлж, хэрэгжилт, зарцуулалтад нь хяналт тавих” гэснийг “бүрдүүлэх” гэж, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “журам, эмийн жагсаалтыг” гэснийг “журмыг” гэж, 20.5 дахь хэсгийн “бүртгэж, улирал бүр цахим мэдээллийн санд оруулна” гэснийг “бүртгэнэ” гэж, 20.7 дахь хэсгийн “сөрөг үйлдэл болон хэрэглээний горимыг” гэснийг “гаж нөлөө, хэрэглэх зааврыг” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалтын “эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг” гэснийг, 11.2.2 дахь заалтын “эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх,” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “мал эмнэлгийн байгууллага, мал, амьтны эмийн санд эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг” гэснийг, 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага,” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.10.2 дахь заалтын “хамтын ажиллагааны болон төслийн” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.3.5 дахь заалтын “эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, багаж, тоног төхөөрөмжийн олон улсын болон тухайн орны чанар баталгаажилтын болон гарал үүслийн гэрчилгээ, хэрэглэх заавар” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “жил бүр шинэчлэн тогтоож, өөрийн орны судалгааны дүн болон” гэснийг, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “жил бүр шинэчлэн” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.3.7 дахь заалтын “үйл ажиллагаа эрхлэх ажлын байрны” гэснийг тус тус хасах.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа нарын 4 гишүүн 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Үндэсний их баяр наадмын тухай хуульд доор дурдсан агуулгатай 10.20 дахь хэсэг нэмсүгэй:

10.20.Энэ хуулийн 10.19-д заасан жороо морины уралдаанд морио уяж, уралдуулсан уяачийн амжилт нь энэ 10.4, 10.5, 10.6-д заасан болзлыг хангасан бол уяачид мөн хэсэгт заасан цол олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл зүйл.Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нарын 6 гишүүн 2024.05.17-ны өдөр мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг /

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 32.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.13.Цахимаар хуралдаанд бүртгүүлсэн бол санал хураахаас бусад асуудалд Хурлын ирцэд оруулан тооцож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 14

Бүгд: 39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 51.2 дахь хэсгийн “дараах асуудлаар шийдвэр гаргаж, дараагийн хуралдаанд танилцуулж болно” гэснийг “дараах асуудлыг хэлэлцэж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанд танилцуулж болно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 17

Бүгд: 39

56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3. Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “32.10” дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.10.Баг, хорооны иргэдийн Нийтийн анхдугаар хуралдаанаас хуралдаан даргалагчийг 2 жилийн хугацаагаар сонгоно. Хуралдаан даргалагч нь хуралдааныг удирдан явуулах, хуралдааны шийдвэрийг албажуулан гарын үсэг зурах, дараагийн хуралдааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангах үүрэгтэй. Хуралдааны даргад баг, хорооны Засаг даргын албан тушаалын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Ес. “Монгол Улсын Ерөнхий аудитор томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд нэр дэвшигч Д.Загджав оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай асуудлаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Д.Сарангэрэл нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын Ерөнхий аудитораар Дэлэгийн Загджавыг томилохыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2-т заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонх томилох саналыг дэмжсэн тул Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Монгол Улсын Ерөнхий аудитор томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./14:03/

Уг асуудлыг 14 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, авлига, хүнд суртлыг бууруулах “Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаар хийх Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах тухай албан бичиг ирүүлснийг танилцуулж, мэдээллийг хойшлуулав./14:03/

Арав.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга Л.Алтангэрэл, мөн газрын дэд дарга Д.Тэмүүлэн, Захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Ууганбат, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Ариунаа, Санхүүгийн хэлтсийн дарга Ч.Бат-Очир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 14 цаг 07 минутаас хуралдааныг даргалав.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Төслийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн “албан тушаалтныг” гэснийг “албан тушаалтан, эсхүл төр, нийгмийн зүтгэлтнийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Арван нэг. “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн газрын ахлах мэргэжилтэн Ц.Амгалан, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, ахлах мэргэжилтэн Б.Эрхэмбаяр, Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэбат, Арьс шир үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал Т.Баярсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд

хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Арван хоёр.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 4 гишүүн 2024.05.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолоор санал хураалт явуулав.

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын шинжтэй саналын томъёолол:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 16¹.5.5 дахь заалтын “чиг үүргээ” гэснийг “энэ хуульд заасан бүрэн эрхээ” гэж, 16¹.17 дахь хэсгийн “алба нь” гэснийг “албатай байж болох бөгөөд ажлын алба нь” гэж тус тус

өөрчилж, мөн хэсгийн “нарийн бичгийн” гэсний дараа “дарга” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчлөх, агуулга зарчмыг хөндөхгүйгээр үг хэллэг, найруулгын засвар хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын ““Төрийн албаны зөвлөлийн дарга” гэсний дараа” гэснийг болон мөн заалтын ““Төрийн албаны зөвлөлийн гишүүн” гэсний дараа” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Арван гурав.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-

ийн Захиргааны газрын дарга О.Энхбаяр, мөн компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 13 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 53 минут үргэлжилж, 72 гишүүнээс 50 гишүүн хүрэлцэн ирж, 69.4 хувийн ирцтэйгээр 14 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
10 цаг 34 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Гишүүдийн ирц бүрдсэн байна. Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя. 16 асуудал хэлэлцэнэ.

Энд хуулийн төслүүдийг эцэслэн батална. Нийт 17 хуулийн холбогдолтой хуулийн төслүүд, хамт өргөн мэдүүлсэн, дагалдуулж холбогдуулж боловсруулсан хуулийн төслүүд байгаа. 2 дугаарт Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлж хэлэлцэнэ. Энэ бол асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа. Одоо хэлэлцэх эсэх асуудал санал хураалт явуулна. Дараа нь 3 дугаарт бол Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалт бас үргэлжилнэ, зарчмын зөрүүтэй 78 саналтай. 4 дүгээрт Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалт үргэлжилнэ, зарчмын зөрүүтэй 18 саналтай. 5 дугаарт Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна. Зарчмын зөрүүтэй 16 саналтай санал хураалт явуулна.

6-д Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон

хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. 8-д Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг. 9 дүгээрт Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл анхны хэлэлцүүлгийг, анхны хэлэлцүүлгийг явуулна. Зарчмын зөрүүтэй 3 саналтай. 10.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна. 11-д Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. 12-т Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн тогтоолын хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. 13.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Монгол Улсын ерөнхий аудиторыг томилох тухай асуудал. Ашигт малтмалыг хайх, ашиглах зориулалтаар газар түүний хэвлийд тусгай зөвшөөрөл олгох төлбөр, татвар ноогдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагааны хяналт шалгалт хийх үүрэг бүхий хяналт шалгалтын түр хорооны тайлан санал, дүгнэлтийг тогтоолгохыг хэлэлцэнэ. 16-д Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Дашидондогийн Ганбат нараас үг хэлэх санал ирүүлсэн байгаа. Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Монголынхоо бизнес эрхэлж байгаа, төрдөө татвар төлж

байгаа бүх хүмүүстээ энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье. Тэгэхээр 2016 оноос хойш төр бизнес хийх явдал бол хэрээс хэтэрсэн. Хувийн хэвшилд 70 хувийг нь, төр 30 хувийг нь хийдэг байсан бол өнөөдрийн байдлаар бол төрийн хийдэг төрийн оролцоо, бизнес дэх оролцоо 60 хувьд хүрсэн. 40 хувь дээр л хувийн хэвшлийнхэн ажиллаж байна. Цөөхөн хүн амтай энэ оронд бол энэ 40 хувь дээр ажиллана гэдэг бол компаниуд дампуурах, бизнесийн эрсдэлд орох, үйл ажиллагаа нь зогсох ийм нөхцөл байдал руу бүгдийг нь аваачиж оруулж байгаа юм.

Дээрээс нь ковидын 2 жил бол үнэхээр бизнесийнхнийг хүнд нөхцөл байдалд оруулсан. Эндээсээ арай гэж гарч ирж байгаа тэр хүмүүс нь энэ төрийн дарамтад орж бизнесээ зогсоох ийм нөхцөл байдал руу маш их орж байгаа. Төр зүйл бүрээр дарамталж байна. Хуулийнхан дарамталж байна, татварынхан, хяналтынхан бүх зүйлээр дарамталж байна. Төрийн албан тушаалтнууд авлигаар дарамталж байна. Бүх хөдөлбөл гарын үсэг зурах болгонд л мөнгө төлдөг болсон ийм нийгэмд манай хувийн хэвшлийнхэн ажиллаад байна.

Тэгээд энэ өнөөдрийн эрх баригч нар бол энэ төрийн, энэ хувийнхныг харгислах энэ байдал бол хэрээс хэтэрсэн. Ер нь бол ямар хатуу, ямар их, дарамттай байгааг, ямар харгис байгааг та нар уржигдрын тэр Гарамжав захирлыг баривчилсантай холбоотой харж болно. Энэ хүн чинь Их Хурлын гишүүн байсан, МАН-ын Бага хурлын гишүүн, Удирдах зөвлөлийн гишүүн байсан. Дээрээс нь 10 дугаар Богдын эмээ. Олон, олон, тэгээд дээрээс нь өнөөдрийн энэ төрийн удирдлагуудтай бүгдтэй нь ойрхон. Гэтэл аваачаад л шоронд хийж байна шүү дээ. Энэ чинь яаж байна гэхээр та нарыг ч гэсэн бүгдийг нь бизнес эрхэлж байгаа та нарыг ч гэсэн өнөө маргаашгүй бүгдийг нь аваачаад л шоронд хийнэ гэсэн үг байхгүй юу. Харгисална гэсэн үг байхгүй юу. 10, 10-аар нь 20, 20-оор нь аваачаад хийх ийм харгислал маш их явж байна.

Тийм учраас энэ ийм хүнд нөхцөлд бол энэ хувийн хэвшлийнхэн ямар ч байсан татвараа төлөөд л яваад байгаа. Тэгээд дарамт янз янзын дарамтаа л багасгачих гэж байна шүү дээ. Хяналт шалгалтаа багасгачих. Тэгвэл бид нар татвараа төлөөд л явъя гэдэг ийм л юман дээр манай хувийн хэвшлийнхэн байж байгаа.

Гэвч харамсалтай нь өнөөдөр төр бол тэр бизнесүүдийг бүгдийг нь зөвхөн МАН-д үйлчлэх ёстой гэдэг ийм байр сууринаас хандаж л бүгдийг нь дарамталж байгаа ийм зүйл хэрээс хэтэрч байна. Тэгээд манай бизнесийнхэн ч гэсэн бас их аймхай болсон байна. Хэвлэлийнхнийгээ дараад авчихсан шиг бизнесийнхэн ерөөсөө юм ярьж эсэргүүцэхээ больсон. Тэгээд л энэ нэг сонгуулиар өөрчлөгдөөсэй гэдэг ийм нэг дотооддоо бодолтой ингээд л байж байгаа. Тийм учраас энэ айдастай байгаа бол энэ бизнесийг хамгаалъя. Янз янзын асуудал байгаа бол, авлигал хээл хахууль байгаа бол тэр бүх зүйлээ бид нарт хэлээч, бид нар хамгаалъя. Энэ АН. Ялангуяа би бол ямарваа нэгэн байдлаар мэдээллийг бол огт алдахгүйгээр энэ та бүхний зовлонг бүгдийг нь ярьж хэлэхэд бол бэлэн байж байна. Үнэхээр хүнд байна.

Ковидын дараа арай гэж өндийх гэж байгаа тэр бизнесийг бүх төрлийн замаар бүгдэнгээр нь дарамтална гэдэг бол үнэхээр хүнд байгаад байгаа юм. Тэгээд энэ Худалдаа, аж үйлдвэрийн танхим гээд байгууллага байдаг тэр нь ерөөсөө юу ч хийдэггүй. Бизнесийнхнийг чөлөөтэй бизнес эрхлэх, тэр авлигаас ангид байх тэр юмандаа л тал дээр нь ерөөсөө хөдөлдөггүй. Дарга нь бизнесийнхнийг дарамталдаг МАН-ын жагсаалтад ороод нуугдчихсан ийм нөхцөл байдалтай байна. Тийм учраас та нарыг та нарт бас тодорхой хэмжээний асуудлаа хэлдэг тийм хүн хэрэгтэй байгаа байх. Би тэр болгон дээр чинь энэ Их Хурлын индэр дээрээс үгээ хэлээд та нарыг хамгаалаад явахад бэлэн байгаа шүү гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Эрхэм нөхөд өө, бас нэг хэдэн зүйлийн талаар ярья гэж бодож байна. Маргааш Эх үрсийн баярын өдөр 6 сарын 1. Тэгээд олон мянган ээжүүддээ манай Монгол Улсын хүн амын 51 хувийг эзэлдэг ээжүүддээ, Монгол Улсын гэрэлт ирээдүй болсон хүүхдүүддээ, манай бас энэ 76-н 12 болсон энэ сайхан Монголын саран гуа ээжүүддээ маргаашийн Эх үрсийн баярын мэндийг хүргэе. Ачааны хамгийн хүндийг үүрч явдаг бол манай Монголын ээжүүд байгаа шүү. Тэгээд хэд хэдэн хуулийг бид нар хэлэлцэж байгаа ээжүүдийн талаар. Тэр Ерөнхийлөгчөөс л нэг хааяа гайгүй юм орж ирэх юм даа. Тэр одонтой ээжүүдийг 100, 150 мянга ч билүү нэг хоёрын хооронд мөнгө өгөөд байдаг юм тэрийгээ арай ахиу болгож байгаа 200, 400. Энийг яаралтай баталчихмаар байх юм. Бага ч гэсэн яах вэ.

Нөгөө тэр цалинтай ээж гээд хачин, хачин юм яриад байдаг. Тэгээд 3 нас хүртэл 50 мянган төгрөг өгдөг, тэрийг яаж цалин гэх юм бэ? Үгүй ээ яг тэр цалинтай болгочихъё л доо хэдүүлээ. Энэ их авлигын мөнгө урсаж байхад. Энэ бол уурхайн бүтээгдэхүүн үнэтэй байхад энийг энэ чуулган хийчихмээр байх юм. Тэр тусмаа та нар социалист чиг баримжаатай халамжийг хавтгайруулдаг нам. Тэгээд хийвэл хийсэн юм шиг хүнээ олсон ийм юмаа хийчихмээр байх юм. Энэ зүйлийг бас би нэг та бүхэнд ард түмний амьдралд үлдсэн ийм юм хийчхээч гэж энэ чуулганы эцсийн чуулганаар хүсээж байна.

Нөгөө талаар бол энэ малчдын талаар өнөөдөр ч гэсэн бас хуулиуд орж ирж байна. Энэ их хачин юм болж байна. Тэр шинэ хоршоо гэдэг чинь яг л Өвөр Монголыг бид нар давтаж байна шүү дээ. Малчдыг бэлчээргүй болгох гэж байна. Малчдыг ерөөсөө хуучин тэр уламжлалт мал аж ахуйгүй, бэлчээрийн мал аж ахуй,

тэрний шал эсрэг үйлдлүүд явж байна. Тэгээд 50 сая төгрөг өгнө нэг хүнд нь гээд л, нийлээд л нэг 10 хүн 500 сая төгрөг авна гэж тэрүүгээр юу хийх вэ дээ. Үр дүнтэй юм болж чадах уу? Тэрийг малчид маань ойлгоод эхэлчихжээ.

Энэ уул уурхайгаас их мөнгө орж ирж байна. Энэ авлигад урсаж байгаа төр төрийн оролцоо 40, 50, 60, 70 хувь болчихсон энэ нөхцөлд бид нар энэ 30, 40 хувь нь бараг 50 хувь нь ядуу байна Монголын ард түмэн, хэдхэн хүн л баян байна. Тэгэхээр энэ уул уурхайгаас орж ирж байгаа орлогоо ер нь зээлийг нэг удаа тэглэчихвэл яадаг юм бэ дээ. Та нар ч тэр тэтгэврийн зээлийг тэглэлээ барилаа гээд л ингээд байдаг байсан. Тэгээд болдог бүтдэг, тэр хууль номдоо нийцдэг юм бол та нар угаасаа л тийм юм хийдэг юм чинь хийчих л дээ. Энийг нэг хэлчихье. Үнэхээр сэтгэл байгаа бол.

3 дугаарт энэ хувийн хэвшил, баялаг бүтээгчид энэ хүмүүсийг энэ гадна, дотнын нөхцөл байдал ч гэсэн хүнд байна. Ооёо Хуяа нар нь нийлчихсэн юм шиг байна лээ. Ийм үед бас Монгол Улсын тусгаар тогтнол ганхаж эхэлдэг л дээ. Яг 100 жилийн өмнө ямар байлаа. Тэгээд энэ 10 дугаар Богдтой холбоотой асуудал байна. Арай гэж бид нар 10 дугаар Богдоо тодруулсан. Гэтэл тэр 10 дугаар богдын эмээ, ээж гаднын захиалгаар гар хөл болж хэн орон шоронд хийж байна, хэн зогсоо зайгүй хэвлэл мэдээллээр дарамталж байна. Энийг тогтоо. Яг ард нь хэн байгаа юм бэ? Эрх мэдэлтэй хүмүүс л байгаа. Энийг тогтоо. Энэ бол Монгол төрийн хийх ёстой ажил гэж би бодож байна.

Аягүй л бол энэ чуулганы дараа МАН-д бол сайн, сайн хүмүүс бий. Би нэр заагаад яах вэ зарим нэг хүмүүс гомдох байх. Манай намд ч гэсэн танай, намд ч гэсэн хэцүү улсууд байна. Аягүй л бол энэ сонгуулийн дараа Шанхайн хамтын байгууллагад орно гээд л гүйнэ. Тусгаар тогтнолоо алдана. Намайг үг хэлдэг шүүмжилдэг болохоор аягүй бол миний амь насанд халдана энэ

сонгуулиар. Энийг зохих байгууллагууд нь анхааралдаа аваарай. Хэн гэдэг нь хэлсэн ч болж байна би. Тэгээд яах вэ дээ тэгээд Түшээт ханы, Түшээт гүний хошуу л даа манай аав Шанхын хийдийн Хархорины. Тэнд бурхан шашин дэлгэрч.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалтыг жич зарлана.

Нэг. Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар /Засгийн газар 2024.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/

Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслийг болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлж хэлэлцэнэ. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа. Санал хураалт явуулна. Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай. Ажлын хэсгийн гишүүдийг оруулна. Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Байнгын хорооны саналаар Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах

тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт. Бүртгэлийн санал хураалт эхлээд явуулж байна. Өглөөний анхны санал хураалт, бүртгэлийн санал хураалт. Бүртгэлд ороогүй улсуудыг тасалсанд тооцно. Жаргалмаа гишүүн орж ирж байна. Санал хураалт явуулна. Сая Хүрэлбаатар гишүүн, хэн гишүүн 2 байсан яачхав, Ганбат гишүүн. Санал хураалт явуулъя. Санал хураалт. 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

10.51 цаг

Хоёр. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Дараагийн асуудалд орно. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Оруулж ирье, оруулъя. Нямбаатар дарга. Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж хариулт авч дууссан. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтад явуулна.

Зарчмын зөрүүтэй 78 санал байгаа. Санал хураалтад бэлтгэе.

Ажлын хэсэг Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Цогтын Баярбат Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сүхбаатарын Цогтгэрэл Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, Пүрэвжавын Сайнзориг Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч, Дугаржавын Амгалан НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Дорждэрэмийн Цолмон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх, Хааш-Эрдэнийн Сүрэнхорол, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Сүхээгийн Тэнгис Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, Батсүхийн Баярмаа БОАЖЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Бат-Эрдэнийн Төрбат ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын шинжээч, Алдаржавхлан алга байна. Билэгсайхан алга байна. Мөнхөөгийн Батбаяр алга байна. Баатарын Гүнболд алга байна. Цогтгэрэлийн Батгэрэл, Баянболд, Дэмбэрэлийн Баялагцэнгэл алга байна. Сумьяасүрэнгийн Энхжаргал алга байна. Жижгээгийн Ганболд Сэлэнгэ аймгийн Дулаанхаан хотын тосгоны захирагч. Доржсүрэнгийн Эрдэнэбулган Сэлэнгэ аймгийн Бугант тосгоны захирагч. Амгаланбаатарын Сод-Эрдэнэ алга байна.

Санал хураалт явуулъя. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Нэг.ТББХ дэмжсэн санал.

Төслийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Нийслэл Улаанбаатар хот, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны тухайлан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал, Энхтайваны Бат-Амгалан, Жижгидийн Батжаргал, Баагаагийн Баттөмөр, Гонгорын Дамдинням, Тогмидын Доржжанд, Цэндийн Мөнх-Оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Ганзоригийн Тэмүүлэн. Одонтуяа гишүүн саналаараа ажлын хэсгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс гарсан болно. Санал хураалт явуулъя. Санал хураалт. 21 гишүүн 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “оршин суугчтай,” гэсний дараа “эсхүл байнгын оршин суугчтай байхаар төлөвлөсөн,” гэж нэмж, 4.3 дахь хэсгийн “эдийн засаг, нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, хэрэгжүүлэх” гэснийг “болон бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, газар зүйн байршил,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дангаараа” гэснийг “нэг” гэж, 5.5 дахь хэсгийн “энэ хуулийн 5.2-т заасныг” гэснийг “тосгоны оноосон нэр, эдэлбэр газрын хэмжээ, байршил, заагийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.1.9, 6.1.10, 6.1.11 дэх заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“6.1.9.төр, хувийн хэвшилийн түншлэлийг дэмжих;

6.1.10.алслагдсан хот, тосгонд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх;

6.1.11.хот, тосгоны зохион байгуулалт, тэдгээрийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, хотын зэрэглэл тогтоохтой холбоотой шийдвэр гаргахад их өгөгдлийн тооцоололд суурилах, дэвшилтэт технологийг ашиглах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 26 гишүүн дэмжиж, 63,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн, 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсгийн “Хотын” гэснийг “Хот, тосгоны” гэж, 3 дугаар бүлгийн болон 14 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 14.1 дэх хэсгийн, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн, мөн зүйлийн 17.7 дахь хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж өөрчилж, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг бүхэлд нь, 18 дугаар зүйлийн гарчгийн “Улсын зэрэглэлтэй хотын” гэснийг, 18.2 дахь хэсгийн “хотын” гэснийг тус тус хасаж, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, дугаарлалтыг өөрчлөх:

“10.2.Тосгоны удирдлага дараах тогтолцоотой байна:

10.2.1.тосгоны Зөвлөл;

10.2.2.тосгоны Захирагч.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 11 дүгээр зүйлийн “хотын хороо” гэснийг “хотын хороолол” гэж өөрчилж, төслийн бусад зүйл, хэсэг, заалтын “хотын хороо” гэснийг “хотын хороолол” гэж тохиолдол бүрд агуулгад нийцүүлэн өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 25 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ.

7.Төсөлд доор дурдсан агуулгатай 14 дүгээр зүйл нэмэх:

“14 дүгээр зүйл.Хот, тосгоны хөгжлийг дэмжихэд харилцаа холбоо, мэдээллийн технологи ашиглах

14.1.Хот, тосгоны удирдлага нь хот, тосгоны чиг үүргийг хэрэгжүүлэхэд харилцаа холбоо, мэдээллийн технологийг дараах хэлбэрээр ашиглана:

14.1.1.инновац, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, юмсын интернэт зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;

14.1.1.2.шийдвэр гаргах аас өмнө тухайн шийдвэрийг цахим орчинд урьдчилан загварчилж, үр дүнг тооцоолох;

14.1.3.дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд зохицуулалтын сэндрокс орчинд туршиж, оршин суугчийн саналыг авах;

14.1.4.харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд бүтэц, мэдээллийн системийг бий болгох, түүний тасралтгүй, найдвартай байдал болон кибер аюулгүй байдлыг хангах, саадгүй мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх;

14.1.5.хотод цугларсан мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл болгон, олон нийтэд ил тод байршуулах.

14.2.Энэ хуулийн 14.1.3-т заасан зохицуулалтын сэндрокс орчныг бий болгох, үйл ажиллагаа явуулах журмыг Засгийн газар батална.

14.3.Хот, тосгон нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасан шаардлагыг хангасан мэдээллийн систем, түүний дэд бүтцийг ашиглана.

Тайлбар: - Энэ зүйлд заасан “юмсын интернэт” гэж эд зүйлсийг цахим орчинд хянах, удирдах зорилгоор өгөгдлийг

цуглуулж, дамжуулах зориулалт бүхий мэдрэгч болон бусад төхөөрөмж, программ хангамж, тэдгээрийг хооронд нь холбосон сүлжээг ойлгоно.

-Энэ зүйлд заасан “зохицуулалтын сэндбокс орчин” гэж шинээр нэвтэрч байгаа технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчин, тодорхой цаг хугацаанд туршихыг ойлгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 29 гишүүн дэмжиж, 67,4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Найруулга дээр нь эцсийн найруулга дээр анхаараарай. Эд юмыг интернэтийг сүлжээ гэж ойлгоно гэж сүүлд нь тайлбарлаж болно шүү дээ.

8.Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.6 дахь хэсэг нэмэх:

“14.6.Тосгоны Зөвлөлийн гишүүнийг оршин суугчдаас сонгох ба Зөвлөлийн гишүүний тоо 9 байна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 43 гишүүн оролцож, 29, 30 гишүүн дэмжиж 69,8 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Зөвлөл” гэсний өмнө “Хотын” гэж нэмж, 15.3, 15.4 дэх хэсгийн “Зөвлөлийн” гэсний өмнөх “Хотын” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 15.3 дахь хэсэг нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“15.3.Тосгоны Зөвлөл энэ хуулийн 15.1.4-т заасан албан татварын хувь хэмжээг тогтоохоос болон 15.1.8-д зааснаас бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

10.Төслийн 15 дугаар зүйлийн 15.3.2 дахь заалтын “улсын зэрэглэлтэй хотын Захирагч” гэсний дараа “, тосгоны Зөвлөлийг харьяалах сум, дүүргийн Засаг дарга, эсхүл орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагч” гэж нэмэх. Санал

гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 60,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Түрүүнийх 67,5 хувь гэж зарласан л даа.

11.Төслийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “буюу” гэснийг “, эсхүл” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Бат-Амгалан гишүүн санал хураалтаа, саналаа өг. 22 гишүүн дэмжиж, 51,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “24.1.4,” гэснийг, “хотын” гэснийг тус тус хасаж, мөн хэсгийн “шийдвэрлэнэ” гэснийг “шийдвэрлэх ба 24.1.4-т заасан тохиолдолд огцорсонд тооцно” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 67,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14, 13.Төслийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийн “томилно” гэснийг “томилж, чөлөөлнө” гэж, мөн зүйлийн 28.9 дэх хэсгийн “Хотын” гэснийг “Хот, тосгоны” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 62,3 саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1.51 дэх заалтыг бүхэлд нь, 29.1.3 дахь заалтын “энэ хуулийн 29.1.2-т заасан асуудлаар” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 65,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1.45 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 67,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “, 30.1.4-д заасан тохиолдолд огцруулах” гэснийг, 30.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 10.2-т зааснаас бусад” гэснийг хасаж, 30.3 дахь хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгон, хотын хорооны” гэж өөрчилж, 30.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 30.7 дахь хэсэг болгох:

“30.7.Гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон тохиолдолд хот, тосгоны, хот, тосгон, хотын хорооны захирагчийг огцорсонд тооцно.” Санал гаргасан ажлын хэсэг. Энэ хорооны захирагчтай болж байгаа юм уу? Хороолол биш л дээ хороо гэж бичигдсэн байна. Санал хураалт. 62,8 хувийн саналаар дэмжигдлээ. Ажлын хэсэг бол энийг хорооллын гэж нэрлэж байна шүү. Хотын хорооных биш хотын хорооллынх юм байна шүү. Найруулга дээр янзал.

17.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “хотын Захирагчийг дээд шатны Захирагч, Засаг дарга, эсхүл Ерөнхий сайд” гэснийг “улсын зэрэглэлтэй хотын Захирагчийг Ерөнхий сайд, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагчийг харьяалах дээд шатны Захирагч, эсхүл Засаг дарга” гэж, 31.1.4 дэх заалтын “зохих ёсоор” гэснийг “удаа дараа” гэж өөрчилж, 31.1 дэх хэсгийг 30.4 дэх хэсэг болгон шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 62,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энийг сайн харахгүй бол бас энэ чинь нийт иргэдээс сонгогдоод тэгээд дараа нь дээд шатны Засаг дарга нь батламжлахгүй гээд байдаг юм нь.

18.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1.4, 31.1.5, 31.1.6 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, Улсын Их Хурлын Гочоогийн Ганболд, санал хураалт. 60,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төслийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг болгох:

“30.5.Хотын хорооны захирагчийг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө хотын захирагч энэ хуулийн 30.1.2, 30.1.3, 30.1.5-д заасан үндэслэлээр чөлөөлж, 31.1.1, 31.1.4, 31.1.5, 31.1.6-д заасан үндэслэлээр огцруулна.” Санал гаргасан ажлын хэсэг,

санал хураалт. Хотын хорооны захирагч л гэж болгочоод байх юм. Гэхдээ хорооны дарга гэж явдаггүй зүгээр яг Нийслэлийн захирагч гэдэг шиг захирагч гэж явах юм уу? Хотын хорооллын дарга гэж явж болдоггүй юм уу? Эцсийн хэлэлцүүлэг дээрээ хотын хороо гэдгээ хороолол гэж найруулахгүй бол энэ чинь өөрчлөлт, хорооны захирагч, нийслэлийн захирагч гээд зэрэгцсэн захирагч байх юм уу хорооны дарга, хорооллын дарга байх юм уу? Саналыг, 65,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Төслийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 33.2, 33.3 дахь хэсэг нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“33.2.Хотын хорооны Захирагчийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

33.3.Хотын хорооны Захирагчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон бол шинээр сонгогдох Захирагчийн бүрэн эрхийн хугацаа нь өмнөх Захирагчийн бүрэн эрхийн үлдсэн хугацаатай тэнцүү байна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 61,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийн “Тосгоны Захирагчаар дараах шаардлагыг хангасан иргэнийг” гэснийг “Тосгоны Захирагчаар дараах шаардлагыг хангасан иргэнийг тухайн тосгоны оршин суугчдаас сонгож,” гэж, “томилно” гэснийг “батламжилна” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Төсөлд доор дурдсан агуулгатай 34.5 дахь хэсэг нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“34.5.Тосгоны Захирагчийн үйл ажиллагааны зардлыг тухайн тосгонд хуваарилсан төсвөөс санхүүжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал

хураалт. 59,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 30 дугаар зүйлийн 30.6 дахь хэсэг болгох:

“30.6.Тосгоны захирагчийг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө тухайн тосгоны Зөвлөл энэ хуулийн 30.1.2, 30.1.3, 30.1.5-д заасан үндэслэлээр чөлөөлж, 31.1.1, 31.1.2, 31.1.4, 31.1.5, 31.1.6-д заасан үндэслэлээр огцруулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

24.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.7 дахь заалтыг хасаж, 35.1.8 дахь заалтын “санал гаргах,” гэсний дараа “төлөвлөгөөг батлуулах” гэж нэмж, 35.1.2 дахь заалтын “иууд” гэснийг “ерөнхийлөн” гэж, 35.1.20 дахь заалтын “харьяалах сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хотын” гэснийг “тосгоны” гэж, 35.1.28 дахь заалтын “хотын” гэснийг “тосгоны” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Төслийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 36.3 дахь хэсэг нэмэх:

“36.3.Хот, тосгоныг хөгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа эрхлэхэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх асуудлыг тухайн төрлийн татварын хуулиар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 63,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Төслийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “хот нь аймаг, нийслэлийн, тосгон нь аймгийн” гэснийг “хот болон тосгон нь аймаг, нийслэлийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 68,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Төслийн 40 дүгээр зүйлийн гарчгийн “Чөлөөт бүс” гэсний дараа “, эдийн засгийн тусгай бүс” гэж нэмж, 40.1 дэх хэсгийн “чөлөөт бүстэй” гэснийг “чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүстэй” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 40.3 дахь хэсэг нэмэх:

“40.3.Хотын эдийн засгийн тусгай бүстэй холбогдох харилцааг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 38-45 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 61,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Хот, тосгоны Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1.2 дахь заалтын “бохир ус,” гэсний дараа “цэвэрлэх байгууламж,” гэж нэмж, 41.3 дахь хэсгийн “сан байгуулах, түүнийг” гэснийг “сангийн хөрөнгийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Төслийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тохиолдол бүрд өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Төслийн 46 дугаар зүйлийн 46.3.3 дахь заалтын “засаг захиргааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт, удирдлагын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Төслийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсгийн, 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийн “хотын Зөвлөл, тосгоны Захирагч” гэснийг “хот, тосгоны Зөвлөл” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, шилэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Бат-Амгалан гишүүнд үг өгөхгүй. Өчигдөр, уржигдар хотын гишүүд санал хураалтад оролцоогүй, энэ хуулийг их удааж байгаа учраас. 61,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал. 1.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “тэдгээрийн” гэснийг “хотын” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтын “барилга,” гэснийг “барилгын болон бусад” гэж, 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийн, 23 дугаар зүйлийн 23.1.3 дахь заалтын “хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар” гэснийг “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр” гэж тус тус, 29 дүгээр зүйлийн 29.1.32 дахь заалтын, 35 дугаар зүйлийн 35.1.16 дахь заалтын “нийгэм хамгаалал, халамж, гэснийг “нийгмийн хамгаалал” гэж тус тус, 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсгийн, 19 дүгээр зүйлийн 19.1.8 дахь заалтын, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн, 22 дугаар зүйлийн 22.1.7 дахь заалтын, 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтын, 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тус тус, 17 дугаар зүйлийн 17.8 дахь хэсгийн “хэлэлцүүлэхээр” гэснийг “хэлэлцүүлэх санал” гэж, 17.9 дэх хэсгийн “хоногийн” гэснийг “өдрийн” гэж, 17.10 дахь хэсгийн “хуралдах тохиолдолд” гэснийг “хуралдахад” гэж, 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийн “хэсгийн заалт” гэснийг “зүйл, хэсэг, заалт” гэж, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “заасны дагуу нэр дэвшигчдийн” гэснийг “заасан нууц санал хураалтаар нэр дэвшигчийн” гэж, 20.5 дахь хэсгийн “хүний” гэснийг “нэр дэвшигчийн” гэж, 20.6 дахь хэсгийн “хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн” гэснийг “хангалтгүй

биелүүлсэн гэж үзсэн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.5.1 дэх хэсгийн “хотод” гэснийг “хот, тосгонд” гэж, 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтын “хуралд” гэснийг “хуралдаанд” гэж, 22.2.1 дэх заалтын “гомдлыг” гэснийг “гомдолд” гэж, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “Хотыг өдөр тутамд удирдах” гэснийг “Хотын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.48 дахь заалтын, 35 дугаар зүйлийн 35.1.25 дахь заалтын “үйлчилгээг зохион байгуулж байгаад” гэснийг “үйлчилгээний зохион байгуулалтад” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.50 дахь заалтын “хот” гэснийг “хотын” гэж, 29.1.53 дахь заалтын “байгууллага” гэснийг “байгууллагын” гэж, “үүргээ хэрхэн биелүүлж байгаад” гэснийг “үүргийн биелэлтэд” гэж, 29.1.54 дэх заалтын “газарт” гэснийг “газрын хэмжээнд” гэж, 30 дугаар зүйлийн гарчгийн “Хотын” гэснийг “Хот, тосгон, хотын хорооны” гэж, 30.1 дэх хэсгийн “Захирагчийн бүрэн эрх” гэснийг “захирагчийг” гэж, “дуусгавар болно” гэснийг “чөлөөлнө” гэж, 31 дүгээр зүйлийн 31.1.1, 31.1.2 дахь заалтын “хот байгуулалтын” гэснийг “хотын” гэж тус тус, 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтын “хэрэгцээний” гэснийг “хэрэглээний” гэж, 35.1.17 дахь заалтын, 35.1.8, 35.1.28 дахь заалтын “хотын” гэснийг “тосгоны” гэж, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “хот” гэснийг “хотын” гэж, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийн “хүмүүст” гэснийг “хүнд” гэж, “хүмүүсийг” гэснийг “хүнийг” гэж өөрчилж, төслийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийг 19 дүгээр зүйлийн 19.1.10 дахь заалт болгон, 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийг 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэг болгон, 30 дугаар зүйлийг 35 дугаар зүйл болгон тус тус шилжүүлэх.

2.Төслийн 15 дугаар зүйлийн 15.3.2 дахь заалтын “хотод” гэснийг, 25 дугаар зүйлийн гарчгийн, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “Хотын” гэснийг тус тус, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалтын “явуулж буй” гэснийг, 17 дугаар зүйлийн

17.8 дахь хэсгийн “асуудал санаачлан” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийн “хэсгийн” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.5.1 дэх заалтын “ориин суугч” гэснийг, 33 дугаар зүйлийн гарчгийн “, бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох” гэснийг, 33.1.3 дахь заалтын “асуудлаар” гэсний дараах “захиран зарцуулах” гэснийг, 41 дүгээр зүйлийн 41.1.1 дэх заалтын “болон” гэснийг, 51 дүгээр зүйлийн 51.2.2 дахь заалтын “хот, тосгоны” гэснийг хасах.

3.Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Зөвлөл” гэсний өмнө “хотын” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “гэрээний” гэсний өмнө “нийтийн эрх зүйн” гэж, 28 дугаар зүйлийн 28.6, 28.7 дахь хэсгийн “Захирагчийн” гэсний өмнө, 28.8 дахь хэсгийн “Захирагч” гэсний өмнө “Хотын” гэж тус тус, 43 дугаар зүйлийн гарчгийн “Зөвлөл” гэсний өмнө “Хотын” гэж, 51 дүгээр зүйлийн 51.2.2 дахь заалтын “Захирагчийн” гэсний өмнө “хот, тосгоны” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ хуулийн төсөл боловсруулсан байлгүй Цолмон тэр ахлах зөвлөх, Сайнзориг энэ тэр ийм их найруулгын санал гарч байна, ийм санал гарч байна гэдэг бол хуулийн төсөл их муу боловсруулсан байна гэсэн үг шүү. Одоо ч гэсэн энэ үг дотор нь бол зөндөө алдаа явж байна. Зарим агуулгын шинжтэй ч юм орсон явж байна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал байна. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн хүснэгтийн 3 дахь заалтын “Төв аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал” гэснийг “Төв аймгийн Зуунмод сумын иргэдийн

төлөөлөгчдийн хурал” гэж, мөн заалтын “Төв аймгийн засаг дарга” гэснийг “Төв аймгийн Зуунмод сумын засаг дарга” гэж, мөн хүснэгтийн 10 дахь заалтын “Чингэлтэй хот, Сэлбэ хотын Зөвлөл” гэснийг “Чингэлтэй хотын Зөвлөл” гэж, мөн хүснэгтийн 14 дэх заалтын “Баян-Өлгийн аймгийн Засаг дарга” гэснийг “Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Засаг дарга” гэж, мөн хүснэгтийн 15 дахь заалтын “Баянхонгор аймгийн Засаг дарга” гэснийг “Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Засаг дарга” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 67,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн хүснэгтийн хотын нэр баганад “Хархорин хот” гэж, “Хотын Зөвлөл, Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага баганад “Өвөрхангай аймгийн Хархорин сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал”, “Өвөрхангай аймгийн Хархорин сумын Засаг дарга”, гэж, Хотын удирдлага баганад “Хархорин хотын Зөвлөл”, “Хархорин хотын Захирагч” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд, Дуламдоржийн Тогтохсүрэн, Содномын Чинзориг. Санал хураалт. 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/16 дугаар зүйлийн 16.2.11 дэх заалт:

“1.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ байгаль орчин болон байгалийн нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлөхөд шаардагдах хөрөнгийг тухайн төсөл, арга хэмжээний төсөвт тусгуулах.”

2/49 дүгээр зүйлийн 49.9 дэх хэсэг:

“9.Аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлээс хэрэгжүүлж байгаа Гамшигаас хамгаалах тухай хуулийн 4.1.7, 4.1.8-д заасан үйл ажиллагааг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхөн төлбөрөөс чөлөөлнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 68,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 68 дугаар зүйлийн 68.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“68.5.Энэ хуулийн 68.1-д заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын чиг үүргийг шилжүүлсэнтэй холбогдуулан тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төрийн болон орон нутгийн өмчийг хуульд заасны дагуу хот, тосгонд шилжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 68,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 68 дугаар зүйлийн 68.6 дахь хэсгийн “Хотын зөвлөл” гэснийг “Хот, тосгоны зөвлөл” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 63,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 3 дугаар зүйлийн “24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.2, 24.3.3 дахь заалтын” гэснийг “24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.2, 24.3.3, 24.3.4 дэх заалт, 24.5 дахь хэсгийн, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 25.4.3 дахь заалтын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 буюу 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хот, тосгоны эрх зүйн байдлын дагуу байгуулагдсан” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 буюу 77 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 68.4-т заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрийн удирдлагын чиг үүргийг шилжүүлсэн бол энэ хуульд заасан иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхийг тухайн хот, тосгоны зөвлөл хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 70,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3/78 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 68.4-т заасны дагуу засаг захиргаа, нутаг

дэвсгэрийн нэгжсийн төрийн удирдлагын чиг үүргийг шилжүүлсэн бол энэ хуульд заасан засаг даргын бүрэн эрхийг тухайн хот, тосгоны захирагч хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 68,2 хувийн саналаар санал дэмжигдлээ. 3.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх: 3-г хураасан уу.

Зургаа.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “тухайн хотод” гэснийг “тухайн шүүхэд” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал, санал хураалт. 68,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гамшигаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Гамшигаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 68,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Энэ миний кноп ажилласангүй. Энэ санал хураалт хүчингүй, энэ яагаад санал хураалтыг таслалдуулаад байна вэ? Яагаад явахгүй байна вэ? Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Программ гацаад саяын санал хураалт явагдсангүй байна л даа. Дахиад хэлээд дахиад явахгүй болчихлоо. Болж байна уу? Сая яасан бэ? Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Энэ ийм байж болохгүй. Төрийн байгуулалтын байнгын хороонд бид нар их олон талаас нь ярьсан, ийм байж болохгүй гэдгийг ярьсан. Энийг болих хэрэгтэй. Төв аймгийн, Завханы, Говь-Алтайн, Увсын, Хөвсгөлийн, Дорнодын энэ тусгай хамгаалалттай газруудын асуудлыг Улаанбаатар хот шийдэж байж таарахгүй биз дээ энэ чинь. Тэгэхээр энийг даргаа дахиж Байнгын хороон дээр бид нар ярина. Тогтолцоо бүхэлдээ эвдэж байгаа юм.

Дэлхийн олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг гэж байна. Үүрэг гэж байна. Монгол Улс хэчнээн хэмжээний газраа тусгай хамгаалалтад авч олон улсын өмнө хүлээчихсэн үүрэг бий. Хурал дээр ярьж байхад Улаанбаатар хотын хувьд бол Богд-Уулаа тойрсон асуудлаа метро бусад юмтайгаа холбоод, Төв аймгийн урд талын хэсэгтэй холбоод, хойд талын хэсэгтэй нь холбоод энэ асуудлыг нь шийдэж болно гэдэг тал дээр ярьсан. Улсын Их Хурлаас тогтоол гарчихсан байж байгаа. Тэгэхэд энэ тогтолцоог бүхэлд нь эвдээд, Монголын бүх тусгай хамгаалалттай газрыг Улаанбаатар хотын захиргаа мэдэж шийдвэр гаргаж байна гэж юу гэсэн үг юм бэ? Ийм байж болохгүй шүү дээ. Тэгэхээр үүнийг та чиглэл өг, дахиж ярь гэж хэл. Тийм.

Үгүй ээ энэ би ярьж байна шүү дээ бүх аймгууд орно, ингээд явчихвал. Тусгай хамгаалалттай газрын тухай хуулийг тэгвэл бүхэлд нь хүчингүй болгох хэрэгтэй одоо. Бид дараагийн тэгвэл Байнгын хороон дээр тийм санал оруулж ирнэ Төрийн байгуулалтын байнгын хорооноос. Үүнийг ингээд дэмжээд явбал Тусгай

хамгаалалттай газрын тухай, Байгаль хамгаалах тухай бүх хуулиудыг хүчингүй болгох санал дагуулж орж ирнэ. Үүнийгээ та чиглэл өг даргаа. Ийм байж болохгүй.

Олон асуудал дэмжиж байгаа шүү Улаанбаатар дээр бид нар. Заримыг нь нүдээ аниад л дэмжиж байгаа. Тэгэхэд ийм тогтолцоог бүхэлд нь өөрчилсөн Монгол Улсын хууль тогтоомж, Үндсэн хууль, бусад юмнуудыг зөрчсөн ийм юмнуудыг болохгүй шүү дээ. Гишүүдэд битгий буруу мэдээлэл өгөөд бай л даа. Дахиад хэллээ шүү үүнийг дарга чиглэл өг. Байнгын хороон дээр ярина. Ингэвэл дараа нь бид нар дагуулаад Тусгай хамгаалалттай газрын тухай, ер нь тусгай хамгаалалт гэдэг ойлголтыг байхгүй болгоод, тэр хуулиудыг нь санаачлаад хамт оруулж ирнэ шүү. Энэ арай болохгүй. Бид нар олон юм дэмжиж байгаа шүү Нямбаатар даргаа. Мааш олон юмыг дэмжиж байгаа. Болохгүй байгаа юмнуудыг нь бусад хуульд нь өөрчлөлт, нэмэлт хийж байгаад дэмжээд явж байгаа. Эрх байхгүй, тийм. Ажлын хэсгийн дарга үгээ хэлээч дээ. Хариуцсан Улаанбаатараас сонгогдсон гишүүн тийм. Тэр хуулийг нь, хуулийг нь та нар уншаад үзээрэй. Сая эсрэг өгсөн санал өгсөн гишүүд. Та чиглэл өг.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал гишүүн. Энэ нэгэнт хураагдсан саналаар чиглэл өгөх дэг байхгүй л дээ. Энийг горимын санал гаргаж хүчингүй болгоод, тэгээд дахин санал хураалт дээр дэмжчихээд, тэгээд тэрнийг болбол гүйцээн боловсруулах, ахиж ярих тийм чиглэл өгч болно. Тэгээд тэр Байнгын хороон дээрээ, ТББХ-н даргын хэлж байгаа үг явах юм бол энэ хууль чинь тэр чигээрээ явахгүй болох нь байна шүү, хугацаа байхгүй болсон шүү. Ер нь гишүүд одоо байна шүү дээ өнөөдөр нэлээн шахаж хуралдаад, тэр олон маргааш Эх үрсийн баярын өдөр, Олон хүүхэдтэй ээжийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг эцэслэн батлах хэрэгтэй байна 39 гишүүнээр. Өнөөдөр хуулиудаа эцэслэн батална энэний дараа.

Тийм учраас жоохон ажил хэрэгч хандмаар байна. Бас юмыг бас хууль дэг журмын дагуу байхгүй болбол энэ хуулийг бас ингээж завхруулж болохгүй. Ням-Осорын Учрал гишүүн.

Н.Учрал: Ажлын хэсэг байгуулагдсан. Тэгээд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ хуулийг болбол олон талаас нь ярьсан. Тэгээд мэргэжлийн яам ч гэсэн саналаа хэлсэн. Тэгээд энэ бол олон улсад хүлээсэн үүрэг гэж байгаа, олон улсын гэрээ конвенцод нэгдсэн. Тэгэхээр мэдээж нийслэлийн хэрэгжүүлэх гээд байгаа энэ томоохон төсөл, хөтөлбөрийг болбол ойлгож байгаа. Бид нар бол тэрийг ойлгож байгаа шүү дээ. Гэхдээ яг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг энэ өөрчлөлтийг нь ингээд хараад үзэхээр болбол энэ дотор болбол зөвхөн энэ Богд уулыг тойрсон шинэ суурьшлын бүстэй холбоотой биш, энэ байгалийн цогцолборт газар хязгаарлалт тогтоох, хамгаалалтыг эрхлэх эрхийг нь НЗД-д шилжүүлэх гэдэг ийм бүхэлдээ агуулга ороод ирчихсэн байгаа.

Тийм учраас бид болбол энэ хуулийн төслийг шууд явуулах ямар ч бололцоогүй. Үгүй ээ үгүй, энэ хуулийг нь харахаар тийм шүү дээ. Тэгээд хэдүүлээ ярилцсан шүү дээ. Тэгээд ярилцсан биз дээ. Тэгээд ярилцаад эцсийн үр дүнд хүрээд зөвхөн энийг нь хязгаарлаад ингээд оруулж ирье гээд. Тийм учраас энийг босгож ирээд тусгай хамгаалалттай газрыгаа зөвхөн тэр Богд уулыг тойрсон шинэ суурьшлын бүс дээрээ тэр метро барихтай холбоотой, тэр шинэ төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг шийдээд явъя л гэж ийм л ойлголцолд хүрсэн шүү дээ. Гэтэл энийг бүгдийг нь буцаах боломж бололцоогүй. Тийм учраас би бас энэ ажлын хэсгийн ахлагчийн хувиар би бас асуудалд хариуцлагатай хандаж байна.

Тийм учраас энийгээ дахиж хураалгаад, тэгээд чиглэл өгөөд зөвхөн Богд уултай холбоотой тэр метро барих гээд байгаатай холбоотой дэглэмийн асуудлаа ярь. Тэрнээс биш би та нар ингээд нэг зүгээр ингээд нэг санал хураалт шийдэж болохгүй шүү дээ. Та нар тэр ажлын хэсэг өөрсдөө хариул. Тэр Байгаль орчны яам гэж байгаа юм бол тэр асуудалдаа өөрсдөө хариулаач. Тэрнээс биш өнөөдөр зүгээр нэг ийм энийг босгоё, унагая гэдэг ийм юм ярихгүй. Тийм учраас энийгээ хүчингүй болгоод, эцсийн хэлэлцүүлэг дээрээ Нямбаатар даргын яг яриад байгаатайгаа тэр яг шинэ шинэ төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал дээрээ тухайлан авч үзээд оруулах нэг ийм л гарц байна. Тийм биз дээ. Нямбаатар даргаа унагаагаад тэр сүүлийн асуудал дээр зөвхөн энийгээ хязгаарлаад оруулж ирье л гэдэг ийм л саналыг Их Хурлын даргад хэлчихмээр байна шүү дээ.

Г.Занданшатар: Аубакир гишүүн Баян-Өлгий аймгийн бүх дархан цаазтай газрыг бүгдийг нь хотод шийдэх болохыг дэмжиж байгаа санал өгсөн үү? Одоо нэг тэр гишүүн санал гаргах хэрэгтэй байна л даа.

Н.Учрал: Үгүй ээ үгүй, зөвхөн тэр хэсгээ хязгаарлаад тохирёё гэж ажлын хэсэг дээр нийслэлтэй тохирсон шүү дээ. Эцсийн хэлэлцүүлэг дээрээ чиглэл өгчих.

Г.Занданшатар: Горимын санал гаргая. Б.Энх-Амгалан, Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн говийн дархан цаазтай газар, горимын санал гаргачих, тэгээд дахиж санал хураалт явуулъя.

Б.Энх-Амгалан: Миний энэ төхөөрөмж ажилласангүй. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөх горимын санал хураалт явуулж өгөхийг хүсэж байна. Тийм.

Г.Занданшатар: Үгүй ээ үгүй, эхлээд энэ санал хураалтыг хүчингүйд тооцох болно. Ингээд Бямбасүрэнгийн Энх-

Амгалан гишүүний гаргасан горимын саналаар өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Пүрэвдорж гишүүнээ, Пүрэвдорж гишүүн. Ингээд энэ өмнөх санал хураалт хүчингүй болчихно. Тэгж байгаад дараа нь дахин санал хураалт явахгүй бол. Санал. Өмнөх санал хураалтаа хүчингүй болгочихно. Тэгээд санал босоо үлдчихээр нь ахиж санал хураахгүйгээр чиглэл өгөх нь. Санал хураалт. Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Би энэ санал хураалтыг дэмжиж байгаа юм. Тэгээд саяын санал хураалтаар хоцорчихлоо. Саяын санал хураалтыг хүчингүй болгоод, дахиж санал хурааж өгөөч.

Г.Занданшатар: Сандаг-Очир гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 59,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ санал хураалт хүчингүй боллоо. Энэ хуулийн төслийн заалт нь Үндсэн хуулийн зөрчилтэй учраас ТББХ-н дээр гүйцээн боловсруулж, дахин хэлэлцэх чиглэл өгч байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжгийн хууль, холбогдох хууль тогтоомжууд, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиуд, улсын Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хуультай зөрчилдөж байгаа учраас гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

9 дэх заалтыг мөн адил дээдэх Үндсэн хуульд, гүйцээн боловсруулах чиглэл өгч байгаа учраас, буцаачихсан. 10, 9-ийг бас буцаачихлаа.

10.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 7.3.10 дахь заалтын “50-иас доошгүй” гэснийг тохиолдол бүрд “50” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Энэ санал дэмжигдсэнгүй.

Арван нэг.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 2 дугаар зүйлийн “8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “хот, тосгоны Зөвлөл” гэснийг “хотын Зөвлөл” гэж,” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “хот, тосгоны Зөвлөл” гэснийг “хотын Зөвлөл” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмэх:

2/7 дугаар зүйлийн 7.4-7.6 дахь хэсэг:

“7.4.Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын алслагдсан байришилд тухайн хотын газрын зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссаны дагуу баригдсан олон улсын стандартад нийцсэн боловсрол, соёл, нийтийн номын сан, нийгмийн халамжийн үйлчилгээ, ахмадын төв, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, спортын барилга, байгууламжийн үл хөдлөх эд хөрөнгөд ногдуулах албан татварыг 5 жилийн хугацаанд чөлөөлж болно.”

7.5.Энэ хуулийн 7.4-д заасны дагуу албан татвараас чөлөөлөх үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалтыг тухайн хотын Захирагч, салбарын асуудал эрхэлсэн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд тавигдах шаардлага, стандартыг Засгийн газар батална.

7.6.Энэ хуулийн 6.4 дэх хэсэгт хамрагдсан үл хөдлөх эд хөрөнгөд энэ хуулийн 7.4 дэх заалт хамаарахгүй.” Энэ найруулга нь ерөөсөө ойлгомжгүй юм байгаад байх юм. 7.5 нь энэ хуулийн 7.4-д заасны дагуу албан татвараас чөлөөлөх үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалтыг тухайн хотын Захирагч, салбарын асуудал эрхэлсэн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд тавигдах шаардлага, стандартыг Засгийн газар батална. Ням-Осорын Учрал сайд, гишүүн хариулъя, үг хэлнэ. Тайлбар байхгүй, зүгээр дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно. Баахан хавсарсан нийлмэл өгүүлбэр тэгээд. Ням-Осорын Учрал гишүүн. Энэ жагсаалтыг үндэслээд.

Н.Учрал: Энэ татварын болон татварын бус дэмжлэгийг үзүүлнэ гэдэг энэ зарчмыг дагуулаад бид ингээд хуульд тодорхой өөрчлөлт оруулж байгаа юм. Тэгээд тухайн үед бол ажлын хэсэг дээр Сангийн яамнаас болбол зөвшилцөөд, ойлголцолд хүрээд яг энэ саналыг болбол оруулсан. Тэгэхээр яг нөгөө ЗГ-аас баримтлаад байгаа 20 минутын хот концепцыг амилуулах хамгийн чухал заалт болбол энэ гэж ойлгож байгаа юм.

Юу вэ гэхээр энэ хуулийг өргөн барихдаа хэрвээ алслагдсан хотод бүх төрлийн үйл ажиллагааг үзүүлэх юм бол тэр 4км дотор номын сан ойртох юм бол, үйлчилгээ ойртох юм бол, тэр кофе шоп ойртох юм бол, тэр спорт комплекс ойр байгуулагдах юм болбол ямар нэгэн байдлаар дэмжлэг үзүүлэхгүй бол тэр алслагдсан хотод энэ үйл ажиллагаа явуулах ямар нэгэн хөшүүрэг байхгүй байна гэж ойлгож байсан. Тэгэхээр энэ хуулийн хүрээнд болбол нөгөө хотууд байгуулагдаад эхлэхээр тухайн хотыг үнэлэх тийм индикаторууд бий болно. Тэр нь юу вэ гэхээр тухайн хотод номын сан байна уу, тухайн хотод тэр үйлчилгээний цогцолбор байна уу, тэр спорт цогцолбор байна уу гээд

үзэхээр хэрвээ тэр алслагдсан хотод жишээ нь тэр кино театр байгуулагдлаа гэхэд тодорхой дэмжлэгийг тэр хувийн хэвшилд үзүүлэхгүй бол хотын төвд л байгуулагдана гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр тэр Толгойт хотод үнэхээр орчин үеийн кино театр байгуулагдаж байх юм бол үл хөдлөхийн татварыг 5 жилийн хугацаанд зүгээр хойшлуулъя л гэж байгаа юм. Тэгэх юм бол хувийн хэвшлийг, хувийн хэвшил өөрөө бас нэг илүү хөшүүрэг болж тэнд үйл ажиллагаа явбал бололцоо нээгдэнэ. Тэгэхээр энэ аль ч хотод хамааралтай. Тухайн хотод байхгүй үйлчилгээ очих юм бол, тухайн хотод байхгүй тэр цогцолборын үйл ажиллагаа явагдах юм болбол үл хөдлөх хөрөнгийн татварыг л 5 жил хойшлуулъя. Үүн дээр тэр жагсаалтыг нь тухайн хотын.../минут дуусав/

Г.Занданшатар: Санааг нь ойлгож байна зөв гэж байна. Яах вэ ингээд 7.5 нь ерөөсөө уншаад ойлгогдохгүй өгүүлбэр болчхоод байгаа байхгүй юу 7.5-ыг л. Энэ хуулийн 7.4-д заасны дагуу албан татвараас чөлөөлөх үл хөрөнгийн жагсаалтыг, хууль их тодорхой байвал ойлгомжтой байна. Хотын захирагч батлах юм уу, салбарын асуудал эрхэлсэн төсвийн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн батлах юм уу гээд тэгтэл цаашаа явж байснаа тэдний саналыг үндэслээд ЗГ, гэснээ үл хөдлөх эд хөрөнгөд тавигдах шаардлага стандартыг нь ЗГ батална гээд дуусаж байгаа байхгүй юу. Баахан хавсарсан нийлмэл өгүүлбэрийн дунд 3, 4 субъект, тэгээд хэн нь яг юу хийх нь тодорхойгүй ийм ойлгомжгүй заалт болчхоод байна. Энэ 7.5-аа тодруулахгүй бол яг явж, явж байгаад жагсаалтыг батлах биш, эд хөрөнгөд тавигдах шаардлага стандартын ЗГ батална гэж дуусчхаад байна л даа. Энийг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Арван гурав.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийн ““Байгалийн” гэсний өмнө” гэснийг ““дараа сарын” гэсний өмнө” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ бол Дулаанхаан хотын тосгоны захирагч нарын санал байх. Энэ байгалийн нөөц ашигладаг газар гэхээр энэ Дулаанхаан л байгаа байх. Танай санал уу?

Арван дөрөв.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “23.10 дахь хэсгийн “аймаг” гэсний дараа “, хот” гэж” гэснийг “23.10 дахь хэсгийн “Аймаг,” гэсний дараа, “суманд оршин суудаг”, “сумын төв нь”, “суманд 50 хувиар”, “суманд 90 хувиар” гэсний өмнө “хот,” гэж” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван тав.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14 дүгээр зүйлийн 14.1.22 дахь заалтын “хотын Зөвлөлийн дарга тухайн шатны Зөвлөлийн төсвийн” гэснийг “хот, тосгоны Захирагч тухайн шатны төсвийн” гэж, 4 дэх заалт буюу 23.14 дэх хэсгийн “хотод” гэснийг “хот, тосгонд” гэж, “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 1 дэх заалт буюу 14.1.23, 14.1.24 дэх заалтыг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“4/23 дугаар зүйлийн 23.8.18 дахь заалт:

“23.8.18.хотын албан татвар.”” Санал гаргасан ажлын хэсэг,

санал хураалт. 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 8.5.3 дахь заалт, 61.1, 63.4, 64.1 дэх хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж, 8.5.4 дэх заалтын “улсын зэрэглэлтэй хотын” гэснийг “тосгоны” гэж, 29.3 дахь хэсгийн “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын” гэснийг “хот, тосгоны” гэж, 57.4 дэх хэсгийн “орон нутгийн зэрэглэлтэй хот” гэснийг “болон орон нутгийн зэрэглэлтэй хотын” гэж тус тус өөрчилж, “16 дугаар зүйлийн” гэсний дараа “16.3 дахь хэсгийн” гэж нэмж, 42.3.3 дахь заалт, 66.1 дэх хэсгийн “улсын зэрэглэлтэй хотын хороо,” гэснийг, 56.3.2 дахь заалтын “хотын” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 63,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 19.5 дахь хэсэг, 4 дэх заалт буюу 36.1, 36.2, 36.6 дахь хэсэг, 9 дэх заалт буюу 61.4 дэх хэсэг, 10 дахь заалт буюу 63.3 дахь хэсгийн “хотын” гэснийг, 3 дахь заалт буюу 34.2 дахь хэсгийн “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын” гэснийг “хот, тосгоны” гэж, 14 дэх заалт буюу 19.6.3 дахь заалтын “улсын зэрэглэлтэй хотын” гэснийг “тосгоны” гэж, 8 дахь заалт буюу 60.6 дахь хэсгийн “хот, улсын зэрэглэлтэй хотын хорооны” гэснийг “хотын” гэж, 9 дэх заалт буюу 61.3 дахь хэсгийн “Засаг дарга болон хот, тосгон, улсын зэрэглэлтэй хотын хорооны Захирагч” гэснийг “Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч” гэж, 12 дахь заалт буюу 67.1 дэх хэсгийн “улсын зэрэглэлтэй хот, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагч нь” гэснийг “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч” гэж тус тус өөрчилж, 2 дахь заалт буюу 21.2, 21.3 дахь хэсэг, 15 дахь заалт буюу 67.2.3 дахь заалтын “улсын зэрэглэлтэй хотын хороо,” гэснийг, 3 дахь заалт буюу 34.2 дахь хэсгийн “хотын” гэснийг, 5 дахь заалт буюу 56.3 дахь хэсгийг, 7 дахь заалт буюу 59.2 дахь хэсгийг, 10 дахь

заалт буюу 63.3 дахь хэсгийн “улсын зэрэглэлтэй хотын хороо,” гэснийг болон 13 дахь заалт буюу 8.5.1, 8.5.3 дахь заалтыг хасаж тус тус хасаж, 6 дахь заалт буюу 58.1.1 дэх заалтын “хот,” гэсний дараа “тосгон” гэж, 12 дахь заалт буюу 67.3 дахь хэсгийн “Захирагч” гэсний өмнө “хот, тосгоны” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Гишүүд өнөөдрийн санал хураалтыг дуустал гарч, орохгүй тогтвортой сууна шүү. Үүдэнд хүн гаргахгүй, тэр үүдэнд сууж байгаа хүмүүс. Гаргахгүй, гаргахгүй. Аубакир гишүүн тэгээд алга болчихдог. Яг гаргахгүй гэхээр гардаг нь яаж байгаа юм бэ та, зөрж байгаа юм уу, худлаа яриад гарч байна, яг хэлэнгүүт гарч байгаа байхгүй юу, дандаа тэгнэ. Баделхан сайд хаачсан бэ? Баян-Өлгийд чинь очиж би зарлана шүү.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын “Засаг дарга болон Захирагчаас” гэснийг “Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчаас” гэж, 4.1.27, 8.9.3, 59.2.4 дэх заалт, 23.8, 23.9, 25.8, 39.1 дэх хэсгийн “хотын” гэснийг “хот, тосгоны” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн “8.8 дахь хэсгийн” гэсний өмнө “8.5.1, 8.5.3 дахь заалтын “Хуралд” гэснийг “Хурал болон Зөвлөлд” гэж,” гэж, “23.8, 23.9 дэх хэсгийн” гэсний өмнө “, 23.7.3 дахь заалт, 23.13 дахь хэсгийн “аймаг, нийслэлийн” гэснийг “аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын” гэж,” гэж, “25 дугаар зүйлийн” гэсний өмнө “23.9.3 дахь заалтын “сум, дүүргийн” гэснийг “сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны” гэж, 24¹ дүгээр зүйлийн 24¹.1.1 дэх заалтын “нийслэлийн” гэснийг “нийслэл, улсын зэрэглэлтэй хотын” гэж,” гэж, 59.8 дахь хэсгийн “тосгоны” гэсний өмнө “орон нутгийн зэрэглэлтэй хот,” гэж, “66 дугаар зүйлийн” гэсний өмнө “64 дүгээр зүйлийн гарчгийн “Хурлын” гэснийг “Хурал, Зөвлөлийн” гэж, 65 дугаар зүйлийн гарчгийн “даргын” гэснийг “дарга, улсын зэрэглэлтэй хотын Захирагчийн” гэж,” гэж, “66.1.3 дахь заалтын” гэсний өмнө

“гарчгийн “даргын” гэснийг “дарга, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн” гэж,” гэж тус тус нэмж, 36.3 дахь хэсгийн “улсын зэрэглэлтэй хотын хороо,” гэснийг, 66.1.6 дахь заалтын “хотын хороо,” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд “56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсгийн “нийслэлийн төсөвт, аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум дүүргийн төсөвт” гэснийг “нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төсөвт, аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсөвт, улсын зэрэглэлтэй хотын Захирагч нь орон нутгийн зэрэглэлтэй хотын төсөвт” гэж,” гэж, мөн зүйлд “59.2 дахь хэсгийн “нийслэл” гэснийг “нийслэл, улсын зэрэглэлтэй хот” гэж, “дүүргийн” гэснийг “дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны” гэж,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 63,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван зургаа.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 2 дугаар зүйлийн “22.5.1 дэх заалтын “аймаг” гэсний дараа “, хот”” гэснийг “22.5.1 дэх заалтын “сумын төв нь”, “суманд байнгын”, “сумын нутаг дэвсгэр”, “суманд 50 хувиар”, “суманд 90 хувиар” гэсний өмнө болон “албан татварыг аймаг,” гэсний дараа “хот,”” гэж өөрчилж, мөн зүйлийн “28.6 дахь хэсгийн” гэсний дараа ““татвар нь”, “жилд” гэсний дараах” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 58,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Гишүүд

суудалдаа сууя. Гишүүд суудалдаа сууя. Санал хураалт. 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван найм.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 3 дугаар зүйлийн “Засаг даргын” гэсний өмнө ““хооронд”, “дээд шатны” гэсний өмнөх” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 63,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хорь.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтын “Хурал” гэсний дараа “, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл” гэж,” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.3.Энэ хуулийн 29.1.12, 29.1.14, 35.1.4, 35.1.5, 35.1.6, 35.1.7, 35.1.8, 35.1.9, 35.1.10, 35.1.11,35.1.12, 35.1.13, 35.1.15, 35.1.16, 35.1.17, 35.1.18, 35.1.21, 35.1.22 дахь заалт, 35.4, 35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан аймаг,

нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тогтооно.”” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 2/3-оор босгож болно. 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн гарчиг болон 35.1 дэх хэсгийн “Засаг даргаас” гэснийг “Засаг дарга, хотын Захирагчаас” гэж, 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2 дахь заалтын “олгоход”, “сунгахад” гэсний дараах “нийслэлд” гэснийг “нийслэл, нийслэлийн харьяа улсын зэрэглэлтэй хотод” гэж, 35.2.1 дэх заалтын “1 000 000 төгрөг”, “300 000 төгрөг” гэсний өмнөх, 35.2.2 дахь заалтын “500 000 төгрөг”, “300 000 төгрөг” гэсний өмнөх “аймгийн төвийн суманд” гэснийг “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотод” гэж, 35.2.1 дэх заалтын “500 000 төгрөг”, “200 000 төгрөг” гэсний өмнөх, 35.2.2 дахь заалтын “300 000 төгрөг”, “100 000 төгрөг” гэсний өмнөх “бусад суманд” гэснийг “суманд” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал хураалт. Энэ тэмдэгтийн хураамжийг дэмжихгүй бол болохгүй. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хорин нэг.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсгийн дугаарыг “40.8” гэж өөрчилж, 2, 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ. Болорчулуун гишүүнээ санал хураалт, буцаж орж ирээрэй.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 2 дугаар зүйлийн “, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “50-иас доошгүй хувийг” гэсний дараа “хотын дэд бүтцийн санд төвлөрүүлж,” гэж” гэснийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлд “7.3 дахь хэсгийн “50-иас доошгүй хувийг” гэснийг “50 хувийг хотын дэд бүтцийн санд төвлөрүүлж,” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. 50-иас доошгүй гэдгийг 50, яг 50 гээд хатуу заасан унасан шүү дээ. Чиглэл санал хураагдсан.

Хотын албан татварын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төслийн талаар

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “төсөвт төвлөрүүлэх” гэсний өмнө “уг татварыг” гэж нэмэн, “харилцааг зохицуулна” гэснийг “харилцаанд үйлчилнэ” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын “тав тухтай амрах, зугаалах нөхцөлийг” гэснийг “байнгын болон улирлын үйл ажиллагаатай, үйлчлүүлэгчийн тав тухтай амрах нөхцөлийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 7 дугаар зүйлийн “түүний дагалдах хэрэгсэл” гэснийг “тэдгээрийн дагалдах хэрэгсэл” гэж, 7.2.5 дахь заалтын “угаалгын үйлчилгээ” гэснийг “угаалгын газрын үйлчилгээ” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Гадаа байгаа гишүүдийг дуудаарай. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “ногдох албан татварыг” гэснийг “ногдуулсан албан татварыг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал

хураалт. 56,1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Учрал гишүүнээ ажлын хэсэг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль чинь эхнээсээ буруу бичигдсэн хууль юм байна. Тэгээд энэ бараг найруулгаараа Байнгын хорооны даргаа авахгүй бол энэ тоо мэддэггүй хүн бичсэн юм шиг байна энэ. 50-иас доошгүй гээд 2-ланг нь 50-иас доошгүй гэхээр чинь нийлбэр нь 100 болж чадахгүй шүү дээ тэгэхээр яг 50 гэж авахгүй. Харин тэгж засахгүй бол харин угаасаа буруу бичигдсэн хууль юм байна. Тийм учраас энэ дээр Байнгын хороон дээрээ энийг найруулга редактораар ч авч болохоор засвар байна. Тэгээд Байнгын хороон дээрээ хэлэлцээд шийдчих.

“Хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар, санал хураалт явуулья.

1.Тогтоолын төслийн 1 дэх заалтын хүснэгтийн 11, 13 дахь дэд заалтын “Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр” гэснийг “Нийслэлийн Сонгинохайрхан, Баянгол дүүргийн нутаг дэвсгэр” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Сонгинохайрхан, Баянгол хоёр нийлж байгаа юм байна тийм ээ. 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 1 дэх заалтын хүснэгтийн 33 дахь дэд заалтын “Өвөрхангай аймгийн Арвайхээр сум” гэснийг “Өвөрхангай аймаг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 56,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 1 дэх заалтын хүснэгтийн 52 дахь дэд заалтын “Дархан хот” гэснийг “Дархан-Уул аймаг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 5 дахь заалтын “чиг үүргийг” гэсний өмнө “зарим” гэж тохиолдол бүр нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 59,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 6, 7 дахь заалт нэмэх:

“6/Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн зарим чиг үүргийг Шаргаморьт дагуул хотод, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зарим чиг үүргийг тус хотын Зөвлөлд, дүүргийн Засаг даргын зарим чиг үүргийг тус хотын Захирагчид хотын эдэлбэр газрын хэмжээнд хэрэгжүүлэхээр тус тус шилжүүлсүгэй.

7/Нийслэлийн Багахангай дүүргийн чиг үүргийг Багахангай дагуул хотод, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чиг үүргийг тус хотын Зөвлөлд, дүүргийн Засаг даргын чиг үүргийг тус хотын Захирагчид хотын эдэлбэр газрын хэмжээнд хэрэгжүүлэхээр тус тус шилжүүлсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Учрал гишүүнээ энэ дээр, 59,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Эдэлбэр газрын хэмжээнд гэдгийг нутаг дэвсгэрийн хэмжээнд гэж газар нутаг дэвсгэрийн хэмжээнд гэж. Энэ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хууль шүү дээ. Түүнтэйгээ нийцэж явна шүү дээ, нутаг дэвсгэр гэдгээр.

6.Тогтоолын төслийн 9 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 54,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. 6.Тогтоолын төслийн 9 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Тогтоолын төслийн 10 дахь заалтын 1 дэх дэд заалтын “Нийслэл Улаанбаатар хотоос бусад” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал

хураалт. 61,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Тогтоолын төслийн 1 дэх заалтын хүснэгтийн Хотын нэр баганад “Хархорин хот” гэж, “Харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, Хот баганад “Өвөрхангай аймгийн Хархорин сум”, гэж, Газар зүйн байршил баганад “Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дэвсгэр” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд, Дуламдоржийн Тогтохсүрэн, Содномын Чинзориг, санал хураалт. Ганболд гишүүнээ наад Тэмүүлэн гишүүнээ ухаан орсонгүй юу. Зүгээр, зүгээр. 61,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хорин тав. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар.

1.Тогтоолын төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/хууль тогтоомжийг нийцүүлэх чиглэлээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2024 оны дөрөвдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/хот, тосгоны зөвлөл, захирагчийн сонгуулийг цахимаар явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судалж, танилцуулах.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 58,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй санал байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, санал хураалт явуулъя, санал хураалт. Дэмжинэ гэж байна. 53,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлд “23.6.13.нэмэгдсэн өртгийн албан татварын 10 хувь”, төслийн 3 дугаар зүйлд “23.4.2.нэмэгдсэн өртгийн албан татварын 90 хувь” гэсэн агуулгатай заалт тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал гаргасан Бат-Амгалан гишүүн байна шүү. Дэмжих юм байна, бүгдээрээ дэмжинэ. 53,7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ. Хатантуул тэр төр, Нямбаатар сайд хаачсан юм бэ? Тэр нөгөө Төр, хувийн хэвшлийн түншлэлийн юм чинь хаана явчхав, байхгүй юм уу. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна. ТББХ-н дарга, үг байхгүй л дээ. Нямаагийн Энхболд дарга.

Н.Энхболд: Ийм байгаа юм даргаа, Занданшатар даргаа Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах хууль дээр ийм заалт орж ирсэн юм. Ус бохирдуулсны төлбөрийн орлогын 50-аас дээшгүй хувийг.../үг тасрав/

Г.Занданишатар: Тийм ээ, түүнийг ойлгож байгаа. Түрүүн хэлчихсэн шүү дээ.

Н.Энхболд: Тийм. Тэгэхдээ үүнийг ийм байна. Яг дэгээрээ болбол бид нар энийг нь түрүүн унагаагчидсан учраас дахиж Байнгын хороон дээр хэлэлцэж болохгүй юм байна. Тэгээд тэр саналаа хүчингүй болгоод, саналыг нь хэвээр нь үлдээж байгаад Байнгын хороон дээрээ дахиж хэлэлцэх ёстой юм байна. Тэгэхээр би таныг тэр 10 дугаар, 10-д орж ирсэн Засгийн газрын тусгай сангийн хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар хураасан саналыг хүчингүй болгоод тал дээр нь өгөөч. Бид нар үүнийгээ засчхаад, Байнгын хороон дээр ороод ирье. Нэгэнт бид нар энийг дэмжээгүй болохоор Байнгын хороогоор хэлэлцэж болохгүй юм байна. Хуучнаараа үлдчихээд байгаа юм байна. Хуучин нь дэмжигдчихсэн гэсэн үг байхгүй юу. Тэгээд тэр саналаа хүчингүй болгочихвол бид нар Байнгын хорооны санал дэмжигдсэн гэдэг утгаар нь тоогоо юу эргээд янзлаад оруулах юм байна. Учрал дарга бас сая яг тийм юм хэлэх гэж бид 2 тийм.

Г.Занданишатар: Гэхдээ яах вэ энэ агуулгын хувьд үлдсэн хэмжээг нь өөр юманд зарцуулж болно л гэж харах гээд байна л даа.

Н.Энхболд: Харин тийм, тэгэхээр ийм байхгүй юу.

Г.Занданишатар: Заавал энэ хоёрт яг 50, 50 гээд хуваагчид байгаа шүү дээ яг.../үг тасрав/

Н.Энхболд: 50-ийг нь л ав гэж байгаа, 50-ийг нь л хот ав, бусдыг нь нөгөө бусад юмандаа зарцуул. 50-аас доошгүй гэхээр бүгдийг нь хот авчих гээд байгаа байхгүй юу.

Г.Занданишатар: 50-аас доошгүй гэдгийг хоёуланг нь 50 хувь гээд хатуу

заачихаар цаана нь юм үлдэхээ больчихож байгаа байхгүй юу.

Н.Энхболд: 50-аас доошгүй гэхээр цаана нь юм үлдэхгүй болчихоод байгаа юм. 50-аас доошгүй гэхээр чинь 100 хүртэл явна шүү дээ. 50-аас дээшгүй гэсэн бол хагас нь үлдэнэ. 50-аас доошгүй гэхээр 50, тэгээд түүнээс дээш гэхээр бүгдийг нь хот аваад, бусад юманд нь зарцуулах мөнгө нь үлдэхгүй болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо хэдүүлээ тэр саналыг хүчингүй болгуулчихаад.../үг тасрав/

Г.Занданишатар: Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 7.3.10-д заасан санал хураалтыг хүчингүйд тооцоход гүйцээн боловсруулах чиглэл өгөх санал хураалт явуулах нь байна тийм ээ. Ийм агуулгаар санал хураалт. Ням-Осорын Учрал гишүүн.

Н.Учрал: Сая Их Хурлын даргаас тэр төр, хувийн хэвшлийн түншлэлтэй холбоотой бас яг нөгөө нэг зарчим дэмжигдсэнтэй холбогдуулж асуулт асууж байгаа юм. Тэгэхээр энэ дээр нэг горимын санал байна. Төслийн 6 дугаар зүйл дээр бол тэр татварын болон татварын бус дэмжлэг бас дэмжигдсэнтэй холбогдуулаад татварын тэр хууль дээр өөрчлөлт орсон. Тэгэхээр 6.1.9 дээр бол төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих гээд бас дэмжигдсэн. Тэгэхээр энэ хуулийн гол концепц болбол тэр хувийн хэвшлийн түншлэлийг л дэмжихэд оршиж байгаа. Тийм учраас энэ хуулийн төслийн 6 дугаар зүйл дэмжигдсэнтэй холбогдуулаад төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих чиглэлээр, төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд бас холбогдох өөрчлөлт оруулах шаардлага бас үүсэж байх шиг байна. Тийм учраас Их Хурлын даргаас энэ ТББХ-нд энэ эцсийн хэлэлцүүлэг дээрээ үүнийг анхаарч өгөх чиглэл өгөхийг бас хүсье, тийм.

Г.Занданишатар: Эхлээд Төрийн байгуулалтын байнгын хорооны даргын гаргасан саналаар Засгийн газрын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар хураасан санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалтыг явуулна. Энэ санал эхнийх нь эдний санал учраас эхлээд санал хураалт явуулчихна. Учралд үг өгчихсөн, өгчихсөн. Сая хэлчихсэн, хэлчихсэн. Эхнийх нь Нямаагийн Энхболд даргын горимын санал байгаа юм. Тэрнийг санал хураачхаад тэгээд. Гишүүд чуулганы танхимд орж ирье. Санал хураалт явуулъя.

12.25 цаг

Гурав.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд оръё. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна. Ажлын хэсгийн гишүүд өмнөх хуультай ажил, албан тушаал, нэр, овог нэг адил учир протоколд тэмдэглүүлж үлдээлээ.

Санал хураалт явуулъя. ТББХ-ны даргын гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хурааа. Олонхын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалт дахиж явуулъя. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Гишүүд Байнгын хорооны саналтай холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууссан. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 18 санал байгаа. Тэгээд өнөөдөр энэ Эх үрсийн баяраас өмнө тэр Олон хүүхэдтэй, хэдэн хуулиудыг эцэслэн баталчихмаар байна. Баярсайхан гишүүнээ та эмэгтэй гишүүдээ дуудаад. 2 цагт яг санал хураалт.

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 7.3.10 дахь заалтын “50-иас доошгүй” гэснийг тохиолдол бүрд “50” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал хураалт. Санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2 цагт хуулийн төсөл эцэслэн батлах санал хураалт явуулна. Бүх гишүүд, 44 гишүүн түрүүн байсан, бүгдээрээ заавал байх ёстой. Бүх гишүүд рүү утасдаж мэдэгд. Тасалсан гишүүдэд хариуцлагатай, цалин санхүүжилтийг энэ сарынхыг бүрэн хасна.

Холбогдох хууль тогтоомжид нийцүүлж, хууль санаачлах асуудлыг эцсийн хэлэлцүүлэг дээр ТББХ хэлэлцэж болно. Тухайн дэг, журмын дагуу холбогдох ЗГ-ын саналыг авч, Ерөнхий сайдын саналыг авч, үзэл баримтлалын хүрээнд Учрал гишүүний гаргасан горимын саналыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудлыг хэлэлцэхийг өгч байна.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. ТББХ дэмжсэн. Нийтэд зарлаж мэдээлнэ. Энэ хуулиудыг эцэслэн батлаагүй олон хүүхэдтэй ээжүүдэд олгох тэтгэвэр, тэтгэмжийг батлаагүй гишүүдийг зарлаж мэдээлнэ шүү. Пүрэвдорж гишүүнээ та сууж байна. Бүлгийн гишүүддээ сайн хэлээрэй. ТББХ-нд дэмжсэн санал.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар санал хураалт явуулж дууслаа. Шинэ Зуунмод хотын эрх зүйн, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

1.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “нутаг дэвсгэр нь” гэснийг “эдэлбэр газар” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ яагаад нутаг дэвсгэрийг эдэлбэр газар өөрчлөөд байгаа юм бэ? Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал, Энхтайван Бат-Амгалан, Жигжидийн Батжаргал, Баагаагийн Баттөмөр, Гонгорын Дамдинням, Тогмидын Доржханд, Цэндийн Мөнх-Оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Ганзоригийн Тэмүүлэн. Энэ ажлын хэсгийн гишүүд бүгдээрээ байх шаардлагатай шүү. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Сандаг-Очир гишүүнээ санал. Пүрэвдорж гишүүн саналаа өгөөрэй. Адъяасүрэн гишүүн хаачсан юм бэ? Өнөөдөржингөө байсангүй. Тилеуханы Аубакир гишүүн, Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн. Төв аймгаас сонгогдсон Туваан гишүүн дэмжихгүй байгаа юм уу? Тилеуханы Аубакир гишүүн гэсэн. Горимын санал хэлнэ. Энэ яагаад ингээд юу яагаад байгаа юм бол. Тилеуханы Аубакир гишүүн микрофон өгнө үү.

Т.Аубакир: Би сая дэмжиж санал өгсөн боловч энэ төхөөрөмж ажилласангүй. Тийм учраас саяын саналыг хүчингүй болгоод дахин санал хураалгаж өгнө үү. Аубакир гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Дэлгэц дээр яагаад ингэж санал хураалтыг хожимдуулж гаргаад байгаа юм бэ энэ. 53,8 хувийн саналаар санал хураалт дэмжигдлээ. Аубакир гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг дахиж явуулъя. 51,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “сонгон шалгаруулж, 4 жилийн хугацаагаар хотын Захирагч томилно” гэснийг “сонгоно” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн “Цаашид “Захирагчийн

ажлын алба” гэх./-” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,” гэсний дараа “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 17 дугаар зүйлийн 17.3.3 дахь заалтын “академи” гэснийг “үндэсний хүрээлэн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Энэ санал дэмжигдсэнгүй.

6.Төслийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт доор дурдсан 17.3.6 дахь заалт нэмэх:

“17.3.6.олон улсын банк, санхүүгийн үйл ажиллагаа.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Бат-Эрдэнэ гишүүнээ саналаа өгөөрэй, саналууд унаад байна. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төсөлд доор дурдсан агуулгатай 18 дугаар зүйл нэмэх:

“18 дугаар зүйл.Олон улсын санхүүгийн төв

18.1.Энэ хуулийн 8.1.1-д заасан эдийн засгийн чөлөөт бүсэд тусгай дэглэм бүхий газар нутгийн хил зааг дотор олон улсын банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн ороцогч байгууллагуудаас бүрдсэн олон улсын санхүүгийн төв байгуулна.

18.2.Олон улсын санхүүгийн төвийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны хүрээ, хязгаар, эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” Санал

гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “16.1.1-д зааснаас бусад” гэснийг “16.1.2, 16.1.3, 16.1.4-т заасан” гэж өөрчилж, “доор дурдсан салбарт” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 29 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, агуулга, зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 52,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал. 1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4.4 дэх заалтын “бэлгэдэл тэмдэг” гэснийг “бэлгэ тэмдэг” гэж, 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсгийн “зүйлийн” гэснийг “хуулийн” гэж тус тус өөрчлөх, яах вэ би алгассан тэд нарыг тэгээд ойлгочих, тэгээд санал гаргасан ажлын хэсэг. Найруулгын саналыг бүхэлд нь.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4.4 дэх заалтын “бэлгэдэл тэмдэг” гэснийг “бэлгэ тэмдэг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийн “9.5-д” гэснийг “9.6-д” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “хороонд” гэснийг “хороололд”, “хороо” гэснийг “хороолол” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “13.4.4” гэснийг “13.4.5” гэж, “13.4.5” гэснийг “13.4.6” гэж, “13.4.6” гэснийг “13.4.7” гэж, “13.4.7” гэснийг “13.4.8” гэж, “13.4.8” гэснийг “13.4.9”, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “Шинэ Зуунмод хот /цаашид “хот” гэх”, 16

дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорац /цаашид “корпорац” гэх”/ гэсэнтэй нийцүүлж тохиолдол бүрт, 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсгийн “зүйлийн” гэснийг “хуулийн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “Нийслэл” гэсний дараа “хот” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт явуулъя. 51,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

1.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотын хотын хөгжлийн корпорац нь Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 18.1-д заасан олон улсын санхүүгийн төвийг байгуулах бэлтгэл ажлыг хангана. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

2.Төслийн 3 дугаар зүйлийг 4 дүгээр зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд хотын Захирагчийн чиг үүргийг хотын бүтээн байгуулалт, хөгжлийн асуудал хариуцсан бүрэн эрхт төлөөлөгч хэрэгжүүлэх бөгөөд түүнийг нийслэлийн Засаг даргын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.” Санал

гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 58,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “38.1.22” гэснийг “38.1.23” гэж, “40.8” гэснийг “40.9” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Нямбаатар сайд Шинэ Зуунмод хотынхоо. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “38.1.22” гэснийг “38.1.23” гэж, “40.8” гэснийг “40.9” энэ чинь сая санал хураалт явуулсан.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар.

1.Төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль баталсантай холбогдуулан бусад хууль тогтоомжийг нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2024 оны дөрөвдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 56,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.“Хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

1.Тогтоолын төслийн үндэслэх хэсгийн “тус тус” гэсний өмнө “, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийг” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал

хураалт. Пүрэвдоржоо саналаа. 56,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн хавсралтын “Шинэ Зуунмод хотын эдэлбэр газрын хилийн заагийн эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээ, байршил” хүснэгтийн Төв аймгийн Сэргэлэн сумын “Шинэ Зуунмод /Төрийн захиргааны нэгдсэн цогцолбор/”-ын 1000 га газрын солбицлыг тэгш өнцөгтийн солбицлоор хийсэн байгааг газар зүйн солбицол болгон нийцүүлж доор дурдсанаар өөрчлөх.

Энэ солбицлыг сайн шалгахгүйгээр ингэж. Хүснэгтэд дурдсанаар өөрчлөх. Хүснэгт нь Төв аймгийн Сэргэлэн сум 379644,9 Шинэ Зуунмод хот төрийн захиргааны нэгдсэн цогцолбор 1000 га газар, ингээд 1-ээс 9 тоот хүснэгтэд солбицлыг заасан байна. Энэ солбицлыг нягтлаарай ингээд. Санал хураалт. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Төрийн бодлого шийдвэртэй зөрөөд байгаа юм байхгүй. Гэхдээ бас бид эрх зүйт төрийг төлөвшүүлж байгаа. Аливаа асуудал хууль номынхоо дагуу л явах ёстой. Тэр нэг сүүлд нэмэгдээд байгаа мянган га чинь орон нутгаас ирсэн санал юмнууд тодорхойгүй юм билээ. Тэгээд тийм асуудлыг Их Хурал хэлэлцэж, шийдвэр гаргаж болох юм уу? Энэ чинь орон нутгаасаа санал нь ирээд, ЗГ-аараа дамжаад, Их Хурал руугаа орж ирдэг ийм л зүйл шүү дээ. Тэгээд орон нутгийнхан санал ирээгүй юм байна лээ шүү дээ.

Г.Занданшатар: Санал хураалт явуулах уу? Энэ чинь унах юм байна даа. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Байнгын хороон дээрээ Батжаргал гишүүн эцсийн хэлэлцүүлэг дээр ярь. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явж дууслаа. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн

хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр ТББХ-нд шилжүүлж байна.

12.42 цаг

Гишүүд суудалдаа суугаарай. Оюунчимэг гишүүнээ суудалдаа суугаарай. Гишүүд суудалдаа сууж санал хураалтаа үргэлжлүүлнэ шүү.

Дөрөв. Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна. Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан. Байнгын хорооны гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 16 санал байгаа.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжсэн санал. 1.Төслийн 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Наянтайн Ганибал, Батсүхийн Саранчимэг, Цагаанхүүгийн Идэрбат, Төмөртоогогийн Энхтүвшин цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт явуулъя. Пүрэвдоржоо санал хураалт. Учрал гишүүнээ санал хураалт. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиа явуулчихсан, одоо энийгээ цааш нь явуулна. 3, 5, 6, 7, 8. Адьшаа гишүүнээ танай 2 бол, та 2 суучих. Санал хураалт. Холбоо 2, Ховдын 2 суудалдаа. 16 саналтай.

Ажлын хэсгийг танилцуулъя. Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, сайдыгаа дуудчих. Энхбаатарын Цолмонжаргал тус яамны Хуулийн хэлтсийн дарга, Цэвэгмэдийн Мөнхнасан тус яамны

Бодлого, төлөвлөлтийн газрын мал аж ахуйн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн. Та хаачих нь вэ? Гялс саналаа өгчхөөд гарчих. Учрал гишүүнээ та хуулиа батлуулчхангуут ингээж гарч явж болохгүй бас. Адьшаа гишүүнээ. Санал хураалт. Мөнхбаатар дарга. Санал хураалт, Адьшаа гишүүнээ санал хураалт, Пүрэвдоржоо санал хураалт. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Энэ дэлгэц дээр арваасаа эхэлж тоо явахгүй ингээж хоосон юу харуулж байгаад ингээж гэнэт гаргаж ирээд, дохио санамжгүй. Энэ хаанаас юу явуулаад байна вэ. Санал хураалт явуулъя. 52 хувийн, 52,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 4.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4.1.7, 4.1.8 дахь заалт нэмэх:

“4.1.4. “хот айл” гэж хоёр ба түүнээс дээш малчин өрх хамтран хөдөлмөрөө хоршин мал аж ахуй эрхлэх зохион байгуулалтын хэлбэрийг;

4.1.5. “мал аж ахуйн зохистой дадал” гэж бэлчээрийг хамгаалах, мал маллагаа, малын эрүүл мэнд, үүлдэр угсаа, ашиг шим, түүхий эдийн чанар, аюулгүй байдлыг хангах арга барил, үйл ажиллагааг;

4.1.7. “мал” гэж Малын генетик нөөцийн тухай хуулийн 4.1.1-д заасныг;

4.1.8. “малчин өрх” гэж Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.2-т заасныг.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 52,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.6 дахь заалтын “урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд” гэсний дараа “хамрагдах хүсэлт гаргасан малчныг жил бүр” гэж нэмж, 5.1.6 дахь заалтыг 5.1.6, 5.1.7 дахь заалт болгож, 5.2, 5.3 дахь хэсэг, 5.2.1,

5.2.3, 5.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.6.мал аж ахуйн салбарын уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан эрсдэл даах чадавхыг бүрдүүлэх;

5.1.7.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, боловсруулалтын түвшинг ахиулах цогц бодлогыг хэрэгжүүлэх;

5.2.Засгийн газраас энэ хуулийн 5.1-д заасан бодлогыг хэрэгжүүлэхээс гадна дараах арга хэмжээг авна:

5.2.1.мал аж ахуйн тогтвортой хөгжлийн бодлогыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт, шаардагдах санхүүжилтийг улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;

5.2.3.мал үржүүлэг, технологийн болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг хөнгөлөлттэй зээл болон бусад хэлбэрээр дэмжих;

5.2.7.гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас малчин нь ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 48 сараар тооцож, түүнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь Засгийн газрын нөөц сангаас олгох;

5.3.Энэ хуулийн 5.2.4, 5.2.5, 5.2.6, 5.2.7, 5.2.8, 5.2.9-д заасан арга хэмжээтэй холбогдох харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал хураалт. Сэргэлэн генералаа санал хураалт. 52,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, ГУРАВДУГААР БҮЛЭГТ шилжүүлэх. Санал

хураалт. 52.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 12 цаг 50 минутаас хуралдааныг даргалав.

Л.Мөнхбаатар: Санал хураалтаа явуулъя. 4, 4 юм байна тийм ээ. 4.Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, ГУРАВДУГААР БҮЛЭГТ шилжүүлэх:

МАЛЧНЫ ХӨГЖИЛ, ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

6 дугаар зүйл.Малчны эрх, үүрэг

6.1.Малчин дараах эрх эдэлнэ:

6.1.1.уур амьсгалын өөрчлөлт, зах зээлийн нөхцөлд мал маллах арга ухааныг эзэмшиж, мэдлэг, туршлага, ур чадвар, арга барилаа ахиулж, малчинд зориулсан сургалт мэдээлэл, зөвлөгөө авах;

6.1.2.байгалийн нөөц, бэлчээрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гэрээгээр ашиглах эрхээ баталгаажуулах;

6.1.3.төрөөс болон олон улсын байгууллагын санхүүжилтээр олгосон хөрөнгө оруулалт, хөгжлийн зээл, дэмжлэг, санхүүгийн үйлчилгээ авах;

6.1.4.малын эрүүл мэндийг хамгаалах болон үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг эрх бүхий нэгжээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, зөвлөгөө авах;

6.1.5.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлт, нэр төрөл, чанараас хамаарсан урамшууллыг хууль тогтоомжийн дагуу авах;

6.1.6.хуульд заасан бусад эрх.

6.2. Малчин дараах үүрэг хүлээнэ:

6.2.1. байгалийн нөөц, бэлчээр, усан хангамжийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;

6.2.2. мал маллагааны уламжлалт болон шинжлэх ухаанч арга барилыг эзэмших;

6.2.3. малын эрүүл мэндийг хамгаалах, малын генетик нөөцийг зохистой ашиглах;

6.2.4. мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангах;

6.2.6. хуульд заасан бусад.

6.3. Энэ хуулийн 6.2.1-д заасан үүргийн хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:

6.3.1. малчин өрх, хот айл бэлчээрээ дундаа хамтран ашиглаж ирсэн уламжлалд тулгуурлан харилцан зөвшилцөж, зохион байгуулалтад орсон байх;

6.3.2. бэлчээрийг даацад нь нийцүүлэн улирлын хуваарьтай ашиглаж, сэлгэх, өнжсөөх, сайжруулах, нөхөн сэргээх зэргээр бэлчээрийн төлөв байдал, голлох ургамлын эзлэх хувийг гэрээ байгуулах үеийн тогтоосон суурь түвшинээс бууруулахгүй байх;

6.3.3. Газрын тухай хуулийн 52.7-д заасан газарт тэжээлийн ургамал тариалах, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан хадлан, гар тэжээл бэлтгэх.

6.4. Энэ хуулийн 6.2.2-т заасан үүргийн хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:

6.4.1. мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг өөрийн малын

тоо толгойд нийцүүлэн бүрэн хангаж, 90-ээс доошгүй хоногт хүрэлцэхүйц өвс, тэжээл бэлтгэж нөөцлөх;

6.4.2. малын хэвтэр бууц, хашаа, хороог байнга цэвэрлэж, өвөлжсөөний хэрзэнг жил бүр авдаг, өтөг хэрзэнг овоолж хэвтрийн нөөц бүрдүүлдэг байх;

6.4.3. өвөлжсөө, хаваржааны дулаан хашаа, хороо, байр барьж ашиглах;

6.4.4. дөрвөн улиралд нүүдэллэн бэлчээр ашиглахдаа байгаль орчныг бохирдуулахгүй, хог хаягдлыг ил задгай үлдээхгүй байх;

6.4.5. худаг, хөв цөөрөм бий болгох, сэргээн засварлах;

6.4.6. мал маллах, хариулах, тууварлах, тээвэрлэхдээ уламжлалт арга барилыг түлхүү ашиглах.

6.5. Энэ хуулийн 6.2.3-т заасан үүргийн хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:

6.5.1. тухайн бүс нутагт үржүүлэхийг зөвшөөрсөн, баталгаажсан үүлдэр, омгийн хээлтүүлэгч ашиглах, малыг ялган тэмдэглэх, бүртгэлд хамруулах;

6.5.2. малын төрлийн харьцаа, сүргийн зохистой бүтцийг хангаж, эдийн засгийн эргэлтэд оруулах;

6.5.3. тухайн үүлдэр, омгийн нэгж малаас авч болох ашиг шимийн дундаж гарцаас багагүй хэмжээний ашиг шим авах;

6.5.4. мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд 3 жил тутамд чанарын үнэлгээ хийлгэх;

6.5.5. мал эмнэлгийн болон үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг

мэргэжлийн нэгжээр гэрээний үндсэн дээр технологит хугацаанд гүйцэтгүүлэх;

6.5.6.мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдал, гарал үүслийг тогтоох нөхцөлийг бүрдүүлж, малын шилжилт хөдөлгөөний талаар эрх бүхий байгууллагад мэдээлдэг байх;

6.5.7.эмийн үлдэц агуулаагүй, баталгаатай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх.

6.6.Энэ хуулийн 6.2.4-т заасан үүргийн хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:

6.6.1.малын ноос, ноолуур, хөөврийг технологийн хугацаанд холбогдох стандарт, шаардлагын дагуу чанарын ялгаатай байдлаар ангилан тордож, бэлтгэн нийлүүлэх;

6.6.2.малын мах бэлтгэлийг хийхдээ малын арьс ширийг механик гэмтэлгүйгээр хоёр цагийн дотор цэвэрлээг, анхан шатны тордолтыг хийж, холбогдох стандарт, шаардлагын дагуу бэлтгэх;

6.6.3.сүү, сүүн бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэхдээ эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангасан байх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Гишүүдээ санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.6 дахь хэсэг, 7.5.3, 7.5.4, 7.5.7 дахь заалтыг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулж, 7.2 дахь хэсгийг хасах:

7.3.Энэ хуулийн 7.1-д заасан сургалтын хөтөлбөрийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, сургалтыг их сургууль, коллеж, мэргэжил, сургалт

үйлдвэрийн төв, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор үндэсний хэмжээнд зохион байгуулна.

7.4.Энэ хуулийн 7.3-т заасан хөтөлбөр нь сургалтын нэгдсэн стандарт, бүс нутгийн онцлогт нийцсэн байна.

7.5.3.малын чанарыг сайжруулах, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал маллах, арчлах болон сувилгааны арга аргачлалын талаарх мэдлэг мэдээлэл, цуврал хичээл;

7.5.4.бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх мэдлэг олгох мэдээлэл, цуврал хичээл;

7.5.7.малын өтөг бууц, аргал, хөрзөнг цэвэрлэх, боловсруулах, техник, технологийн мэдлэг;

7.6.Сургалт зохион байгуулсан байгууллага сургалтын хөтөлбөрөөр бүрэн суралцсан, үнэлгээний шаардлага хангасан төгсөгчид үнэмлэх, тэмдэг олгож, энэ талаарх мэдээллийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлнэ. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 56,4 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 8.3 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллага нь” гэснийг “Засаг дарга” гэж өөрчилж, 8.3.4 дэх заалт, 8.4 дэх хэсэг, 8.5 дахь хэсгийн “, 8.3.4” гэснийг, тус тус хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 8.3, 8.4 дэх хэсэг нэмэх:

“8.2.Аймаг, сумын Засаг дарга орон нутгийн онцлогт нийцүүлж, малчны хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

8.3.Газрын тухай хуулийн 52.7-д заасан газрыг өөр чиглэлээр давхиуулан

газар ашиглах, эзэмшүүлэх, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохгүй.

8.4.Залуу малчин гэр бүлд болон хот, сууринаас шилжин очиж, 2-оос доошгүй жил тасралтгүй мал маллаж байгаа малчин өрхөд өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх, бэлчээр ашиглуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрт үндэслэн сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал дэмжигдсэнгүй. Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ горимын санал гаргая.

Б.Бат-Эрдэнэ: Миний саналаа өгсөн эсрэг гарчихлаа, энэ юунд гацаад гараад байна. Дарагдахгүй байна, дэмжиж саналаа өгсөн юм. Тийм учраас горимын санал дахиж санал хураалгах, хүчингүй болгоод санал хураалгаж өгөөч.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд саналаа өгөөрэй. 53,8 хувиар санал дэмжигдлээ. Санал хүчингүйд тооцсон. Саналын үндсэн томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт явуулъя. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10.9 дэх хэсгийн “хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага тус тус” гэснийг “Засаг дарга” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 10.10 дахь хэсэг нэмэх.

“10.3.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашиг, нөөц ашиглалтын түвшний өсөлт болон малчны хүлээх үүрэг, зохистой дадлын хэрэгжилтийг харгалзан улс, аймаг, сумын аварга малчин, тэргүүний

малчны хоршоо, аймаг, сум шалгаруулах болзолд тусгаж, бүтээмжийг үнэлнэ.

10.6.Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу халдварт өвчингүй, эрүүл мал сүрэгтэй малчин өрхийг баталгаажуулна.

10.10.Улсын аварга, хошой аварга малчин, саальчин, фермер шалгаруулах журам болон энэ хуулийн 10.4-т заасан малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд урамшуулал олгох журмыг Засгийн газар тус тус батална.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 51,3 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4.6 дахь заалтын “малчны бүлгийн” гэснийг “хот айл, малчдын холбооны” гэж өөрчилж, 11.4.7 дахь заалтын “санаачлах аливаа малчны” гэснийг, 11.5 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 12, 13, 14 дүгээр зүйлийн хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “Малчин нь” гэснийг “Малчид хамтын санаачилга, хоршилд үндэслэн” гэж өөрчилж, 15.2 дахь хэсгийг хасаж, 15.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“15.6.Бэлчээрийг хаших, хөрсийг эвдэх, мэргэжлийн байгууллагаас доройтсон болохыг тогтоосон бэлчээрээс ургамал түүх, хадахыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 51,3 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “16.2-т заасан зээлийг” гэсний дараа “арилжааны банкны шаардлага болон” гэж нэмж, 16.5.10, 16.6.5, 16.6.6 дахь заалтыг тус тус хасаж, 16.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“16.7.Энэ хуулийн 16.2-т заасан зээлийн хүүгийн хөнгөлөлтөд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгана.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалтын “урамшууллын нэг удаагийн орлогын хуваарилалт” гэснийг “урамшууллаас малчны зөвшөөрлийг үндэслэн хуваарилсан хөрөнгө” гэж өөрчилж, 17.2.5 дахь заалтыг хасаж, 17.7 дахь хэсгийн “хоршоо,” гэсний дараа “нөхөрлөл, компани,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал хураалт. 51,3 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 19 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Сууцгаагаарай. Санал дэмжигдсэнгүй. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд горимын санал гаргая.

Н.Энхболд: Их олон санал хураагаад байсан энэ аппарат нь жоохон гацаад байх шиг байна. Минийх би уг нь дэмжсэн чинь эсрэг гарчихлаа. Санал хураагаад хүчингүй болгоод, дахиад санал хурааж өгөөч даргаа.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболдын гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Адьшаа гишүүн саналаа өгөөрэй. 53,8 хувиар санал дэмжигдлээ. Санал хүчингүйд тооцсон. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Үндсэн санал хураалтыг явуулъя, санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 21 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

21 дүгээр зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

“21.1.Энэ хуулийн 5.2.9 дэх заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.

21.2.Энэ хуулийн 16 дугаар зүйлийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,4 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал байна. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “мал аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх” гэснийг мөн хэсгийн “бүтээмж бүхий” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “, чадваржуулах, оролцоо идэвхийг нэмэгдүүлэх, тогтвортой, чанартай амьдрах хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэснийг, 5.1.7 дахь заалтын “мал аж ахуй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд” гэснийг, 5.2.2 дахь заалтын “малчин өрхийн амьдралын чанарыг дээшлүүлэх үүднээс” гэснийг, 5.2.6 дахь заалтын “малчид жил тутам” гэснийг, 5.2.9 дэх заалтын “Тайлбар: Энэ заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн “батлан” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “, цахим малчныг хөгжүүлнэ” гэснийг, 16.5.1 дэх заалтын “байгаль цаг уурын нөхцөлийг хангахуйц” гэснийг, 16.5.9 дэх заалтын “, түүхий эд, бүтээгдэхүүний чанарын үнэлгээ хийлгэх” гэснийг тус тус хасах.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “малчны үйл ажиллагаатай холбогдсон бусад” гэснийг “эдгээр хуультай нийцүүлэн гаргасан” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “байгаль цаг уурт” гэснийг “уур амьсгалын нөхцөлд” гэж, 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын “сайжруулах” гэснийг “хамруулж, дэмжлэг” гэж, 5.2.4 дэх заалтын “үүднээс” гэснийг “зорилгоор орон сууцны” гэж, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “, үнийн үнэлгээг тогтоож,” гэснийг “олгох замаар” гэж, 10.5 дахь хэсгийн “үржлийн ажлыг” гэснийг “үржүүлэг, технологийн

ажил, үйлчилгээг” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтын “ашигийн төлөө байгууллага” гэснийг “нөхөрлөл, хоршоо, компани.” гэж, 11.3 дахь хэсгийн “Компанийн тухай болон Хоршооны тухай хуулиар зохицуулагдана.” гэснийг “холбогдох хуулиар зохицуулна.” гэж, 11.4.7 дахь заалтын “байгаль орчны” гэснийг “уур амьсгалын өөрчлөлтийн” гэж, 17 дугаар зүйлийн 17.2.4 дэх заалтын “малчны, малчны бүлгийн” гэснийг “энэ хуулийн 11.1, 11.1.2, 11.1.3-т заасан этгээдийн” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “малын тоо толгойн албан татварын орлогыг төвлөрүүлэх сан” гэснийг “малчны хөгжлийн сан” гэж, 18.1.3 дахь заалтын “орон нутгийг хөгжүүлэх” гэснийг “орон нутгийн хөгжлийн сан” гэж, 18.1.4 дэх заалтын “сумын хоршооны” гэснийг “хоршоо хөгжүүлэх сан” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал хураалт гишүүдээ. 51,3 хувиар санал дэмжигдлээ. Дараагийн санал хураалтыг явуулъя.

Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. Нэг.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёоллыг танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.43, 6.64 дэх заалтын “15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт” гэснийг “15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 13.11 дүгээр зүйлд” гэж тус тус өөрчилсүгэй. Санал гаргасан

ажлын хэсэг, санал хураалт. Гишүүдээ санал хураалт. 56,4 хувиар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёолоор санал хурааж дууслаа. Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлээ.

13.12 цаг

Тав.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Дараагийнхаа асуудалд орёё. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулъя. Ажлын хэсгийг оруулаарай.

Хэлэлцээж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун, ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Бямбын Болдбаатар, Мал эмнэлгийн ерөнхий газрын Статистик, дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Сандагийн Батхуяг нар оролцож байна.

Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт аваад дууссан байна. Санал хураалтыг явуулна. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн дараах зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. БОХХАА-н

байнгын хороо дэмжсэн саналууд байна. Мал, амьтан, мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийн талаарх саналуудыг, санал хураалтуудыг явуулна.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “мал амьтны эм” гэсний дараа “/цаашид “эм” гэх/” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар. Санал хураалт. Санал гаргах уу? Учрал гишүүн гарах юм уу, хэн гарах юм бэ? Учрал гишүүн санал гаргая. Энэ Малчны тухай хууль дээр чинь Учрал гишүүнээ Цахим малчин гэсэн тийм нэр томъёонууд ороод ирсэн байна лээ. Таны бас эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зүйл байна лээ шүү. Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал горимын санал гаргая.

Н.Учрал: Сая би дэмжиж саналаа өгсөн, тэгсэн дэмжигдээгүй байна. Тэгээд дахин санал хураалт явахыг хүсье. Улсын Их Хурлын гишүүн Учралын гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал дэмжигдсэнгүй. Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа горимын санал гаргая. Адьшаа гишүүний микрофоныг өгөөрэй.

Ш.Адьшаа: Миний төхөөрөмж ажилласангүй, дахиж санал хураалгаж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаагийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Сая яасан гацаад байна уу? Энэ төхөөрөмжүүд гацаад байх шиг байна тийм ээ? Тийм байна. Санал хураалтыг хүчингүйд тооцчихъё, сая төхөөрөмжүүд ер нь бүгд ажиллахгүй байгаад байна. Санал хураалтыг дахин явуулъя. Техникийн хэлтсийнхэн, Хурал зохион байгуулахынхан анхааралдаа аваарай. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт явуулъя. Адьшаа гишүүний санал. Энэ яагаад ажиллахгүй байгаад байна вэ? Энэ

төхөөрөмжүүд гацаад байна. Адьшаа гишүүний гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Сая техник бэлэн болсон байна. Санал хураалт гишүүдээ. 56,4 хувиар санал дэмжигдлээ.

Саналын үндсэн томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт явуулъя. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж горимын санал гаргая.

Б.Пүрэвдорж: Би яг нөгөө нэг юу дарахаас өмнө хуруугаа дарчихаар энэ гацчихдаг юм. Санал хураалт явахаас өмнө, тэгээд гацчихлаа. Тийм учраас миний би уг нь дэмжсэн юм. Тийм учраас дахин санал хурааж, хүчингүй болгож өгөх санал хурааж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. 55,3 хувиар санал дэмжигдлээ. 2 төслийн 4 дүгээр зүйлийн, сая юу яасан, хүчингүйд тооцсон санал хураалт сая яагдаад дэмжигдсэн. Одоо саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.5, 4.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.1. “эм” гэж мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчин эмгэгийг оношлох, эмчлэх зориулалттай, эм судлал, эмнэлзүйн болон бусад сорилт туршилтаар үйлдэл нь нотлогдсон нийлэг болон амьтан, ургамал, эрдсийн гаралтай тодорхой хэлбэр, тун, хэмжээтэй бүтээгдэхүүнийг;”

“4.1.5. “оношлуур” гэж мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, мал, амьтан, тэдгээрийн

гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болон орчны сорьцын шинжилгээнд хэрэглэдэг тодорхой тун, хэмжээ, найрлага, өвөрмөц чанар, идэвх бүхий бүтээгдэхүүнийг;”

“4.1.8, “эмийн туслах бодис” гэж эмийн гол үйлдлийг дэмжих, сөрөг нөлөөлөл, нөлөөг бууруулах, амт, үнэрийг дарах ба нэмэгдүүлэх, эмийг хэлбэржүүлэх, найрлагыг тогтворжуулах, үйлдлийн ба хадгалах хугацааг уртасгах зэрэгт шаардлагатай бодисыг;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар, санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “мал, амьтны эмийн зөвлөл” гэсний дараа “/цаашид “Зөвлөл” гэх/” гэж, 5.3.1 дэх заалтын “мал, амьтны эм,” гэсний дараа “биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл,” гэж тус тус нэмж, 5.4 дэх хэсгийн “мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар, санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “улсын бүртгэлд” гэснийг “Мал, амьтны эмийн бүртгэлд /цаашид “бүртгэл” гэх/ гэж, 6.18 дахь хэсгийн “мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.3.8, 6.3.9 дэх заалт нэмэх:

“6.3.8.оношлуур;
6.3.9.тэжээллэг чанартай тэжээлийн нэмэлт.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар, санал хураалт. 56.4 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 6 дугаар зүйлийн 6.8.10 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар, санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 6 дугаар зүйлийн 6.8.10 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар, санал хураалт. Дараагийн санал хураалтыг явуулъя.

6.Төслийн 8 дугаар зүйлийн 8.4.13 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Аубакир гэсэн байна, санал хураалт. 56,4 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн Гуравдугаар бүлэг болон 10 дугаар зүйлийн гарчгийн “тэжээлийн нэмэлтийн” гэснийг “тэжээлийн нэмэлт, оношлуурын” гэж өөрчилж, 10.2.3 дахь заалтын “мал, амьтны эмийн сан” гэсний дараа “/цаашид “эмийн сан” гэх/” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Аубакир, санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Аубакир, санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 15.12.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас импортлох, экспортлох энгийн зөвшөөрлийг авна.”

“15.12.6.хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл, горим зөрчсөн нь тогтоогдсон;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Аубакир, санал хураалт. 51,3 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дахь хэсгийн “8.1 дүгээр зүйлийн 12.12,” гэснийг “8.1 дүгээр зүйлийн 12.12-т заасан тусгай зөвшөөрлийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,” гэж өөрчилж, 17.2, 17.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.2.Үйлдвэрлэх зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг зөвшөөрөл хүссэн өргөдлийн хамт мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ;”

“17.3.Импортлох зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг зөвшөөрөл хүссэн өргөдлийн хамт мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал. Энэ дээр үү, санал хураалтыг түдгэлзүүлээ. Энэ дээр Батжаргал гишүүн үг хэлэх юм уу? Байнгын хороон дарга Жигжидийн Батжаргал.

Ж.Батжаргал: Тийм, энэ саналын томъёолол дээр эргэж харах зүйл гарсан. Дэд ажлын хэсэгтэйгээ ярьсан. Тийм учраас гүйцээн боловсруулах чиглэл авчихмаар байна даргаа.

Л.Мөнхбаатар: Төслийн 10 дахь санал хураалт буюу төслийн 17 дугаар зүйл дээр бүхэлд нь гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Байнгын хороон дээрээ яриарай.

11.Төслийн 17 дугаар зүйлийн 17.3.3, 17.3.4, 17.4.4, 17.8.3 дахь заалтыг хасах. Энэ чинь уялдаатай заалт уу Батжаргал гишүүнээ? Уялдаатай бол хамтад юу, холбоо уялдаагүй юу өмнөх 17 дугаар зүйлтэй чинь? 17 дээр чинь бид нар чиглэл өгчхөөд байгаа шүү дээ, гүйцээн боловсруулах чиглэл. Хураачих юм уу? Санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсгийн “Мал эмнэлгийн эмийг” гэснийг “Эм, тэжээлийн нэмэлтийг” гэж өөрчилж, доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“20.11.Мал, амьтны эрдэс бодисын дутлыг гэдэг юм уу тийм ээ? Дутал гэсэн ийм үг нэр томъёо байгаа юм уу? ингэд хуульд орж байгаа учраас энэ чинь хууль зүйн нэр томъёо болоод цаашаа явах нь байна шүү дээ дутал гэсэн үг байгаа юм байна. Дутлыг, нэр томъёо дээрээ бас анхаараарай. Дутлыг тодорхойлох тандан судалгааг энэ хуулийн 20.12-т заасан байгууллагын захиалгаар сургалт, эрдэм шинжилгээний байгууллага таван жил тутамд бүсчлэн хийнэ.

20.12.Энэ хуулийн 20.11-д заасан тандан судалгааг үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрдэс бодисын дутлыг нөхөх, хэрэглэх талаар зөвлөмж гаргана.

20.13.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь энэ хуулийн 20.12-т заасан зөвлөмжийн дагуу шаардлагатай эрдэс бодисыг агуулсан эм, тэжээлийн нэмэлтийг хэрэглэнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, санал хураалт. Гишүүдээ саналаа өгөөрэй. Санал дэмжигдсэнгүй. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд горимын санал гаргая.

Н.Энхболд: Сая би уг нь санал өгсөн чинь юу эсрэг гарчих юм даргаа, дахиад хүчингүй болгоод дахиад нэг санал хураалгаад байхаач.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболдын гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Улсын Их Хурлын гишүүн Эрүүл мэндийн сайд Чинзориг

суудалдаа сууж саналаа өгье. Гишүүд анхааралтай саналаа өгөөрэй. Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа горимын санал гаргая.

Ш.Адьяа: Миний микрофон гацчихлаа, төхөөрөмж гацчихлаа. Тийм учраас энэ Болорчулуунд нэг л явдал байна. Тийм.

Л.Мөнхбаатар: Адьяа гишүүний гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай саналаа өгөөрэй. 60 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалт хүчингүйд тооцогдсон. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт. Санал хураалт явуулъя. 57,5 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 22 дугаар зүйлийн 22.4.4 дэх заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, санал хураалт. 56,4 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.1.Энэ хуулийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, санал хураалт. 65,8 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал хурааа. 1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “хэлбэр,” гэсний өмнө “гол үйлчлэгч бодис,” гэж, 6.7.5, 6.8.5 дахь заалтын “хорон” гэсний дараа “, эсхүл хоруу” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “үр дүнгийн” гэсний дараа “харьцуулсан” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “хүртээмжтэй” гэсний дараа “тогтвортой” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “бөөнөөр ханган нийлүүлэх” гэсний өмнө “эмийн санд” гэж, 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтын

“түдгэлзүүлэх,” гэсний дараа “цуцлах” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.3.8 дахь заалтын “тайланг хэлэлцэж, зөвлөмж өгөх” гэснийг “тайлантай танилцах” гэж, 5.6 дахь хэсгийн “төсөвт тусган санхүүжүүлнэ” гэснийг “төсвийн төсөлд тусгана” гэж, 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтын “тусламжаар импортлох” гэснийг “тусламж, хандивын” гэж, 6.3.2 дахь заалтын “эм” гэснийг “бүтээгдэхүүн” гэж, 6.4 дэх хэсгийн “зориулалтыг зааж” гэснийг “зориулалт, жороор олгох эсэхийг зааж” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2.7 дахь заалтын “үйлдвэрлэсэн эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн” гэснийг “бүтээгдэхүүний” гэж, 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “хүн эмнэлгийн зориулалт бүхий” гэснийг “хүний” гэж, 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсгийн “лиценз” гэснийг “энгийн зөвшөөрөл” гэж, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт импортлох, экспортлох энгийн зөвшөөрөл олгохдоо” гэснийг “Энгийн зөвшөөрөл хүсэгч нь” гэж, 17 дугаар зүйлийн 17.8.1 дэх заалтын “бүрдүүлж, хэрэгжилт, зарцуулалтад нь хяналт тавих” гэснийг “бүрдүүлэх” гэж, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “журам, эмийн жагсаалтыг” гэснийг “журмыг” гэж, 20.5 дахь хэсгийн “бүртгээж, улирал бүр цахим мэдээллийн санд оруулна” гэснийг “бүртгэнэ” гэж, 20.7 дахь хэсгийн “сөрөг үйлдэл болон хэрэглээний горимыг” гэснийг “гаж нөлөө, хэрэглэх зааврыг” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалтын “эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг” гэснийг, 11.2.2 дахь заалтын “эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх,” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “мал эмнэлгийн байгууллага,

мал, амьтны эмийн санд эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг” гэснийг, 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага,” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.10.2 дахь заалтын “хамтын ажиллагааны болон төслийн” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.3.5 дахь заалтын “эмнэлгийн хэрэгсэл, оноилуур, багаж, тоног төхөөрөмжийн олон улсын болон тухайн орны чанар баталгаажилтын болон гарал үүслийн гэрчилгээ, хэрэглэх заавар” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “жил бүр шинэчлэн тогтоож, өөрийн орны судалгааны дүн болон” гэснийг, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “жил бүр шинэчлэн” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.3.7 дахь заалтын “үйл ажиллагаа эрхлэх ажлын байрны” гэснийг тус тус хасах.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, шилэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, санал хураалт. 60,5 хувиар санал дэмжигдлээ.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг явуулъя.

1.Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлээ.

13.38 цаг

Зургаа.Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийнхаа асуудалд оръё. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ж.Сүхбаатар: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн. ТББХ 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх

ТББХ-ны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Байхгүй байна. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар ТББХ-нд шилжүүлээ.

13.40 цаг

Долоо. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяа нарын 4 гишүүнээс 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийнхаа асуудалд орёе. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Төслийн талаарх, төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Адъяа нарын 4 гишүүнээс 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн билээ. Тус тус Байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн

39 дүгээр зүйлд заасан журмын дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэндээ танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг өөрчлөн найруулах болон дагаж мөрдөх хугацааг өөрчлөх талаар зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Байнгын хороо Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэж, санал хураалт явуулж олонхын санал авсан саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэндээ хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ, Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Жаргалмаа гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураая. Зарчмын зөрүүтэй 2 санал байна. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. ТББХ дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуульд доор дурдсан агуулгатай 10.20 дахь хэсэг нэмсүгэй:

10.20.Энэ хуулийн 10.19-д заасан жороо морины уралдаанд морио уяж, уралдуулсан уяачийн амжилт нь энэ 10.4, 10.5, 10.6-д заасан болзлыг хангасан бол уяачид мөн хэсэгт заасан цол олгоно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл зүйл.Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлээ.

13.45 цаг

Найм.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нарын 6 гишүүн 2024.05.17-ны өдөр өдөр мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийнхаа асуудалд оръё. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Ганболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Ж.Батжаргал, Д.Батлут, Ц.Идэрбат, Н.Наранбаатар, Т.Энхтүвшин нараас 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 24, 28-ны өдрүүдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн билээ.

ТББХ 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаараа дээрх хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 32.13 дахь хэсгийн цахимаар болон техник технологийн бусад хэлбэрээр хуралдаанд оролцсон бол хурлын ирцэд оруулан тооцож болно гэснийг санал хураахаас бусад асуудлаар хурлын ирцэд цахимаар оролцож болохоор, Зөвлөл 51.2 дахь хэсэгт заасан асуудлыг хэлэлцэж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанд танилцуулж болохоор, баг, хорооны иргэдийн Нийтийн анхдугаар хуралдаанаас хуралдаан даргалагчийг 2 жилийн хугацаагаар сонгох, хуралдааны даргад баг, хорооны Засаг даргын цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож болно гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед асуулт асууж, уг хэлсэн гишүүн гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүнээс гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэж, санал хураалт явуулж, зарчмын зөрүүтэй

саналын томъёоллоор болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ганболд даргад баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааа. Зарчмын зөрүүтэй 3 санал байгаа, танилцуулъя. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. ТББХ дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 32.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.13.Цахимаар хуралдаанд оролцсон бол санал хураахаас бусад асуудалд Хурлын ирцэд оруулан тооцож болно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, санал хураалт. Санал хураалтыг түдгэлзүүллээ. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд үг хэлье.

Н.Энхболд: 30 секунд. Энэ оролцсон гэдгийг нь бүртгүүлсэн гэгчхье. Тэгэхгүй болбол бүртгүүлчхээд ирцэд байгаад байж болно, яг санал хураалтад оролцож чадахгүй тохиолдолдоо, тийм орно, бүртгүүлсэн гээд уничихаарай даргаа. Би хууль санаачилсан хүний хувьд.

Л.Мөнхбаатар: “32.13.Цахимаар хуралдаанд бүртгүүлсэн бол санал хураахаас бусад асуудалд Хурлын ирцэд оруулан тооцож болно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, санал хураалт. 64 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 51.2 дахь хэсгийн “дараах асуудлаар шийдвэр гаргаж, дараагийн хуралдаанд танилцуулж болно” гэснийг “дараах асуудлыг хэлэлцэж, ирээдийн Төлөөлөгчдийн Хуралдаанд танилцуулж болно” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, санал хураалт. 56,4 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн “32.10” дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.10.Баг, хорооны ирээдийн Нийтийн анхдугаар хуралдаанаас хуралдаан даргалагчийг 2 жилийн хугацаагаар сонгоно. Хуралдаан даргалагч нь хуралдааныг удирдан явуулах, хуралдааны шийдвэрийг албажуулан гарын үсэг зурах, дараагийн хуралдааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангах үүрэгтэй. Хуралдааны даргад баг, хорооны Засаг даргын албан тушаалын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож болно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлээ.

13.51 цаг

Ес.Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай

Дараагийнхаа асуудлыг хэлэлцье. Болоогүй, одоо 2 асуудал байгаа. Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох асуудлыг хэлэлцье. Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1 дэх хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Дэлэгийн Загджавыг Монгол Улсын Ерөнхий аудитораар томилуулах саналыг санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Д.Загджав нь Нийгмийн аюулаас хамгаалах яамны Цэргийн дээд сургууль, Төрийн захиргааны удирдлагын хөгжлийн институт, Төрийн удирдлагын академи, ОХУ-ын Новосибирск хотын Эдийн засгийн удирдлагын улсын академи, ОХУ-ын Эрхүү хотын Зам харилцааны улсын их сургуулийг тус тус төгссөн. Эрх зүйч, бизнесийн удирдлагын менежер, эдийн засгийн удирдлагын менежер, төмөр замын инженер мэргэжилтэй. Улс төрийн захиргааны докторын зэрэгтэй. Орос, англи хэлтэй. Д.Загджав нь Дорноговь аймгийн цагдаагийн хэлтэст байцаагч, Ховд аймгийн Ардын аймгийн Ардын Депатутатын Хурлын гүйцэтгэх

захиргааны дэргэдэх Хууль зүйн арбитрын хэлтэст ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга, Ховд аймгийн Шүүхэд шүүхийн гишүүн, Алтай-Интернэйшнл компанид ерөнхий захирал, Монголын ардчилсан социалист оюутны холбоонд ерөнхийлөгч, Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг дарга, Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монголын Энхтайван найрамдлын байгууллагын Ерөнхийлөгч, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэд сайд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргаар тус тус ажилласан туршилагатай. 2023 оноос эхлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Баделхан Төрийн аудитын байгууллага нь төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх хамгийн чухал газар тул эрх зүйч, эдийн засагч, мэргэжилтэй, төр захиргааны бүх шатын байгууллагад анхан шатаас нь эхлэн ажилласан туршилагатай хүн томилогдсоныг дэмжиж байгаа бөгөөд харин Ерөнхий аудиторын албан үүргийг гүйцэтгэхдээ аудиторуудаа чадавхжуулах, ашиг сонирхлоос сонирхлын зөрчлөөс ангид байх, шударгаар ажиллах нь зүйтэй гэж санал гаргасан болно. Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93 дахь хэсгийн нэгд заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсныг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай асуудлаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Пүрэвдорж гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлт, эрх бүхий албан тушаалтны саналтай холбогдуулаад нэр дэвшигчээс асуулт асуух, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна, байхгүй байна. Сарангэрэл гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар асуултаа асууя.

Ж.Сүхбаатар: Би асуултаас илүү бас анхааруулаад нэг юм хэлчихье гэж бодож байгаа. Энэ ирсэн бичгийг харах юм бол одоо түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа нөхөөд томилохоор жил хүрэхгүй хугацаанд ажиллах юм байна л даа өмнөх даргын үлдэж байгаа хугацаатай. Тэгээд үзэхээр ирэх жилийн хавар ингээд хугацаа дуусах юм байна. Ямар ч байсан зохих шаардлага шалгуур хангасан гээд ингээд Загджав гишүүнийг 8 онд хамт сонгогдоод ажиллаж байсан учраас би гишүүнийг гээд хэлчихье. Загджав гишүүнийг ингээд оруулж ирж байгаа юм байна. Тэгэхээр би төрийн ажлын санал шүүмжлэл, зовлон жаргалыг болбол өөрөө бол сайн мэднэ.

Тэгэхээр хамгийн гол анхаарах юм нь түрүүн Баделхан гишүүн ч гэсэн бас Байнгын хороон дээр хэлсэн байна. Энэ Үндэсний аудитын газрын боловсон хүчний бодлогын асуудал бас их анхаарлын төвд бол байх шиг байгаа юм. Хүмүүсийн хувьд хамгийн их яригддаг асуудал бол энэ боловсон хүчний асуудал байгаа. Тэгэхээр яг энэ сонгуулийн цикл таарч байна. Тэгэхээр та болбол энэ боловсон хүчний асуудал дээр бас ямар зарчим баримтлах вэ? Ер нь тогтвортой, мэргэшсэн байх ёстой. Сүүлийн үед бол бас нэг шүүмжлэлүүд бас чих дэлсээд л байсан. Боловсон хүчний хувьд бас их тийм нөгөө цус ойртоно гэдэг шиг бас ингээд хэтэрхий ойр төрөл хамаарал ингээд үүсчихсэн юм яригддаг. Тэгэхээр энэ боловсон хүчний асуудал дээр бол их тийм болгоомжтой сонгуулийн циклүүд явж байна. Янз бүрийн дүгнэлтүүд гарч байгаа.

Тэгэхээр түрүүний сая дүгнэлт дээр гардагтай адилхан нэг асуудал байгаад байгаа л даа. Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ болбол сая энэ сүүлд бол Нийтийн албаны ашиг сонирхлын зөрчлийн хуульд бол өөрчлөлт оруулсан байгаа. Их Хурлын гишүүд, Засаг дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нар гээд төрийн өндөр албан тушаалтнуудыг хамаарал бүхий тэр этгээдүүдийг нь тендер төрөөс тендер авах, тодорхой албан тушаалуудад томилохыг нь бол хязгаарласан байгаа. Тэгэхээр энэ утгаараа болбол энэ Ёс зүйн, ашиг сонирхлын зөрчлийн хуулийн асуудлыг бол ингээж мөрдөж ажиллаж эхэлнэ. Тэгэхээр аудитын байгууллага өөрөө дотроо ашиг сонирхлын зөрчлийн асуудлуудыг зохицуулах асуудал дээр бас анхаарал хандуулмаар байгаа юм.

Ер нь Монголд болоод байгаа асуудал дээр маш их яригдаж байгаа юм болбол компани тодорхой том компаниуд гэдэг юм уу, тодорхой улс төрийнхөн гэдэг юм уу, тодорхой ашиг сонирхлоороо тодорхой хүмүүсийг чухал, чухал албан тушаалд, ялангуяа хууль хяналтын гэдэг шиг ийм хяналтын байгууллагуудад шургуулдаг. Тэгээд энэ нь ч хүмүүсийн дунд яригддаг. Тэгэхээр Үндэсний аудитын газрын хувьд бол тэр чадавхжуулснаас гадна дотроо энэ ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг болбол нэлээн сайн зохицуулж, боловсон хүчнийхээ асуудал дээр ийм анхаарах ийм шаардлага байгаа.

Тэгээд ямар ч байсан ингээд аудитын байгууллагаас гарч байгаа маш олон дүгнэлтүүд гарч байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр явж, явж ер нь Монголд бол одоо нэг л юм дутааж байна шүү дээ. Хууль, журам дутахаасаа илүүтэй тэгээд чадварлаг боловсон хүчин хэрэгтэй байгаа. Тэгээд энэ дотроо нэмээд энэ ашиг сонирхлын зөрчлийн асуудал байгаа. Мэдээж өөртэй чинь холбоотойгоор ингээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх дээр ажиллаж байсан, Ерөнхий аудиторын үүргийг орлон гүйцэтгэж байна гээд ингээд асуудлууд

хүмүүс ярьдаг, санал, шүүмжлэлүүд байж байгаа байх. Энэ дээр бас тусгаад ажиллах тал дээр бас анхаарах ёстой шүү.

Тэгээд энэ байгууллага болбол Үндсэн хуульд заагдсан хэмжээний сүүлд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр болбол их чухал байгууллага болж ингээж тавигдсан байгаа. Одоо төлөвшилийнх нь дараачийн үеийн шинэ шатны хөгжил явж байгаа. Тэгэхээр энэ хөгжлийнх нь энэ голдирлыг нь болбол бас алдагдуулахгүй байхад анхаарах ёстой шүү гэж бас хэлмээр байгаа юм.

Л.Мөнхбаатар: Сүхбаатар гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл үг хэлнэ.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Үндсэндээ манай Баделхан гишүүн, Сүхбаатар гишүүн нарын хэлж байгаатай би санал нэг байгаад байгаа юм. Боловсон хүчний асуудал дээр ер нь аудитын байгууллага анхаарах ёстой болсныг харьяа байгууллагын хувьд Улсын Их Хурлын гишүүд бол энэ дээр анхаарал хандуулж байгааг би Аудитын ерөнхий газрын даргад нэр томилуулахаар орж ирж байгаа Загджав дарга маань анхаарах хэрэгтэй байх гэдгийг давтаад хэлчихье.

2-т нь ерөөсөө ганцхан санаа л хэлэх гээд байгаа юм. Манай аудитын байгууллага бол ерөнхийдөө сайн ажилладаг, дүгнэлтүүд гаргадаг, зөрчил илрүүлдэг. Амьдрал дээр харахад хамгийн гол нь энэ чиглэлээр авч байгаа арга хэмжээ, тооцож байгаа хариуцлагын асуудал төдийлөн хангалтгүй байгаа гэж би үздэг. Тийм болохоор энэ асуудал дээр би Загджав даргыг бас шинээр томилогдож байгаа даргын хувьд илүүтэй бас анхаарч ажиллавал ямар вэ. Тийм шаардлага байгаа шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

Тэгээд манай Загджав дарга бас Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байсан, ШШГЕГ-ын даргаар ажиллаж байсан. Улс төрийн болон төрийн ажлын

турилагатай хүн учраас бол би энэ аудитын байгууллагад бол бас шинэчлэл хийх, саяын гишүүдийн ярьж байгаа асуудлууд дээр бас арга хэмжээ авахад бол бүрэн бололцоотой гэж бодож байна. Тэгээд дэмжиж байна. Амжилт хүсье.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гэхдээ ингэе туршилтын нэг санал хураалт явуулчихъя, нөгөө нууцаар явуулах учраас тэгэх үү? Нууцаар явуулах горим дээрээ би бэлтгэсэн үү? Гишүүд сууж саналаа өгье. 1 санал хураалт явуулчихъя. Бүртгэлийн санал хураалт нэгийг явуулаа шүү. Санал хураалтыг явуулна.

Байнгын хорооны саналаар Дэлэгийн Загджавыг Монгол Улсын Ерөнхий аудитораар томилохыг дэмжье гэсэн саналын томьёолоор нууц санал хураалт явуулъя. Санал хураалт. 61 хувиар санал дэмжигдлээ. Томилох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Ерөнхий аудитораар томилох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Тогтоолын, тогтоолыг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Ерөнхий аудитор томилох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.15 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Монгол Улсын Ерөнхий аудитораар Дэлэгийн Загджавыг өмнөх албан тушаалтны бүрэн эрхийн үлдсэн хугацаагаар нөхөн томилсугай.

2. Энэ тогтоолыг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж

мөрдсүгэй. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

14.03 цаг

Дараагийнхаа асуудалд орно. Тэрнээс өмнө нэг зүйл танилцуулаад орхий. Монгол Улсын ЗГХЭГ-аас албан бичиг ирүүлсэн байна. Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах тухай. Албан ажлын зайлиггүй шаардлагыг харгалзан Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, авлига хүнд суртлын бууруулах Шил ажиллагааны хэрэгжилтийн талаарх Ерөнхий сайдын мэдээллийн товчыг хойшлуулж өгөхийг хүсье гэсэн байна. Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Амарбаясгалан гэсэн байна. Энэ албан бичиг ирсэнтэй холбогдуулан мэдээллийг хойшлууллаа.

Арав.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийнхаа асуудалд оръё. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн. Тус байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслийг, төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сэргэлэн хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авсан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 1 саналаар Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан дахин санал хураалт явуулах талаар санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 нь дэмжсэн болно. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан зарчмын зөрүүтэй 1 саналын томъёоллоор санал хураалт явуулахад гишүүдийн дийлэнх олонх дэмжлээ. Байнгын хорооны хуралдааны эцсийн хэлэлцүүлгээр санал хурааж олонхын дэмжлэг авсан 1 зарчмын зөрүүтэй санал, чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусгаснаас гадна төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр дэс

дараалал, бүтцийн шинжтэй засвар, өөрчлөлтийг хийж, хууль зүйн техникийн талаас нь хянасан эцсийн хувилбарыг та бүхэнд тараасан байгаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 14 цаг 07 минутаас хуралдааныг даргалав.

Г.Занданшатар: Ажлын хэсэг танилцуулъя. Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, бригадын генерал Лхамсүрэнгийн Алтангэрэл, Төрийн тусгай хамгаалалтын газрын дэд дарга Долгорсүрэнгийн Тэмүүлэн хурандаа, Төрийн тусгай хамгаалалтын газрын Захиргаа, удирдлагын газрын даргын албан

үүргийг түр орлон гүйцэтгэгч, хурандаа Хурцын Ууганбат, Төрийн тусгай хамгаалалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, хошууч Эрдэнэдашийн Ариунаа, Төрийн тусгай хамгаалалтын газрын Санхүүгийн хэлтсийн дарга хошууч Чойжамцын Бат-Очир.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн “албан тушаалтныг” гэснийг “албан тушаалтан, эсхүл төр, нийгмийн зүтгэлтнийг” гэж өөрчлөх. Санал гаргасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, санал хураалт. 73,2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлээ.

14.10 цаг

Улсын Их Хурлын гишүүдээ 3 дахь өдөр хуулийн төслүүдийг эцэслэн батална. 3 дахь өдрийн өглөө бүх гишүүд бэлэн. Тэмүүлэн, байж байгаарай Ганзоригийн Тэмүүлэн, байж байгаарай, гишүүд байж байгаарай. Одоо цагаан алт. Тэмүүлэн гишүүн ямар горимын санал юм бэ? Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг хэлэлцэх асуудлын дараалалд нэмье гэсэн санал өглөө. Бас Даргын дэргэдэх зөвлөлөөр шийдсэн, тэгээд нэмчихье, нэмчих, жагсаалтад оруулчих.

Тэгээд одоо дараагийн асуудалд орно. Ирчихсэн байна ирчихсэн байна.

Арван нэг. “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Батсуурийн Даваадалай танилцуулна. Индэрт урьж байна. Төсвийн тогтвортой байдал явсан.

Б.Даваадалай: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Алсын хараа 2050 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 100 жил хөгжлийн 10 зорилт, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2020-оос 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн хүрээнд мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг байгальд ээлтэй байдлаар хөгжүүлэх, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн паркийг иж бүрэн нийлүүлэлтийн сүлжээний хамт үе шаттайгаар байгуулах, аж үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үйлдвэрлэл эрхлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхээр тусгагдсан байна.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлснээр бол уурхайн бус экспортын гол бүтээгдэхүүн болох ноос, ноолуурын боловсруулалтын чадавхыг үе шаттай ахиулж, дотоодын дотооддоо бүрэн боловсруулснаар нэмүү өртөг шингэсэн

эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын орлогыг нэмэгдүүлэх боломжтой юм. Арьс, ширний салбарт жилд дунджаар 18 сая ширхэг арьс, шир, түүхий эд нөөц бэлдэх боломжтой хэдий ч эдгээрийн 30 хүрэхгүй хувийг боловсруулан зах зээлд гаргаж, үлдсэн хувийг нь боловсруулах хүчин чадал дутагдалтай байна.

Тухайлбал 2023 онд дотоодын боловсруулах үйлдвэрүүд 3,3 сая ширхэг арьс ширэнд хагас боловсруулалт, 2,3 сая ширхэг арьс шир гүн боловсруулалт, нийт 5,5 сая ширхгийг нь боловсруулж, 12,5 сая ширхэг арьс ширийг боловсруулж чадаагүй байна. Дотоодын боловсруулах үйлдвэрүүдийн хөрөнгийн чадавх сул, арилжааны банкны зээлийн хүү, барьцаа хөрөнгийн шаардлага өндөр, түүхий эдийн зах зээлд гаднын худалдан авагчдын өрсөлдөөн их, түүхий эдийн чанар муу, бэлтгэлийн оновчтой тогтолцоо хөгжөөгүй, хууль, эрх зүйн орчин дутагдалтай зэрэг олон шалтгааны улмаас түүхий эдээ дотооддоо бүрэн боловсруулж чадахгүй боломжит орлогоо алдсаар байна.

Түүнчлэн үйлдвэрүүдэд нарийн мэргэжлийн хүний нөөц, инженер, техникийн ажилтны хангамж дутмаг, тогтвор суурьшил сул, хүний нөөцийн дутагдалтай байна. Дэлхийн зах зээлд 2023 оны байдлаар 652,9 тэрбум долларын хувцасны хэрэгцээ байна. Энэ нь 2027 онд 830,7 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байгаагаас 2 хувийг ноос ноолууран бүтээгдэхүүний эзэлж байна. Мөн дэлхийн нийтийн чиг хандлага байгальд ээлтэй үйлдвэрлэлд анхаарал хандуулж, эко бүтээгдэхүүний эрэлт хэрэглээ 2032 он гэхэд 2 дахин нэмэгдэх төлөвтэй байна. Бидэнд дэлхийн зах зээлийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээ, Монгол Улсын онцлогт суурилсан цагаан алт хэмээх малын гаралтай түүхий эдийн нөөцийг бүрэн ашиглаж, үнэ цэн шингэсэн бүтээгдэхүүн болгохын зэрэгцээ дэлхийн зах зээлд

нэвтрүүлэх, дотооддоо нэмүү өртөг бүтээх боломж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан Цагаан алт үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан журмын дагуу Засгийн газарт хүргүүлж, санал авсан бөгөөд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд дурдагдсан асуудлуудыг хүлээн авч, төсөлд тусгасан. Түүнчлэн тогтоолын төслийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын цахим хуудсанд байршуулан иргэд, олон нийтийн саналыг авсан болно. Тогтоолын төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Г.Занданшатар: Төслийн талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлого зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дэлхийн зах зээлийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлага, түүхий эдийн нөөцөд тулгуурлан цагаан алт болсон малын гаралтай түүхий эдээ бүрэн ашиглаж, үнэ цэн шингэсэн бүтээгдэхүүн болгох, дотооддоо нэмүү өртөг шингээсэн

бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан Цагаан алт хөдөлгөөнийг өрнүүлэх хүрээнд Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулжээ.

Тогтоолын төсөл батлагдсанаар нийгэмд ямар нэг сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд олон улсын стандартад нийцсэн, өрсөлдөх чадвартай, гарал үүсэл, чанарын баталгаатай, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт нэмэгдэж, малын гаралтай түүхий эдийн үнэ цэн сайжрах эрх зүйн орчин бүрдэнэ гэж үзсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганболд тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны хөтөлбөрүүдийн санхүүжилтийн эх үүсвэр нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд хэрхэн тусгагдсан мөн холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцад зохицуулалт хийн санхүүжүүлэх боломжтой эсэх талаар тодруулж, хариулт авлаа.

Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг

хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Г.Занданиатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна? Алга байна. Батжаргал больё гэсэн юм уу, больсон уу? Жигжидийн Батжаргал гишүүн дэмжиж үг хэллээ гэж ойлголоо.

Байнгын хорооны саналаар Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 56,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ протоколд тэмдэглүүлэх зорилгоор ажлын хэсгийг бас танилцуулах ёстой. Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Батсуурийн Даваадалай, ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Мэндбаярын Дондогдорж тус яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Жаргалсайханы Мөнхболд, Цэрэнпунцагийн Амгалан тус яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, Батбаярын Эрхэмбаяр тус яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, Чойжилсүрэнгийн Эрдэнэбат Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал, Түгджавын Баярсайхан Арьс шир үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал. Ажлын хэсэг, гишүүдэд баярлалаа.

Төслийг хэлэлцэх нь гэж, төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон

анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

14.18 цаг

Арван хоёр.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 4 гишүүн 2024.05.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд орно. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн нарын 4 гишүүдээс 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 5 дугаар сарын 24, 28-ны өдрүүдийн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаараа хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно. Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын

төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын 5 томъёолол байгаа. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй 5 санал байна. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. 63,4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энийг чинь хэн өргөн барьсан билээ? Гэхдээ өөрөө өргөн барьсан хууль дээр өөрөө санал гаргаж болохгүй болчихно.

2.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан Төсвийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, санал хураалт.

Найруулгын санал нэг. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 16¹.5.5 дахь заалтын “чиг үүргээ” гэснийг “энэ хуульд заасан бүрэн эрхээ” гэж, 16¹.17 дахь хэсгийн “алба нь” гэснийг “албатай байж болох бөгөөд ажлын алба нь” гэж тус тус өөрчилж, мөн хэсгийн “нарийн бичгийн” гэсний дараа “дарга” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, санал хураалт. Төсвийн тогтвортой байдлын албаныхан яагаад өөрсдөө орж ирээгүй байна вэ? Өөрсдөд нь. 63,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчлөх, агуулга зарчмыг хөндөхгүйгээр үг хэллэг, найруулгын засвар хийх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, санал хураалт. 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Одоо Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хууль тогтоомжийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар.

1.Төслийн 1 дэх заалтын ““Төрийн албаны зөвлөлийн дарга” гэсний дараа” гэснийг болон мөн заалтын ““Төрийн албаны зөвлөлийн гишүүн” гэсний дараа” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, санал хураалт. Төсвийн энэ тогтвортой байдлын алба бол маш их тусдаа бие даасан институт, хараат бус, том төсвийн тогтвортой байдлыг хангах том алба болж байгаа, болж байгаа юм. Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. Болоогүй түр байж байгаарай. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. Төсвийн

тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжжүүлээ.

14.25 цаг

Арван гурав. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараа нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын /ААНОАТ/ тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 05 дугаар сарын 24, 28-ны өдрүүдийн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах

үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бичсэн тухай танилцуулга бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжжүүлээ.

14.26 цаг

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Ингээд өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлуудаа бүгдийг нь хэлэлцэж дууссан учраас өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Өнөөдөр 16 хуулийн төслийг хэлэлцлээ, санал. Хаасныг мэдэгдье.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН:**

ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

